

**БАЙГАЛИЙН БАЯЛАГ АШИГЛАЛТЫН ИЛ ТОД,
НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ШААРДЛАГАТАЙ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН
УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛГАА**

Улаанбаатар хот, 2024 оны 12 дугаар сар

Агуулга

Агуулга	2
Зорилго	3
Арга зүй.....	3
Хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах.....	4
1. Асуудалд хийсэн дүн шинжилгээ	4
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолсон байдал	27
3. Зохицуулах хувилбаруудыг тогтоосон байдал	33
4. Хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдал	51
5. Хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийсэн байдал.....	57
6. Олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа.....	58
7. Зөвлөмж	63
Хавсралт 1. Ашигласан материал	66
Хавсралт 2. Байгалийн баялгийн ашиглалтын ил тод байдалтай хамаарал бүхий хууль тогтоомжуудийн холбогдох зохицуулалтууд	68

Зорилго

Энэхүү ажлын зорилго нь байгалийн баялаг (газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ургамал, ан амьтан) ашиглалтын ил тод, нээлттэй байдлыг хангах, нийтэд нээлттэй байх мэдээллийг тодорхойлох, түүнд олон нийтийн хяналт тавих, тайлагнах тухай хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, зөвлөмж боловсруулахад оршино.

Түүнчлэн энэхүү судалгаа нь байгалийн баялаг ашиглалтын ил тод, нээлттэй байдлыг бүрэн дүүрэн илэрхийлэхүйц зөв системтэй ойлголтыг гаргах, мөн энэхүү ил тод, нээлттэй байдлыг хэрэгжүүлэх зарчим, хамрах хүрээг тодорхойлоход чиглэсэн.

Ингэснээр Монгол Улсын нийгэм, эдийн засгийн голлох салбар болох байгалийн баялаг, тэр дундаа эрдэс баялаг уул уурхайн салбарын ил тод, нээлттэй байдлыг бүрэн дүүрэн цогц байдлаар хангагдах боломжтой болох бөгөөд төрийн болон төрийн бус байгууллагууд, төрийн болон хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд, олон нийтийн зүгээс байгалийн баялгийг ашиглах үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах эрх, үүрэг тодорхой болж, байгалийн баялгийн ашиглалтад тавих олон нийтийн хяналт болон уг салбарын засаглал сайжрах, Монгол Улсад хэрэгжиж буй хөгжлийн бодлогын олон баримт бичигт заасан хариуцлагатай уул уурхайг салбарыг бий болгох, байгалийн баялгийн үр өгөөжийг олон нийтэд тэгш, хүртээмжтэй байдлаар хүртээх үйл ажиллагаа шинэ шатанд гарах боломжтой болно.

Арга зүй

Энэхүү судалгааг Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, 13 дугаар зүйл болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ыг баримтлан хийж гүйцэтгэсэн.

Судалгаанд мэдээлэл цуглуулалт, ажиглалтын аргаас гадна харьцуулсан дүн шинжилгээ хийх аргыг голчлон ашигласан.

Энэхүү судалгаа нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого баримт бичгүүд болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын бодлогын баримт бичиг болон бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд дээр тулгуурласнаас гадна байгалийн баялаг ашиглалт, тэр дундаа эрдэс баялаг уул уурхай салбарын хариуцлага, ил тод байдал, тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн бүхий л дотоодын болон олон улсын жишиг туршлага болон стандарт, удирдамж, зөвлөмж, хөтөлбөр, зарчим, гарын авлага, аргачлал болон тайлан зэрэг ач холбогдол бүхий баримт бичгүүдийг хамруулан үзсэн. Хугацааны хувьд 2024 оны 12 дугаар сар хүртэлх хугацаанд гаргасан эх сурвалжуудаар энэхүү судалгааны цаг хугацааны хүрээ хязгаарлагдана.

Энэхүү судалгааг боловсруулах явцад байгалийн баялаг ашиглалтын ил тод, нээлттэй байдалд чиглэсэн судалгааны хомс байдал болон бүхий л төрлийн байгалийн баялгийг ашиглах харилцааг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль эрх зүйн актууд, байгалийн баялаг ашиглалтын нөхцөл байдлын талаарх тайлан, судалгаа зэргийг системчлэн багтаасан олон нийтэд нээлттэй мэдээллийн нэгдсэн сан байхгүй, харьцуулалт хийх олон улсын стандарт баримт бичгүүдийн дийлэнх нь монгол хэл дээр орчуулагдаагүй болон байгалийн баялаг гэх ойлголтын өргөн цар хүрээ зэрэг нь гол бэрхшээлүүдийг бий болгож байна.

Судалгааны ажлын даалгаварт заасан байгалийн баялаг гэх ойлголт нь маш өргөн хүрээ бүхий ойлголт бөгөөд нөхөн сэргээгддэггүй байгалийн баялаг буюу газрын хэвлий, түүний баялаг болох ашигт малтмал, газрын тос болон нөхөн сэргээгдэх баялаг буюу ой, усны нөөц, ургамал, ан амьтан зэргийг бүгдийг хамаарна. Хэдийгээр судалгааны ажлын зорилго нь бүхий л төрлийн байгалийн баялгийн ашиглалтын ил тод байдал, нээлттэй байдлыг хамрах зорилготой хэдий ч тэдгээрийг бүгдийг нэг доор ерөнхийлөн авч үзэх боломжгүй бөгөөд тэдгээрийг мөн тус тусад нь нэг бүрчлэн авч үзэж энэхүү судалгаанд багтаах арга зүйн болон цаг хугацааны хувьд боломжгүй тул энэхүү судалгааны ажил нь гол төлөв эрдэс баялаг уул уурхай салбарын ил тод, нээлттэй байдлын асуудлыг авч үзсэн.

Эрдэс баялаг уул уурхайн салбар нь үйл ажиллагааны цар хүрээ, эдийн засагт үзүүлэх үр нөлөө болон ил тод байдлыг хангах хэрэгцээ болон түүнийг хангахад шаардлагатай зохицуулалтын хувьд онцлогтой хэдий ч энэхүү салбарт хамаарах энэ судалгаанд заасан тодорхой зохицуулалтуудыг байгалийн нөхөн сэргээгдэх баялаг болох ой, усны нөөц, ургамал, ан амьтан зэргийн ашиглалтад тухайн баялгийн онцлогт тохируулан адилтган хэрэглэх боломжтой юм.

Хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах

1. Асуудалд хийсэн дүн шинжилгээ

А. Эрдэс баялаг уул уурхайн салбар ба Монгол Улсын эдийн засаг

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн өсөлтийг хангахад эрдэс баялаг уул уурхайн салбарын өсөлт 2001 оноос эхлэн онцгой үүрэг гүйцэтгэж байна. Сүүлийн 20 жилд манай улсын эдийн засаг 25 дахин томорсон бөгөөд энэхүү өсөлтөд уул уурхайн салбарын нөлөө голлох байр суурийг эзэлж байна.¹ 2010 оноос хойш уул уурхайн салбарт их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэж, томоохон төслүүд хэрэгжиж эхэлснээр, тус салбарын үйлдвэрлэл эрчимжиж, эдийн засаг дахь уул уурхайн салбарын нөлөө улам их болсон.

Энэ хэрээр тус салбарын үйлдвэрлэл, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл өсөж дотоодын нийт бүтэгдэхүүн (ДНБ)-д эзлэх уул уурхайн салбарын хувь нэмэгдсэн.² Жишээлбэл, 2000 онд уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хувь 11.3 хувь, 2006

¹ Уул уурхайн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалтын Монгол Улсын нийгэм, эдийн засагт илүүлэх нөлөө. Судалгааны тайлан. Санхүү эдийн засгийн их сургууль, УБ хот, 2024 он, 19 дэх тал.

https://drive.google.com/file/d/15RuDxB-pjiH2Wqm2W_OydjUKYcQlw_vu/view

² Өмнөхтэй ижил

онд 14 хувь байсан бол үүнээс хойш хурдацтай нэмэгдэж, 2010 оны байдлаар уул уурхайн салбар ДНБ-ний 22.4 хувийг нийлүүлэх болсон бөгөөд манай улсын экспортын 81 хувийг эзэлж байсан.³ Монгол Улсын ДНБ 2012 онд 12.3 хувиар өссөн ба үүний 8.9 пунктыг уул уурхайн салбар дангаараа эзэлж байв.⁴ Улмаар 2019 оны байдлаар Монгол Улсын ДНБ-ий 25 хувийг уул уурхайн салбар бүрдүүлж байсан бол экспортын орлогын 90 хувийг уул уурхайн салбар дангаараа бүрдүүлсэн байна.

Тэгвэл энэ тоо цаашид ч хэвээр хадгалагдаж 2023 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын ДНБ-ий 24 хувь, нэгдсэн төсвийн орлогын 29 хувь, нийт экспортын орлогын 91 хувийг уул уурхайн салбар бүрдүүлсэн байна.⁵ Мөн түүнчлэн Монгол Улс газрын тосыг харьцангуй бага хэмжээгээр олборлодог ч төсвийн орлогынхоо тодорхой хувийг тус бүтээгдэхүүнээс бүрдүүлж, орон нутгийн иргэдэд өгөөж нь очиж байдаг. Уг салбар 2023 онд 4.7 сая баррель түүхий газрын тос олборлож, 364.7 сая ам.долларын экспортын орлого олсон нь төсвийн орлогын 1.3 хувьтай тэнцэж байна.⁶

Дээрхээс харахад жил ирэх тусам эрдэс баялаг уул уурхайн салбараас улсын төсөвт төвлөрүүлж буй орлого тогтвортой өсөж, төсвийн орлогод эзлэх хувь хэмжээ нь нэмэгдсээр байна. Тухайлбал, уул уурхайн салбар 2014 онд 1 их наяд төгрөгийн татвар төлж байсан бол 2023 онд 8 их наяд төгрөгт хүрч, 8 дахин өссөн байна.⁷

Цаашид Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-д тусгаснаар уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 2030 онд 31.4 хувь, 2050 онд 25.3 хувьд хүргэхээр тооцоолсон байна.⁸

Гэсэн хэдий боловч Монгол Улсын эдийн засаг уул уурхайн салбараас хамааралтай болохын хэрээр, уг салбарын эдийн засгийн хэлбэлзэл, уг салбараас хамааралтай тодорхойгүй байдал нэмэгдсэн байна. Сүүлийн 10 гаруй жилийн эдийн засгийн өсөлт болон уналт уул уурхайн салбар, тэр дундаа

³ Өмнөхтэй ижил

⁴ Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага ба үнэлгээний аргачлал. Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, УБ хот, 2018
<https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/migration/mn/3a9d885828fa51337a66f7d13ab5754377e3cc764827c0a2988b182bb2c07cc8.pdf>

⁵ Уул уурхайн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалтын Монгол Улсын нийгэм, эдийн засагт илүүлэх нөлөө. Судалгааны тайлан. Санхүү эдийн засгийн их сургууль, УБ хот, 2024 он, 8 дахь тал.
https://drive.google.com/file/d/15RuDxB-pjiH2Wqm2W_OydjUKYcQlw_vu/view

Тухайлбал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам. “Эрдэс баялгийн салбарын статистик 2023” тайланд дурдсанаар нүүрс, зэс, алт болон бусад ашигт малтмал улсын төсвийн орлогыг бүрдүүлэхэд ихээхэн үүрэгтэй бөгөөд 2023 онд 13.9 тэрбум ам.долларын экспортын орлогыг бүрдүүлсэн нь нийт экспортын 92 хувь, төсвийн орлогын 29.9 хувьтай тэнцэж байна.

⁶ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам. “Эрдэс баялгийн салбарын статистик 2023”. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, 2023.

⁷ Уул уурхайн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалтын Монгол Улсын нийгэм, эдийн засагт илүүлэх нөлөө. Судалгааны тайлан. Санхүү эдийн засгийн их сургууль, УБ хот, 2024 он, 34 дэх тал.
https://drive.google.com/file/d/15RuDxB-pjiH2Wqm2W_OydjUKYcQlw_vu/view

⁸ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211059&showType=1>

уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өөрчлөлттэй хамааралтай байсан. Тухайлбал, манай улс эдийн засаг өндөр өсөлт үзүүлсэн 2011-2014 онуудад Оюутолгой болон Таван Толгой зэрэг томоохон төслүүд хэрэгжихтэй зэрэгцэн дэлхийн зах зээл дэх уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өндөр байжээ.⁹ Харин дэлхийн зах зээл дээрх эрдэс бүтээгдэхүүний үнэ унах үед төсвийн орлого эрс буурч, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд хүндрэл гарч, нийгмийн халамж, улс төрийн амлалтыг санхүүжүүлэх нь төсөвт асар их дарамт учруулж, эдийн засгийн бусад салбарын бүтээн байгуулалтын ажлыг сааруулж, эдийн засгийн өсөлтийг удаашруулахад хүргэж байсан байна.¹⁰ Энэ нь мэдээж эдийн засгийн тогтвортой байдал болон өсөлтөд сөрөг нөлөө үзүүлэхээс гадна жирийн иргэд, өрхийн орлого, амьжиргааны түвшинд ч мөн сөрөг нөлөө үзүүлэх нь тодорхой юм.

Эрдэс баялгийн салбар нь улсад төлж байгаа татвараас гадна бусад салбарт асар их хөрөнгө оруулалт хийж байна. Үүнийг дам нөлөө, үржүүлэх нөлөө гэж нэрлэж, ярьдаг.¹¹ Тухайлбал, эрдэс баялаг уул уурхайн салбар нь зөвхөн өөрийн салбараар хязгаарлагдахгүйгээр өсөлт болон бууралт нь барилга, тээвэр, жижиг дунд үйлдвэрлэл, санхүү гэх мэт бусад салбарт шууд нөлөө үзүүлдэг онцлогтой. Үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээ болон дотоодын хөрөнгө оруулагчдын хязгаарлагдмал санхүүгийн боломж болон үйлдвэрлэл эрхчлэгчдийн чадавх зэргээс шалтгаалан гадаадын хөрөнгө оруулалт ихээхэн хэмжээгээр шаарддаг салбар юм. Энэ хэмжээгээр гадаадын хөрөнгө оруулалт нь уг салбарт дэвшилтэт технологи нэвтрүүлэх болон инженер техникийн ажилчдын ур чадвар чадавхыг бэхжүүлж, хамаарал бүхий үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид, бэлтгэн нийлүүлэгчдийн засаглал, хариуцлагатай байдалд эергээр нөлөө үзүүлэх чухал хүчин зүйл болдог. Түүнээс гадна шууд болон шууд бусаар бий болгосон ажлын байр, төлж буй татвар хураамж нь эдийн засгийн өсөлтийг дэмжин, нийт ард иргэдийн амьдралын чанарт эерэг нөлөөлөх хүчин зүйл болдог.

Өнгөрсөн хугацаанд манай улсад орж ирсэн нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын дийлэнх буюу 70 орчим хувь нь зөвхөн энэ салбарт төвлөрсөн байна. Зөвхөн 2022 онд гадаадын шууд хөрөнгө оруулалтын 82.5 хувь нь эрдэс баялаг уул уурхай салбарт төвлөрсөн бол 2023 оны байдлаар гэхэд Монгол Улсад нийт 3.1 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт хийгдсэний 2.4 тэрбум ам.доллар буюу 79.2 хувь нь эрдэс баялаг уул уурхай салбарт орж ирсэн байна.¹²

Үүнээс үзэхэд Монгол Улсын хувьд эдийн засгийн өсөлтөд шууд болон шууд бус нөлөөллийг үзүүлдэг голлох салбар нь эрдэс баялаг уул уурхайн салбар бөгөөд манай улсын эдийн засаг энэхүү салбараас шууд хамааралтай байсаар байгаа бөгөөд харин энэхүү салбарын хөгжилд гадаадын хөрөнгө оруулалт мөн голлох үүргийг гүйцэтгэж байгаа нь тодорхой харагдаж байна. Түүнчлэн Монгол Улс нь зэсийн томоохон экспортлогч болохын хажуугаар алт, молибдени, ураны ихээхэн нөөцийг агуулж байгаа болоод нүүрсний экспортыг цаашид үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх, ураны ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, энэ талаар

⁹ Өмнөхтэй ижил

¹⁰ Эдийн засгийн аюулгүй байдал. Монгол Улсын Үндэсний статисткийн хороо. УБ хот, 2020.

¹¹ Дам нөлөөгөөр эдийн засгийн 60 илүү хувийг хангаж буй салбар ч гэж үздэг.

¹² Уул уурхайн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалтын Монгол Улсын нийгэм, эдийн засагт илүүлэх нөлөө. Судалгааны тайлан. Санхүү эдийн засгийн их сургууль, УБ хот, 2024 он, 34 дэх тал.

https://drive.google.com/file/d/15RuDXB-pjiH2Wqm2W_OydjUKYcQlw_vu/view

хөрөнгө оруулагчтай идэвхтэй гэрээ хэлцлүүдийг хийж байгаа, байгалийн баялаг олборлох болон экспортлох хүчин чадлаа нэмэгдүүлэх, тэдгээрээс олох ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилго тавьж байгаа нь энэхүү салбарын ил тод байдлыг ач холбогдлыг улам бүр чухалчлах шаардлагатайг харуулж байна.

Дээр дурдсанчлан уул уурхайн салбар нь эдийн засгийн өсөлтөд хүргэх, ядуурлыг бууруулах зэрэг олон эерэг талтай хэдий ч байгалийн нөөцийн зүй бус ашиглалт, уул уурхайн салбар дахь засаглалын алдаатай байдал нь эдийн засаг болон нийгэмд олон сөрөг үр дагавар авчрах боломжтой. Монгол Улс нь тус салбарын үр өгөөжөөс зохих түвшинд хүртэж чадахгүй байна гэх төсөөлөл түгээмэл. Ялангуяа судалгаа, дүн шинжилгээнд гэхээс илүү популист хандлагад үндэслэн уул уурхайн салбарын бодлого үе үе өөрчлөгддөг байдал хөрөнгө оруулагчдын итгэлийг сулруулж байна.¹³Тухайлбал, эрдэс баялаг уул уурхайн салбар дахь ил тод бус байдал нь засаглал, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдал, байгаль орчны тогтвортой байдал болон нийгмийн тэгш байдлыг хангахад асар их сөрөг үр дагаварт хүргэж болно.

Тухайлбал, байгалийн баялаг ашиглалтын ил тод бус байдал нь санхүүгийн хууль бус урсгалыг өөгшүүлээд зогсохгүй авлига, албан тушаалын гэмт хэргийг дэвэргэх гол шалтгаануудын нэг болдог. Жишээлбэл, төрийн холбогдох албан тушаалтнуудыг мэдээллийн ил тод бус байдлыг ашиглан хувийн эрх ашгийн үүднээс хөрөнгө оруулагч гадаадын эсхүл дотоодын аж ахуйн нэгжид хэт ашигтай, давуу эрх олгосон гэрээ байгуулах, шийдвэр гаргах зэргээр нийтийн эрх ашгийг хохироож болно. 2016 онд Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM) - гэс гүйцэтгэсэн Монголын уул уурхайн салбарын авлигын эрсдэлийн үнэлгээгээр хайгуулын тусгай зөвшөөрөл авахаас эхлээд нөхөн сэргээлт хийх хүртэл уул уурхайн амьдралын мөчлөгт тохиолдох авлигын эрсдэлийн үнэлгээг хийхэд 15 багц эрсдэл байгааг дурджээ.¹⁴

Эдгээр эрсдэлүүдийн дунд “тусгай зөвшөөрөл авах үе шатанд шийдвэр гаргах үйл явцтай холбоотой”, “компаниудаас орон нутагт үзүүлж байгаа хандив, тусламжтай холбоотой”, “ашигт малтмал ашиглах, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлантай холбоотой”, “ашигт малтмалын борлуулалттай холбоотой” зэрэг авлигын эрсдэлүүдийг дурдсан бөгөөд эдгээр эрсдэлүүд нь хууль эрх зүйн орчны дутуу зохицуулалттай холбоотой бөгөөд хариуцлагатай уул уурхайн тулгуур зарчим болох иргэдийн оролцоог хангасан зохицуулалт хангалтгүй байгааг харуулсан байна.

Эх сурвалж: Монголын уул уурхайн салбарын авлигын эрсдийн үнэлгээ. Уул уурхайн яам, Авлигатай тэмцэх газар, УБ хот, 2016.

<https://www.undp.org/mn/mongolia/publications/mongolyn-uul-uurkhayn-salbaryn-avligyn-ersdeliyn-unelgee>

¹³ Монгол Улсын гэрээний ил тод байдлын нөхцөл байдлын судалгаа. Н.Дорждарь, Н.Золжаргал. Байгалийн нөөцийн засаглалын институт, УБ хот, 2024

https://resourcegovernance.org/sites/default/files/2024-10/scoping_study_contract_transparency_mongolia-mn.pdf

¹⁴ Монголын уул уурхайн салбарын авлигын эрсдийн үнэлгээ. Уул уурхайн яам, Авлигатай тэмцэх газар, УБ хот, 2016. <https://www.undp.org/mn/mongolia/publications/mongolyn-uul-uurkhayn-salbaryn-avligyn-ersdeliyn-unelgee>

Түүнчлэн байгалийн баялгийг ашиглах талаарх ил тод бус гэрээ хэлэлцээрүүд нь тухайн гэрээ хэлэлцээрүүдийн биелэлт болон байгалийн нөөцийн ашиглалтад тавих олон нийтийн хяналтыг боломжгүй болгоод зогсохгүй байгалийн нөөц ашигласнаас олсон ашгийн зүй бус хуваарилалтыг бий болгох, хариуцлагаас зайлсхийх боломжийг бүрдүүлэх эрсдэлтэй. Хуулийн хэрэгжилт хангалтгүй улс орнуудад эрдэс баялаг уул уурхайн салбарын ил тод бус байдал нь эдгээр улсуудад энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаандаа холбогдох хууль, дүрэм, журмуудын заалтыг мөрдөхгүй байх, хууль бус үйл ажиллагаа явуулах боломжийг мөн бүрдүүлдэг.

Байгалийн баялгаар элбэг улс орнуудын хувьд байгалийн нөөцөөс олсон орлогоо зүй зохистой зарцуулаагүйгээс эдийн засгийн өсөлт нь саарах, доройтох тохиолдлууд ч их ажиглагддаг. Энэ нь байгалийн баялгийн орлогын зарцуулалтад зохих ил тод байдлыг хангаагүйгээс орлогыг зүй бусаар зарцуулах улмаар эдийн засгийн хувьд байгалийн баялгаас улам бүр хамааралтай болох зэрэг сөрөг үр дагаварт хүргэдэг. Түүнчлэн энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд ил тод бус байдлыг ашиглан орлогоо нуун дарагдуулах, татвараас зайлсхийх боломжийг бүрдүүлдэг. Түүнчлэн засгийн газрууд уул уурхайн төслүүдээс олох орлогын хэт өөдрөг төсөөлөл, таамагт суурилсан ашиггүй зээлүүдийг авч ашиглах нь тухайн төслүүдийн ил тод бус байдлаас шалтгаалан бүтэлгүйтсэн, зохих үр өгөөжөө өгөөгүй төслүүдийн улмаас эдийн засгийн хямралт ч хүргэж болзошгүй юм.¹⁵

Мөн түүнчлэн ил тод байдал хангалтгүй бол аж ахуйн нэгжүүд байгаль орчныг хамгаалах үүргээ үл хайхрах, үүний улмаас байгаль орчинд хохирол учрах, уур амьсгалын өөрчлөлтийг түргэсгэх, биологийн олон янз байдалд учрах эрсдэл нэмэгдэх төдийгүй байгаль орчны бохирдлын улмаас хохирсон болон уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд өртсөн иргэдийн эрхээ хамгаалах, хариуцлагагүй үйл ажиллагаа явуулсан, хууль тогтоомж зөрчсөн уул уурхайн компаниудад хариуцлага хүлээлгэх боломж нь хязгаарлагдмал болдог.

Үүгээр ч зогсохгүй, байгалийн баялаг ашиглалтын ил тод байдал хангалтгүй байснаар жишээлбэл уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй бүс нутаг орон нутгийн иргэдийн эрх, ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх, нууцлагдмал байдлаар шийдвэр гаргах болон энэ маягаар байгалийн баялгийг ашиглах үйл ажиллагаа нь тухайн орон нутагт оршин сууж буй иргэд болон байгалийн баялгийг ашиглах үйл ажиллагаа явуулж буй компаниуд, төрийн холбогдох байгууллагууд, засгийн газар хооронд үл ойлголцлыг нэмэгдүүлж, мөргөлдөөн гарах, зарим тохиолдолд хүчирхийлэлд ч хүргэж болдог бөгөөд мэдээллийн ил тод бус, хангалтгүй байдал нь зөрчлийг улам хурцатгадаг байна. Жишээлбэл, Уоткинс нар хийсэн судалгаа (2017) - гаар төслийн ил тод байдлын хангалтгүй байдал нь уул уурхайн үйл

¹⁵ Жишээлбэл, байгалийн баялгаараа олон тэрбум долларын орлого олж байгаа Африкийн орнууд эдийн засгийн хувьд хүндрэлтэй байгаа төдийгүй тивийн хэмжээнд нийгэм, эдийн засаг, улс төрийн хувьд хамгийн тогтворгүй байна. Тэд ядуурлыг бууруулахын тулд газрын тос, ашигт малтмалын баялгийн үр нөлөөг бүрэн хэмжээнд ашиглаж чадаагүй, ихэнх тохиолдолд ядуурал улам бүр дордсон байдалтай байна.

ажиллагаа, эрдэс баялгийн олборлолттой холбоотой нийт баримтжуулагдсан зөрчлүүдийн 68 хувьтай нь шууд холбоотой байсан болохыг дурдсан байна.¹⁶

Тухайлбал, хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, ахуй амьдралд сөрөг нөлөө үзүүлж буй нь иргэд болон улсад эдийн засгийн их хэмжээний хохирлыг бий болгохоос гадна уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй компаниудад их хэмжээний зардлыг бий болгодгийг Харвардын Кеннедийгийн Их Сургуулийн Нийгмийн Хариуцлагын Санаачилга болон Австралийн Күйнслэндийн Их Сургуулийн Уул Уурхайн Нийгмийн Хариуцлагын Институтын судлаачид хамтран судалсан байна.¹⁷ Энэхүү судалгаанд дурдсанаар компани ба орон нутгийн иргэдийн хооронд хамгийн их зөрчил үүсгэдэг шалтгаануудын дунд байгаль орчинтой холбоотой бохирдол, ус, газар, ой мод зэрэг нөөцийн өөрчлөлт, ажлын байр, татвар, орон нутгийн худалдан авалт зэрэг эдийн засгийн үр өгөөжийн тэгш бус хуваарилалт зэрэг шалтгаанууд нэрлэгдсэн байна.

Эх сурвалж: Davis, Rachel and Daniel M. Franks. 2014. "Cost of Company-Community Conflict in the Extractive Sector." Corporate Social Responsibility Initiative Report No.66. Cambridge, MA: Harvard Kennedy School.

Иймд эрдэс баялаг, уул уурхайн салбараас хамаарал бүхий эдийн засагтай манай улсын хувьд энэхүү салбарын ил тод байдал нь урт хугацаанд дээр дурдсан эрсдэлүүдээс сэргийлэх, уг салбарын эдийн засагт үзүүлэх үр өгөөж эерэг нөлөөллийг хамгаалах, уг салбарыг үр дүнтэй удирдан зохион байгуулах, мөн ул салбараас олж байгаа орлогыг зүй зохистой зарцуулах нөхцөлийг бүрдүүлэхэд нэн чухал ач холбогдолтой. Энэ нь түүнчлэн эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, урт хугацааны өсөлт хөгжлийг дэмжих, эрүүл, тогтвортой, сахилга баттай салбарыг төлөвшүүлэх, уг салбарын эдийн засагт төдийгүй нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх, хүртээмжийг өсгөх чиглэлд холбогдох талууд санаачилгатай оролцох, олборлох ажиллагааны сөрөг нөлөөллийг багасгахад чухал хувь нэмэр болно.

Цаашлаад эрдэс баялаг уул уурхайн салбарын ил тод, хариуцлагатай байдал нь уг салбарын тогтвортой байдлыг хангах гол хүчин зүйлийн нэг байх төдийгүй улмаар уг салбарын эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөллийг хадгалаад зогсохгүй эдийн засгийг төрөлжүүлэхэд түлхэц болж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, ядуурлыг бууруулан, дундаж давхарга зонхилсон нийгмийг бүтээх урт хугацааны зорилгод хүрэхэд ч чухал ач холбогдолтой. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газар нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ийг 2030 онд 12.054,0 ам.доллар, 2050 онд 38.359,0 ам.долларт хүргэх зорилго тавьсан ба үүний тулд эдийн засаг 2030 он гэхэд 2.4 дахин, 2050 он гэхэд 7.5 дахин тэлэх хэрэгцээ үүсэхээр байна.¹⁸ Энэ зорилгод хүрэх санхүүжилтийн гол эх үүсвэр нь,

¹⁶ Transparent Governance in Times of Uncertainty: Best Practices and Strategic Proposals for the Extractive Industries. Inter-American Development Bank, 2019
https://publications.iadb.org/en/publications/english/viewer/Transparent_Governance_in_Times_of_Uncertainty_Best_Practices_and_Strategic_Proposals_for_the_Extractive_Industries.pdf

¹⁷ Davis, Rachel and Daniel M. Franks. 2014. "Cost of Company-Community Conflict in the Extractive Sector." Corporate Social Responsibility Initiative Report No.66. Cambridge, MA: Harvard Kennedy School.


¹⁸ Уул уурхайн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалтын Монгол Улсын нийгэм, эдийн засагт илүүлэх нөлөө. Судалгааны тайлан. Санхүү эдийн засгийн их сургууль, УБ хот, 2024 он,
https://drive.google.com/file/d/15RuDXB-pjiH2Wqm2W_OydiUKYcQlw_vu/view

ялангуяа ойрын жилүүдэд, манай улсын эдийн засагт голлох байр суурийг эзэлж буй уул уурхайн салбар байх нь гарцаагүй юм.

Б. Эрдэс баялаг уул уурхайн салбар


2024 оны 11 дүгээр сарын байдлаар ашигт малтмалын хүчин төгөлдөр нийт 2728 тусгай зөвшөөрөл бүртгэлтэй байгаагаас ашиглалтын 1744, хайгуулын 984 тусгай зөвшөөрөл байна. Нийт тусгай зөвшөөрөлд хамаарах талбайн хэмжээ нь нийт Монгол Улсын нутаг дэвсгэрийн 4.4 хувийг эзэлж байгаа бөгөөд эдгээр тоон үзүүлэлтүүд нь 2020-2024 оны хооронд харьцангуй тогтвортой байсан нь харагдаж байна.¹⁹

1.2. АШИГТ МАЛТМАЛЫН ХҮЧИН ТӨГӨЛДӨР ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОО, 2020-2024



Эх сурвалж: <https://mrpam.gov.mn/public/pages/202/2024.11.stat.report.mon.pdf>

1.4. АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙН НИЙТ НУТАГ ДЭВСГЭРТ ЭЗЛЭХ ХУВЬ, 2020-2024



Эх сурвалж: <https://mrpam.gov.mn/public/pages/202/2024.11.stat.report.mon.pdf>

¹⁹ Ашигт малтмал газрын тосны газар. <https://mrpam.gov.mn/public/pages/202/2024.11.stat.report.mon.pdf>

Ашиглалтын нийт 1744 тусгай зөвшөөрлийн 26.3 хувь буюу 458 нь алтны шороонд орд, 17.9 хувь буюу 312 нь нүүрс, 12.8 хувь буюу 224 нь жоншны, 5.6 хувь буюу 97 нь алтны үндсэн ордны тусгай зөвшөөрөл байна.²⁰

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нийт 1755 аж ахуйн нэгж байгаагаас 1416 нь дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нийт 2187 тусгай зөвшөөрлийг эзэмшиж байж байгаа бол 100 хувь гадаадын хөрөнгө оруулалттай 248 аж ахуйн нэгж 391 тусгай зөвшөөрлийг эзэмшиж, 91 гадаадын хамтарсан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж 150 тусгай зөвшөөрөл эзэмшиж байна.

1.8. АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО, хөрөнгө оруулалтаар, 2024.XI.30

	Эзэмшигч	Тусгай зөвшөөрөл	Талбай	
	Тоо	Тоо	Га	Хувь
БҮГД	1755	2728	6,893,121.1	100%
Дотоодын аж ахуйн нэгж	1416	2187	5,479,471.1	79.5%
Гадаадын 100 % хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж	248	391	1,095,546.5	15.9%
Гадаадын хамтарсан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж	91	150	318,103.6	4.6%

Эх сурвалж: <https://mrpam.gov.mn/public/pages/202/2024.11.stat.report.mon.pdf>

В. Эрдэс баялаг уул уурхайн салбарын ил тод байдал ба хөгжлийн бодлогын баримт бичгүүд болон хууль тогтоомжууд

Хариуцлагатай, ил тод эрдэс баялаг уул уурхайн салбарыг Монгол Улсад төлөвшүүлэхэд Улсын Их Хурал, Засгийн газрын зүгээс дэмжин, бодлого төлөвлөлтийн олон баримт бичигт энэ асуудлыг тусгасан байдаг. Жишээлбэл, Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлалын 3.2.1.3-д “Ил тод, хариуцлагатай уул уурхай, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлж, түүнээс олох орлогыг ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн бие даасан хөгжлийг хангах олон тулгуурт бүтцийг бий болгох, хүний хөгжлийг дэмжиж, боловсрол, эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд зарцуулна”, 3.2.4.1-д “Уул уурхайн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлж, орлогод тавих хяналтыг сайжруулна” гэж тус тус заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.6.1-д “Газар, түүний нөөцийг зохистой, үр дүнтэй ашиглах, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод газрын харилцааны орчин бүрдсэн байна” гэж, 4.2.1-д “Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшин нэмэгдсэн байна” гэж, мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 4.1.5-

²⁰ Ашигт малтмал газрын тосны газар. <https://mrpam.gov.mn/public/pages/202/2024.11.stat.report.mon.pdf>

д “Ил тод байдал, хамтын ажиллагаанд тулгуурлан гадаадын хөрөнгө оруулалтыг татах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ” гэж, 4.2.12-т “Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа олон улсын стандарт, хэм хэмжээг чанд мөрдөнө” гэж тус тус заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.6.5-д “олборлох үйлдвэрийн ил тод байдлыг хангах” гэж, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 49-д Монгол Улсын эдийн засгийн эрдэс баялгийн салбарын үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх, эрдэс баялгийн салбарын ил тод байдлын эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах тухай хуулийн төсөл боловсруулах” гэж тус тус заажээ.²¹

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.4.1-д “төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, шилэн ажиллагааг үргэлжлүүлж, төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно” гэж, 4.2.2.3-т “Төр хувийн хэвшил, иргэний нийгэмтэй хамтран ажиллахыг эрэлхийлдэг, тэдгээрийн оролцоог шийдвэр гаргах үйл явцдаа хангаж, ил тод байдлыг бий болгосон төрийн шинэ тогтолцоог бий болгоно.” гэж тус тус заасан нь төрийн үйл ажиллагааны бүхий л чиглэлийг, тэд дундаа байгалийн баялаг ашиглалт, тэр дундаа эрдэс баялаг уул уурхай, олборлох салбарын үйл ажиллагаа, засаглалд ч ач холбогдолтой зорилтууд юм.

Дээрхээс гадна өмнө батлагдаж тодорхой цаг хугацаанд хэрэгжиж байсан бодлогын баримт бичгүүдэд ч эрдэс баялаг уул уурхайн салбарын ил тод байдлын талаар тодорхой зорилтуудыг дэвшүүлж байжээ. Тухайлбал, Монгол Улсын Улсын Их Хурлаас 2014 онд баталж, 2021 онд хүчингүй болгосон “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.3.1-д “... байгаль орчныг хамгаалах шаардлагыг хангасан, ил тод, хариуцлагатай уул уурхайн олборлох болон боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого баримтлах”, 3.3.3-д “Хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай техник, технологийг ашиглаж ил тод, хариуцлагатай уул уурхайн зарчимд нийцсэн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг дэмжинэ” гэж, мөн 2012-2016 оны Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөний 2 ба 3.2-д “Хариуцлагатай ил тод уул уурхайг төлөвшүүлнэ” гэж тус тус зааж, тодорхой зорилтуудыг дэвшүүлж байсан хэдий ч эдгээр заалтууд нь хэрхэн хэрэгжсэн нь тодорхойгүй байна.

Дээрх бодлогын баримт бичгүүдэд зааснаар “хариуцлагатай уул уурхай” болон “ил тод уул уурхай” гэх ойлголт нэр томъёог ихэвчлэн зэрэгцүүлэн хэрэглэсэн, тэдгээрийг хэрэглэсэн дараалал нь нэг мөр тодорхой бус байгаа болон сүүлийн жилүүдэд батлагдсан Монгол Улсын урт болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд дээрх ойлголтуудыг огт тусгаагүй зэргээс харахад

²¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17333392437841&showType=1>

дээрх нэр томьёонууд нь уул уурхайн салбарт хэдий нь түгээмэл хэрэглэгддэг боловч тэдгээрийн мөн чанар, хамрах цар хүрээг одоог хүртэл тодорхой болоогүй байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад эрдэс баялаг, уул уурхайн салбарт үйлчилж байгаа хууль тогтоомжууд тэр дундаа Ашигт малтмалын тухай болон Газрын тосны тухай хуульд уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн тодорхой мэдээллийг олон нийтэд ил болгох зорилго бүхий зохицуулалтууд бий боловч тэдгээр нь иж бүрэн бус төдийгүй тэдгээр зохицуулалтыг хэн хэрхэн хэрэгжүүлэх, мэдээллийн чанар, үнэн зөв байдлыг хэрхэн хангах, тухайн зохицуулалтуудын хэрэгжилтийг хэрхэн хянах зэрэг асуудлууд нь тодорхойгүйгээс гадна, ил тод байдлыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагын нэгдсэн тогтолцоо, чиг үүрэг зэргийг багтаасан цогц тогтолцоо хараахан бүрдээгүй байна.

Тухайлбал, Ашигт малтмалын тухай хууль (48 дугаар зүйлийн 48.9 болон 48.10 дахь хэсэг) -д заасан ил тод байдлын талаарх зохицуулалтууд нь тусгай зөвшөөрөл болон гэрээлэгч нь борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээ зэргийг жил бүр олон нийтэд нээлттэй мэдээлэхийг шаардаж байгаа бол Газрын тосны тухай хууль (36 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэг)-д гэрээлэгч нь дээрх мэдээллээс гадна оруулсан хөрөнгө оруулалт, гаргасан зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн урамшуулал, үйлчилгээний хөлсний хэмжээ зэргийг олон нийтэд жил бүр мэдээлэж байхаар заажээ. Дээрхээс гадна уг хуулиудын зохицуулалтууд нь тусгай зөвшөөрөл шинээр олгох болон сунгах, дуусгавах болгох зэрэг арга хэмжээний талаарх мэдээллийг нийтэд мэдээллэх төдийгөөр хязгаарлагдаж байна.

Түүнчлэн 2010 онд хийгдсэн Монгол олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын баталгаажуулалт²² тайланд дурдсанаар Ашигт малтмалын тухай хуулийн дээрх зохицуулалтыг “ОУИТБС-ын зүгээс компаниудаас мэдээлэл авах зорилгоор тэр бүр ашиглахгүй байгаа нь компаниудын гаргаж байгаа тайлангууд нь ОУИТБС-ын шаардлагад нийцэхээргүй байгаагаас харагдаж байна” гэж мөн “ОУИТБС-ын зүгээс тайлангийн маягтуудыг сайн дурын үндсэн дээр бөглөн ирүүлэхийг хүсэмжилж буй бөгөөд харин нөгөө талаас тайлангаа заавал ирүүлж байх хуулийн заалт байхгүй байгаа”²³ гэж дурджээ.

Эрдэс баялаг, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын тухай зохицуулалтуудыг 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдөр Хөрөнгө оруулалтын тухай хууль батлагдсанаар уг хуульд тусгаж, улмаар Ашигт малтмалын тухай хуульд байсан хөрөнгө оруулалтын талаарх зохицуулалтуудыг уг хуулиас хасжээ. Хөрөнгө оруулалтын тухай хуульд мэдээллийн ил тод байдал, тэр дундаа эрдэс

²² Энэхүү тайлан нь Монгол улсын ОУИТБС-ын хэрэгжилтэд хийгдсэн баталгаажуулалтын тайлан болно. Баталгаажуулалтын үйл ажиллагааг Коффи Интернейшнл Девелопмент болон Далайван Аудит компаниудын хамтарсан консорциум хийж гүйцэтгэсэн байна. 2007 оны 9 дүгээр сарын 27-нд Осло хотод болсон Олон улсын ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн гуравдугаар хуралдааны шийдвэрээр Монгол Улс 2010 оны 3 дугаар сараас өмнө баталгаажуулалт хийлгэсэн байх үүргийг хүлээсэн.

²³ Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын баталгаажуулалт (2010), 17 дахь тал. https://resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/01/13/jn8v6pzc3zdpirr4/EITI_Validation_Report_2010_Mongolian.pdf

баялаг уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтын нээлттэй байдлын талаар зохицуулалт тусгагдаагүй байна.

Түүнчлэн Цөмийн энергийн тухай хууль (16 дугаар зүйл) -д тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагаа нь ил тод, тогтвортой байх ерөнхий шаардлагыг биелүүлэх тухай заалт байгаа боловч энэхүү ил тод байдал нь хэрхэн хэрэгжих талаар тодорхой зохицуулалт байхгүй байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд (35 дугаар зүйлүүд) байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан ажиллагааг зааж, уг мэдээллийн санд газрын хэвлий болон ашигт малтмалын талаарх мэдээлэл багтаах заасан хэдий ч мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэгт “хуульд өөрөөр заагаагүй бол [байгаль орчны] мэдээллийн сан олон нийтэд нээлттэй байна” гэж зааснаас өөрөөр мэдээллийн сан дахь мэдээллийг олон нийт хэрхэн олж авах, тэдгээртэй танилцах талаар тусгайлсан зохицуулалт байхгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд зааснаар байгалийн нөөц ашиглагч нь тодорхой төлбөр төлөхөөр заасан бөгөөд уг хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгчийн мэдээллийг сум, дүүргийн Засаг дарга, орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагчийн томилсон албан тушаалтан бүртгэх бөгөөд уг мэдээлэлд иргэний нэр, иргэний бүртгэлийн дугаар, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, байршил, ашиглах хугацаа, хэмжээ, тоног төхөөрөмжийн хүчин чадал зэрэг шаардлагатай үзүүлэлтийг багтаах заажээ. Гэсэн хэдий боловч уг мэдээлэл нь олон нийтэд нээлттэй байх тухай ямар нэгэн зохицуулалт уг хуульд тусгагдаагүй байна. Түүнчлэн байгалийн нөөц ашигласны төлбөр, төлөлтийн мэдээлэл нь ил тод байх эсэх нь тодорхойгүй байна.

Төсвийн тухай хууль болон Авлигын эсрэг хуульд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах үйл ажиллагаа нь ил тод нээлттэй байх, төрийн байгууллагын бодлого боловсруулах, зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журам зэрэг нь олон нийтэд нээлттэй ил тод байхаар заасан хэдий ч уул уурхай, олборлох үйлдвэрлэлтэй холбоотой энэ талаар тусгайлсан зохицуулалт үгүй байна.

Түүнчлэн 2021 онд батлагдсан иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох үндсэн зорилго бүхий Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд мэдээлэл хариуцагч нь зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацааны талаарх мэдээллийг ил байлгах заасан. Мөн түүнчлэн хуульд хаалттай байхаар зааснаас бусад өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах зааснаас өөрөөр уул уурхайн салбарын ил тод байдлыг хангахтай холбоотой тодорхой зохицуулалтууд тусгагдаагүй байна.

Уул уурхайн салбарт үйлчилж буй хууль тогтоомжуудаас харахад Ашигт малтмалын тухай хууль батлагдсанаас хойш сүүлийн 20 орчим жилд холбогдох

хууль эрх зүйн орчинд нийгэм эдийн засгийн цаг үеийн хэрэгцээ шаардлагаас хамааран ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаатай холбоотой тодорхой өөрчлөлт шинэчлэлтүүд хийгдсээр иржээ. Гэсэн хэдий ч дээр дурдсан ойлголтууд болон хариуцлагатай уул уурхай, ил тод байдал болон олон нийтийн хяналт зэргийг зохицуулах оролдлогууд бий боловч одоогоор бүрэн хэмжээний нарийвчилсан зохицуулалт, цогц хууль, эрхзүйн орчинд бий болоогүй байна.

Уул уурхайн салбарт олборлолт, боловсруулалт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг тухайн орон нутагт хэрхэн явуулах, байгаль орчны асуудлыг ямар байдлаар шийдвэрлэх, нутгийн иргэдтэй хэрхэн харьцах зэрэгт одоогоор бүрэн хэмжээний нарийвчилсан зохицуулалт хууль, эрхзүйн орчинд бий болоогүй байна. Мөн шинээр орж ирсэн ойлголтууд болох олон нийтийн хяналт, оролцоо, цахимжуулалт, ил тод байдал зэрэг нь холбогдох хууль, эрх зүйн баримт бичгүүд дээр тусгагдаж байгаа ч эхлэлийн хэмжээнд байна гэж дүгнэж байна.

Эх сурвалж: Монголын уул уурхайн төслийн шийдвэр гаргах процессын авлигын эрсдэлийн зохицуулалтын үнэлгээ, С.Боргил, Б. Мөнхтогтох, Байгалийн нөөцийн засаглалын Институт, УБ хот, 2023

https://resourcegovernance.org/sites/default/files/documents/mongolia_regulatory_assessment_corruption_risks_mining_sector_mon.pdf

Эдгээр зохицуулалтууд нь олон улсын стандарт, санаачилгуудад заасан уул уурхай, олборлох үйлдвэрийн ил тод байдлын талаарх шаардлагатай төдийлөн нийцээгүй төдийгүй цаашид энэхүү ил тод байдлыг хангах зохицуулалтыг олон улсын стандарт, сайн туршлагад нийцүүлэн иж бүрэн цогц байдлаар нь хууль тогтоомжид тусгах хэрэгцээ шаардлага байна.

Мөн түүнчлэн уул уурхайн салбарын ил тод байдал олон нийтийн хяналт зэргээс гадна аливаа шийдвэр гаргах процессыг нарийвчлан зохицуулах, эрх мэдэлтэн албан тушаалтнуудын дур зоргыг хязгаарлах, шийдвэр гаргах үндэслэл, журмыг тодорхой болгоход чиглэсэн цогц шинэчлэл ч хэрэгцээтэй байгаа нь харагдаж байна.

Эдгээр өөрчлөлт шинэчлэлийг хэрэгжүүлэхдээ талуудын эрх тэгш оролцоог хангах тал дээр онцгой анхаарах шаардлагатай. Үүнд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга зэрэг олон талт механизмын үүрэг, цар хүрээг тэлж, салбарын аливаа бодлогын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг цаг алдалгүй хэрэгжүүлэх боломжийг хангах байдлаар мэдээллийн урсгалыг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх нь авлигын эрсдэлийг бууруулах, арилгах эхний алхам байх болно гэж үзэж байна.

Эх сурвалж: Монголын уул уурхайн төслийн шийдвэр гаргах процессын авлигын эрсдэлийн зохицуулалтын үнэлгээ, С.Боргил, Б. Мөнхтогтох, Байгалийн нөөцийн засаглалын Институт, УБ хот, 2023

https://resourcegovernance.org/sites/default/files/documents/mongolia_regulatory_assessment_corruption_risks_mining_sector_mon.pdf

Г. Эрдэс баялаг уул уурхайн салбарын ил тод байдлын хэрэгжилт

Уул уурхайн салбарын ил тод байдлыг хангах, олон нийтэд энэ салбарын үйл ажиллагааг нээлттэй болгох зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 1 дүгээр тогтоолоор Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга

(ОУИТБС) буюу **Extractive Industries Transparency Initiative (EITI)**²⁴-д нэгдэж байгаагаа дэлхий нийтэд албан ёсоор зарласан. ОУИТБС нь салбарын ил тод байдал, сайн засаглалын дэлхий нийтийн стандартыг тогтоож, орлого, төлбөр, олборлолтын хэмжээ, түүхий эдийн борлуулалт, уул уурхайн компаниудын өмчлөл, хөрөнгө оруулагчид болон засгийн газрын хоорондын харилцааг зохицуулдаг олборлолтын гэрээ зэрэг чухал мэдээллийг ил тод болгохыг компаниуд болон засгийн газраас шаарддаг.

Ингэснээр төрийн байгууллагууд болон олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниудын үйл ажиллагааг олон нийт хянах, байгалийн баялгийн орлогын оновчтой, үр ашигтай хуваарилалт, зарцуулалтыг бий болгох зорилт тавьсан нь тодорхой хэмжээгээр үр дүнгээ өгсөн байна.

Тухайлбал, Монгол улс нь ОУИТБС-ын анхны аудитын нэгтгэлийн тайланг 2008 оны 2 дугаар сард гаргасан нь 2006 онд компаниудын төлсөн болон Засгийн газрын хүлээн авсан татвар, хураамжийг хамарсан байна. Энэхүү анхдугаар аудитын нэгтгэлийн тайланг уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй тэргүүлэх 25 компаниар гаргажээ. Аудитын нэгтгэлээр 25 тэрбум төгрөгийн зөрүүг илрүүлжээ.²⁵ Харин энэ зөрүү 2014 оны тайлангаар 581 сая төгрөг болж эрс багассан байна.²⁶

ОУИТБС-ын тайлан 9 жил гарч түүний зөрүү 25 тэр бумаас 581 сая төгрөг болж буурсан хэдий ч энэ мөнгө удаа дараа ЗГ талдаа дутаж, нотлогдохгүй байгаа нь анхаарал татаж ирсэн байна. Хамгийн гол нь энэ мөнгө улсын төсөвт оролгүй алга болсон байхад ямар нэг арга хэмжээ авагдаагүй, хэн нэгэнд хариуцлага тооцоогүй явж ирсэн байна.

Эх сурвалж: Монголын уул уурхайн салбарын авлигын эрсдийн үнэлгээ. Уул уурхайн яам, Авлигатай тэмцэх газар, УБ хот, 2016. 26 дахь тал, <https://www.undp.org/mn/mongolia/publications/mongolyn-uul-uurkhayn-salbaryn-avligyn-ersdeliyn-unelgee>

Мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд Монгол олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын баталгаажуулалт тайланд ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд тулгарч буй тодорхой саад бэрхшээлүүдийн талаар дурдсан нь одоо ч ач холбогдолтой хэвээр байна. Тухайлбал, компаниудын төлөөллийн хэлснээр компаниуд нь төв болон орон нутгийн түвшинд төрөл бүрийн татвар, төлбөр төлөх шаардлагатай үргэлж тулгарч байдаг бөгөөд эдгээр нь зарим тохиолдолд хоорондоо ихээхэн зөрчилддөг бөгөөд компаниудын зүгээс Засгийн газартай харилцах өөр төрлийн харилцаагаа ч (жишээ нь гэрээ гэх мэт) олон нийтэд нээлттэй болгох боломжтой ч заримдаа Засгийн газрын зүгээс мэдээлэл гаргахгүй байх хүсэлттэй тулгардаг гэжээ. Тэдний санал болгож буйгаар ОУИТБС-ын зарчмуудыг энэхүү салбар руу чиглүүлэн өргөтгөх хэрэгтэй гэсэн байна.²⁷

²⁴ <https://eiti.org/>

²⁵ Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын баталгаажуулалт (2010), 7 дахь тал. https://resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/01/13/jn8v6pzc3zdpirr4/EITI_Validation_Report_2010_Mongolian.pdf

²⁶ Монголын уул уурхайн салбарын авлигын эрсдийн үнэлгээ. Уул уурхайн яам, Авлигатай тэмцэх газар, УБ хот, 2016. 26 дахь тал, <https://www.undp.org/mn/mongolia/publications/mongolyn-uul-uurkhayn-salbaryn-avligyn-ersdeliyn-unelgee>

²⁷ Өмнөхтэй ижил, 18 дахь тал

Мөн төрийн байгууллагуудын зүгээс ОУИТБС-д цаашид тулгарч буй шийдвэрлэх шаардлагатай дараах асуудлуудыг онцолсон байна. Тухайлбал, Монголын ОУИТБС-ын үйл ажиллагаа нь донорын санхүүжилтээс бүрэн хамааралтай байгаа тул цаашдын тогтвортой байдлын асуудал ихээхэн ноцтой буйн хажуугаар одоогоор энэхүү үйл явцыг төрийг байгууллагуудад өөриймшүүлэн хэрэгжүүлэхэд тодорхой хомсдол байсаар байгаа тухай тэмдэглэжээ. Түүнчлэн ОУИТБС-ын Ажлын хэсгээс стратегийн шинжтэй шийдвэр гаргах явдал учир дутагдалтай байгаа талаар дурдаж, жишээлбэл үйл ажиллагааны төлөвлөгөө нь үр нөлөөнд бус үйл ажиллагаанд илүү ихээр төвлөрч байгаагийн гадна аудитаар илэрсэн алдаа дутагдлыг багасгах, алдааг засварлах төлөвлөгөө байхгүй, энэ талаар үйл ажиллагаа авч хэрэгжүүлэх боломжгүй байгаа талаар дурдсан байна. Үүнээс гадна төрийн байгууллагууд ялангуяа төрийн төв байгууллагууд болон орон нутгийн түвшний төрийн байгууллагуудын харилцан холбоо, хамтын ажиллагаа сул байгаа нь мэдээлэл цуглуулах болон аудитын нэгтгэл хийхэд ихээхэн саад учруулж байна гэжээ. Жишээлбэл, ялангуяа энэ нь аймаг болон сумын түвшин дэх татвар хураамж, хандивт гарч буй мөнгөн дүнгийн ихээхэн том хэмжээний зөрүүнээс харагдаж байна гэжээ.²⁸

Уг баталгаажуулалт тайланг боловсруулахад уулзаж ярилцсан иргэний нийгмийн төлөөлөл ч мөн ижил асуудлуудыг дурдсаны дотор хууль зүйн орчин болон институцын бүтцийн асуудал байсан байна.²⁹ Тухайлбал, аудитын нэгтгэлээр илэрсэн ихээхэн хэмжээний зөрүүг магадлан тодруулах үйл ажиллагаа орхигдож байгаа, төрийн байгууллагуудын хоорондын харилцаа холбоо маш сул байгаа нь аудитын үйл ажиллагааны гол хэсэг болох нэгтгэсэн тайланг гарган өгөхөд ихээхэн саад тотгор учруулдаг, зөрүү үүссэн шалтгааныг тодруулахад саад учирч, шаардлагатай хариуцлага тооцох үйл ажиллагааны удаашралт зэрэг багтаж байгаа ба цаашид ил тод байдлын зохицуулалтад гэрээний ил тод байдлыг мөн хамруулах мөн уул уурхайн салбарт олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх шаардлагатай талаар санал гаргасан байна.

Баталгаажуулагч нарын үзэж байснаар хууль зүйн, зохицуулалтын болон байгууллага/институцын бүтэц нь ОУИТБС-ыг Монгол улсад үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээний саад тотгорыг учруулж байна гэж үзсэн байна. Гол саад тотгорууд доорх шалтгааны хувьд хууль зүйн болон зохицуулалтын бүтцийн хувьд:

- ОУИТБС-ын үйл ажиллагааг зохицуулсан, тухайлбал, лицензийн, үйлдвэрлэлийн, борлуулалтын, экспортын, хөрөнгө оруулалтын болон байгаль орчны нөхөн сэргээлтийн ил тод байдлыг хуульчилсан тусгайлсан хууль Монгол улсад байхгүй
- Ашигт малтмалын хуулиар компаниуд зарим төрлийн мэдээллээ тайлагнаж байх үүргийг үүсгэсэн цөөн тооны заалтууд зэрэг байгаа ч энэ нь ОУИТБС-ын тайлангийн маягтуудын шаардлагад бүрэн нийцээгүй

²⁸ Монголын уул уурхайн салбарын авлигын эрсдийн үнэлгээ. Уул уурхайн яам, Авлигатай тэмцэх газар, УБ хот, 2016. 18 дахь тал, <https://www.undp.org/mn/mongolia/publications/mongolyn-uul-uurkhayn-salbaryn-avligyn-ersdeliyn-unelgee>

²⁹ Өмнөхтэй ижил, 19 дэх тал

- компаниудад ноогдох хууль зүйн хүрээний ямар нэгэн үүрэг хариуцлага байхгүй
- ОУИТБС-ын тусгайлсан хуулийн төслийг боловсруулан гаргаж хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд, газрын тосны болон ураны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг тайлангаа гаргаж өгөх үүргийг бий болгох, хэрэв тайлангаа гаргаагүй болон буруу гаргасан тохиолдолд тодорхой торгууль ноогдуулах зэрэг заалтуудыг оруулах шаардлагатай
- ОУИТБС-ын маягтын дагуу мэдээллээ үнэн зөв гаргаж өгөөгүй тохиолдолд хэрэглэх ямар нэгэн хуулийн хариуцлага байхгүй
- компаниуд нь маягтуудыг олон улсын аудитын стандартуудын дагуу буюу аудитлагдсан тайлан дээрхийн адил баталгаажсан дүнг тайлагнана гэсэн хуулийн ямар нэгэн заалт байхгүй зэрэг байсан байна.

Харин тогтолцоо, ил тод байдлыг хэрэгжүүлэх бүтцийн хувьд:

- ОУИТБС-ын зарим бүрэлдэхүүн хэсгийг гүйцэтгэх үүрэг хариуцлага төрийн байгууллагуудын алинд нь ноогдож байгаа нь тодорхойгүй, эдгээр байгууллагуудад зөвхөн ОУИТБС-ын ажлыг хариуцсан байнгын ажилтан байхгүй, мөн гаргаж буй тайлан нь нямбай, цаг тухайдаа гарч буйг баталгаажуулах хэмжээний чадавх мөн бүрдээгүй
- Аудитаар илэрсэн зөрүүг нягтлан шалгах, тодруулах үүрэг хариуцлагыг аль тал хүлээх талаар мөн тодорхойгүй мөн энэхүү үүрэг хариуцлагыг зөвхөн төрийн нэг байгууллагад хариуцуулах нь ихээхэн чухал бөгөөд ингэснээр тухайн зөрүүнүүдийг цаашид нягтлан шалгах боломж байхгүй
- Компаниудын зүгээс хандив, бэлэг, мөнгөн бус туслалцаа, тусгай сангуудад төлсөн төлбөр хэмээн тайлагнаж байгаа ч харин орон нутгийн засаг захиргаа үүнийг хүлээн авсан талаараа огт тайлагнаагүй зэрэг асуудлуудыг дурджээ.³⁰

ОУИТБС-ын 2022 оны баталгаажуулалтын тайланд сонирхогч талуудын ихэнх нь ОУИТБС-ыг хэрэгжүүлэх зорилтуудад, ялангуяа олборлолтын мэдээллийг ил тод болгоход ахиц дэвшил гарсан гэж үзсэн боловч зорилтууд хараахан биелээгүй гэж үзсэн байна.³¹ 2023 оны Монгол Улсын ОУИТБС-ын тайланд дурдсанаар олборлох үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа нийт 2240 аж ахуйн нэгжээс 1178 нь цахим платформ ашиглан ОУИТБС-ын Ажлын албанд мэдээллээ ирүүлсэн нь ойрын жилүүдэд ажиглагдсан хамгийн бага үзүүлэлт гэжээ.³²

³⁰ Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын баталгаажуулалт (2010), https://resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/01/13/jn8v6pzc3zdpirr4/EITI_Validation_Report_2010_Mongolian.pdf

³¹ Validation of Mongolia (2022): Final assessment of progress in implementing the EITI Standard, 10 дахь тал <https://eiti.org/sites/default/files/2022-10/EITI%20Validation%20of%20Mongolia%20%282022%29%20-%20Final%20Validation%20report%20%28July%202022%29%20%28EN%29.pdf>

³² Mongolia EITI 2023 Annual Report. <https://eiti.org/sites/default/files/2024-02/Annual%20Progress%20Report%20of%202023%20EITI%20Mongolia%202024.pdf>

Жишээлбэл, энэхүү тайланд олборлох үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүдийн эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах ажиллагаа хангалтгүй байгаа талаар тодорхой дурджээ. 2017 онд батлагдаж хэрэгжиж эхэлсэн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг бүртгэх, мэдээллийг ил тод болгох талаар тодорхой зохицуулалт бий болсон боловч Монгол Улсын хууль тогтоомжид эцсийн өмчлөгч гэсэн нэр томъёоны дөрвөн өөр тодорхойлолт байна. 2013 оны Мөнгө угаах, терроризмтой тэмцэх тухай хууль, 2018 онд батлагдсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан тодорхойлолтууд нь ОУИТБС-ын Шаардлага 2.5-д заасан тодорхойлолтод хамгийн ойр байгаа боловч олборлох салбарт зориулсан тусгайлсан онцлог шалгуур болон босго тавьдаггүй байна. Харин 2010 оны Банкны тухай хуульд заасан бусад гурван тодорхойлолт, 2019 оны Татварын ерөнхий хууль болон 2013 оны Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиудад зохицуулж буй харилцаануудаас хамааралтайгаар эцсийн өмчлөгчийг харилцан адилгүй тодорхойлсон байдаг бөгөөд эдгээр тодорхойлолтууд нь эцсийн өмчлөгчийг тодорхойлох өөр өөр шалгуурыг ашигласан байна. Тухайлбал, Мөнгө угаах, терроризмтой тэмцэх тухай хууль болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд хуулийн этгээдийн хувь, хувьцааны 33 хувийг, Банкны тухай хуульд 5-20 хувь, Татварын ерөнхий хуульд 30 хувийг өмчилдөг этгээдийг эцсийн өмчлөгчид тооцож болохоор заасан бол Монголын ОУИТБС нь эцсийн өмчлөгчийн мэдээллийг цуглуулах, ил тод болгохдоо хуулийн этгээдийн хувь, хувьцааны өмчлөлийн 5 хувийн босгыг ашиглаж байгаа бөгөөд 2020 оны ОУИТБС-ын тайланд нийт 2263 аж ахуйн нэгжээс зөвхөн 426 нь эцсийн өмчлөгчийн мэдээллээ ирүүлсэн гэжээ.³³

Монгол Улсын Засгийн газраас 2006 онд “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачлагыг дэмжих тухай” 1 дүгээр тогтоолыг гаргаж, санаачлагыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийг төрийн болон төрийн бус байгууллага, компанийн төлөөлөлтэйгөөр байгуулан ажиллах болсноор манай улс албан ёсоор “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай” олон улсын санаачилгыг хэрэгжүүлж эхэлсэн. ОУИТБС-д байнга шинэ дэвшилт өөрчлөлтүүд гарч байгаа боловч ОУИТБС-ын хүрээнд авч үүрэг амлалтаа Монгол Улс бүрэн хэрэгжүүлэхэд хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, журам, маягт батлах зэргээр хэрэгжилтэд баримталж ирсэн өнөөгийн эрх зүйн орчин хангалтгүй байна.

Эх сурвалж: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлал. <https://mojha.gov.mn:8085/core/files/651fbf0199e06106c64200e9>

2024 оны 10 дугаар сард Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн (ББЗХ) буюу Natural Resources Governance Institute-ээс Монгол Улсын гэрээний ил тод байдлын тойм судалгааг эрхлэн гаргасан байна.³⁴ Энэхүү тайланд Засгийн газар болон компаниуд олон гэрээг ил нийтэлсэн ч холбогдох бүх гэрээг хамарсан эсэх

³³ Validation of Mongolia (2022): Final assessment of progress in implementing the EITI Standard, 47 дахь тал <https://eiti.org/sites/default/files/2022-10/EITI%20Validation%20of%20Mongolia%20%282022%29%20-%20Final%20Validation%20report%20%28July%202022%29%20%28EN%29.pdf>

³⁴ Монгол Улсын гэрээний ил тод байдлын нөхцөл байдлын судалгаа. Н.Дорждарь, Н.Золжаргал. Байгалийн нөөцийн засаглалын институт, УБ хот, 2024 https://resourcegovernance.org/sites/default/files/2024-10/scoping_study_contract_transparency_mongolia-mn.pdf

нь тодорхой бус, гэрээг ил тод болгох зохицуулалт, тогтолцоо хангалтгүй хэвээр байгаа тухай дурджээ.

Тухайлбал, ОУИТБС-ын Шаардлага нь олборлох гэрээг ил тод байлгах, олборлох төслөөс тус улс хүртэж буй үр нөлөөг нягтлах боломжийг иргэдэд өгөх зорилгоор 2021 оны нэгдүгээр сараас эхлэн бүх гэрээ, тусгай зөвшөөрлийг олон нийтэд зориулж нийтлэх шаардлагыг тавих болсон.³⁵ ОУИТБС-ын үзэж байгаагаар байгалийн баялгийн олборлолттой холбоотой гэрээг ил тод нийтлэх нь олборлох салбарын сайн засаглал, ил тод байдалд онцгой нөлөөтэй бөгөөд салбарын бүх оролцогч талд ашиг тустай. Тухайлбал, төр засгийн хувьд зохицуулалтын тогтолцоогоо бэхжүүлж, салбарт оновчтой хяналтыг хэрэгжүүлэхэд тустай бол компаниудад нэр хүндтэй холбоотой үүсэх эрсдэлээ бууруулж, бусад оролцогч талуудын итгэлцлийг нэмэгдүүлэхэд дэм болдог. Харин иргэдийн хувьд засгийн газар, компаниудаас хариуцлага нэхэх, тухайн улсад орох эдийн засгийн үр өгөөж болон бусад үр нөлөөг хянах боломжийг олгодог байна.

ОУИТБС-ын стандартад гэрээ, хэлэлцээрийг ил тод нийтлэх дүрмээс гадна тэдгээрийн тодорхойлолтыг агуулсан байдаг. Уг стандартад "гэрээ" гэдэг нь "газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын нөөцийг ашиглахтай холбогдуулан тодорхой нөхцөлүүдийг тусгасан, төр засгийн зүгээс олгосон эсхүл байгуулсан гэрээ, концесс, бүтээгдэхүүн хуваах гэрээ, эсхүл бусад гэрээний бүрэн эхийг хэлнэ" гэж заасан ба ашиглалтын болон хайгуулын гэрээний аль алийг ил тод нийтлэх шаардлага тавигдаж байгаа.

Гэрээний мэдээллийн сан болон бусад хэрэгслээр дамжуулан олон тооны гэрээг ил тод болгосон ч хөрөнгө оруулалтын гэрээ гэх мэт тухайн төсөлтэй холбоотой гол гэрээ, хэлэлцээрийг нийтлэхийг шаарддаг хууль тогтоомж байхгүй нь Монгол Улсад гэрээг ил тод болгоход тулгарч буй гол бэрхшээл юм.

Эх сурвалж: Монгол Улсын гэрээний ил тод байдлын нөхцөл байдлын судалгаа. Н.Дорждарь, Н.Золжаргал. Байгалийн нөөцийн засаглалын институт, УБ хот, 2024
https://resourcegovernance.org/sites/default/files/2024-10/scoping_study_contract_transparency_mongolia-mn.pdf

ОУИТБС-ын баталгаажуулалтын хамгийн сүүлчийн тайланд³⁶ тусгайлсан мэдээллийн портал дээр нэлээд тооны гэрээг нийтэлснээр ОУИТБС-ын холбогдох шаардлагыг ерөнхийдөө хангаж байгаа ч гэрээний ил тод байдлыг бүрэн хангахад засгийн газрын бодлого, түүний хэрэгжилтийг сайжруулах шаардлага байсаар байгааг тэмдэглэжээ. Мөн түүнчлэн Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн (ББЗХ)-ээс "Монгол Улсын газрын тос, уул уурхайн ил болоогүй гэрээнүүд" хэмээх бодлогын хураангуйг 2019 онд нийтлэхдээ олон гэрээ ил тод бус байгааг онцолсон нь одоо ч ач холбогдлоо алдаагүй байна.³⁷

³⁵ Өмнөхтэй ижил

³⁶ ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар. "Монголын ОУИТБС-ын 2022 оны Баталгаажуулалтын тайлан," 2022 оны 10 дугаар сар <https://eiti.org/documents/mongolia-2022-validation-report>

³⁷ Монгол Улсын гэрээний ил тод байдлын нөхцөл байдлын судалгаа. Н.Дорждарь, Н.Золжаргал. Байгалийн нөөцийн засаглалын институт, УБ хот, 2024
https://resourcegovernance.org/sites/default/files/2024-10/scoping_study_contract_transparency_mongolia-mn.pdf

Монгол Улсын ОУИТБС-ын Олон талт оролцогчдын бүлэг (ОТОБ)-ийн хүрээнд гэрээний ил тайлагналыг хангах тусгайлсан дэд ажлын хэсгийг 2014 онд байгуулсан нь нэн чухал алхам болсон байна. Улмаар иргэний нийгмийн байгууллагууд гэрээний ил тод байдлын санал санаачилгыг түүчээлж ирсний дотор Нээлттэй нийгэм форум (ННФ) нь Монгол Улсын Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санг үүсгэх, санхүүжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэж, энэ мэдээллийн санг³⁸ 2019 оны 4 дүгээр сарын 22-нд албан ёсоор нээснээс хойш газрын тос, уул уурхайн гэрээний мэдээллийг нэгтгэн төвлөрүүлсэн нэн чухал сан болж хөгжжээ. Гэрээний мэдээллийн санг ННФ-ын санхүүжүүлж, ажиллуулдаг. Харин ОУИТБС-ын Ажлын алба дэмжлэг үзүүлдэг байна. Гэвч гэрээг хянах тогтолцоо, хүний нөөцийн асуудлаас шалтгаалж ОУИТБС-ын нэгтгэл тайланд дурдсан болон Гэрээний мэдээллийн санд байршуулсан гэрээнүүд хоорондоо зөрүүтэй байх тохиолдлууд гардаг байна. Мөн түүнчлэн Гэрээний мэдээллийн сан дээр олон төрлийн гэрээг нийтэлж, ОУИТБС-ын тайланд эдгээр гэрээг ашиглаж, Монгол Улсын гэрээний ил тод байдлыг үнэлж, тайлагнадаг боловч компаниудад хайгуул хийх, ашиглах эрхийг олгодог үндсэн гэрээ аль нь болох, аль нь дагалдах гэрээ болох талаар тайлбар, дүн шинжилгээ хийдэггүй байна.³⁹ Мөн Мэдээллийн санд нийтэлсэн гэрээний жагсаалт бүрэн бөгөөд үнэн зөв эсэхийг нягтлах арга хэрэгсэл байхгүй, уялдаа холбоо сул байгаа нь гэрээг ил тод нийтлэх ажлын үр нөлөөг бууруулж байна.⁴⁰

Засгийн газар гэрээний ил тод байдлыг хангах талаар тодорхой амлалтуудыг өгч байжээ. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газар Нээлттэй засгийн түншлэлд оролцох замаар олборлох салбарын гэрээний ил тод байдлыг хангах хүсэл эрмэлзлээ удаа дараа илэрхийлсэн. Үүнд олборлох салбарын бүх төрлийн гэрээг ил тод болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгыг 2016-2018 оны⁴¹ болон 2021-2023 оны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрүүдэд⁴² тус тус тусгасан юм. 49 Түүнчлэн 2024-2027 оны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрт 50 гэрээний ил тод байдлыг хангах амлалтаа дахин баталгаажуулсан байна.⁴³

Дээрх судалгаанд дурдсанаар одоогоор мэдэгдэж буй бүх гэрээний зөвхөн тодорхой хэсгийг хууль тогтоомжийн дагуу олон нийтэд мэдээлэх шаардлага тавигддаг бөгөөд Монгол Улсын хууль тогтоомж болон бүх гэрээний жагсаалтыг хөтлөхийг шаарддаг ОУИТБС-ын Стандарт хоёр хоорондоо зөрүүтэй байгаа нь гэрээний ил тод байдлыг бүрэн хангахад бэрхшээл учруулж байна. Хэдийгээр Монгол Улс гэрээний мэдээллийн тусгайлсан сан ажиллуулах зэрэг янз бүрийн

³⁸ <https://www.iltodgereee.mn/>

³⁹ Монгол Улсын гэрээний ил тод байдлын нөхцөл байдлын судалгаа. Н.Дорждарь, Н.Золжаргал. Байгалийн нөөцийн засаглалын институт, УБ хот, 2024

https://resourcegovernance.org/sites/default/files/2024-10/scoping_study_contract_transparency_mongolia-mn.pdf

⁴⁰ Өмнөхтэй ижил

⁴¹ Нээлттэй засгийн түншлэл. “Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2016-2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тайлан”

⁴² Нээлттэй засгийн түншлэл. “Монгол Улсын Нээлттэй засаг түншлэлийн 2021-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тайлан,” 2022 оны 7 дугаар сарын 21. www.opengovpartnership.org/documents/mongolia-action-planreview-2021-2023/.

⁴³ Нээлттэй засгийн түншлэл. “Монгол Улсын Нээлттэй засаг түншлэлийн 2023-2027 оны үйл ажиллагааны төлөвлөгөө,” 2024 оны 1 дүгээр сарын 8. <https://www.opengovpartnership.org/documents/mongolia-action-plan-2023-2027-%20december/>

санаачилга өрнүүлж байгаа ч хууль эрх зүйн тогтолцоо нь хязгаарлагдмал, хэрэгжилт нь жигд бус байгаа нь олборлох гэрээний талаарх олон нийтийн ойлголт, гэрээний хариуцлагатай байдалд саад тотгор болж байна.

Мөн түүнчлэн Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгээс 2024 онд гүйцэтгэсэн (Natural Resources Governance Institute) “Монгол Улсын олборлох салбарын төрийн өмчит компаниудын ил тайлагналын нөхцөл байдлын судалгаа”-нд дурдсанаар “Монгол Улсын эдийн засагт голлох үүрэг гүйцэтгэж байгаа ч уул уурхайн салбарын ТӨК-иудын засаглал, ил тод байдалд олон бэрхшээл тулгарч байна.”⁴⁴

Д. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийн ил тод байдал ба холбогдох хууль тогтоомжууд

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор "Алсын Хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 6 дугаар зорилгыг “Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна” гэж тодорхойлсон.

Нөхөн сэргээгдэх байгалийн баялаг буюу ойн нөөц, ойн дагалт баялаг, усны нөөц, ургамал, ан амьтныг ашиглах үйл ажиллагаа, тэдгээртэй холбогдсон харилцааг Амьтны тухай хууль, Усны тухай хууль, Он тухай хууль болон Байгалийн ургамлын тухай хуулиар зохицуулж байна. Тус хуулиудаар байгалийн байгалийн баялаг тус бүрийн талаар мэдээллийн сантай байх ба мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглахтай холбоотой харилцааг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулжээ. Гэвч дээр дурдсанчлан тус хуулийн 7 дугаар бүлэгт заасан байгаль орчны мэдээллийн сан нь эдгээр төрлийн байгалийн баялгуудыг ашиглах үйл ажиллагаа, түүний ил тод, нээлттэй байдлыг хангахад чиглэсэн тодорхой зохицуулалт алга байна. Хэдийгээр эдгээр хуулиудад зохицуулж буй байгалийн баялгийг ашиглахтай холбоотой олгосон зөвшөөрөл нь Зөвшөөрлийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиудад заасан олгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн мэдээллийг ил тод болгох зорилго бүхий зохицуулалтуудын үйлчлэлд хамаарахаар байна. Байгалийн баялгуудыг ашиглах үйл ажиллагааны буюу зөвшөөрөл явц, төрийн байгууллага, алба тушаалтны шийдвэрүүд, зөвшөөрөл бүхий үйл иргэн хуулийн этгээдийн үйл ажиллагаа, гүйцэтгэл, тайлагнал, эдгээр баялгийг ашигласны төлбөр, татвар хураамж, тэдгээрийн зарцуулалт, байгалийн баялгийг нөхөн сэргээхэд зарцуулсан төсвийн санхүүжилтийн талаарх мэдээллийн ил тод байдлыг цогц байдлаар хангах, олон нийтийн хяналтын хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх талаарх эрх зүйн орчин байхгүй байна.

Мөн түүнчлэн эдгээр байгалийн баялаг ашиглалтын үйл ажиллагааг тодорхой хууль, дүрэм журмуудаар зохицуулж байгаа хэдий ч тэдгээрийн хэрэгжилт, тэр дундаа ил тод байдал нь хангалтгүй хэмжээнд байсаар байна. Жишээлбэл,

⁴⁴ Монгол Улсын олборлох салбарын төрийн өмчит компаниудын ил тайлагналын нөхцөл байдлын судалгаа, Н.Дорждарь, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, УБ хот, 2024 оны 7 дугаар сар. 4 дэх тал. https://resourcegovernance.org/sites/default/files/2024-10/scoping_study_extractive_sector_soe_disclosures_mongolia-mn_0.pdf

манай улсын ойн нөөцөөр баялаг аймгуудын нэг болох Сэлэнгэ аймгийн Төрийн аудитын газраас 2023 онд хийсэн нийцлийн аудитын тайланд дурдсанаар Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2021-2023 оны хооронд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг давуулан биелүүлсэн хэдий ч тухайн онуудад байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний зардалд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу зарцуулбал зохих төлбөрийн орлогын зөвхөн 23,5 хувийг зарцуулахаар төлөвлөж, баталсан байна.⁴⁵ Мөн түүнчлэн ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөлийн 35 хувь нь “Ойн менежментийн төлөвлөгөө”-г батлуулаагүй байсан⁴⁶ бөгөөд аймгийн ИТХ болон нийт сумдын 70.5 хувь нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалт огт хийгээгүй байна.⁴⁷ БОАЖЯ-наас Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг Сэлэнгэ аймаг 2021 онд 6.0 хувьтай, 2022 онд 24.0 хувьтай хэрэгжүүлсэн гэж үнэлж, дүгнэсэн байна.⁴⁸ Мөн түүнчлэн ойн сан эзэмших, мэргэжлийн байгууллагын зөвшөөрлийг авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлэх, үйл ажиллагаандаа хууль тогтоомж мөрдөхгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхгүй байх зэрэг асуудлууд нийтлэг байна.⁴⁹

Түүнчлэн 2023 онд Үндэсний аудитын газраас хийсэн байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт сэдэвт нийцлийн аудитын тайланд⁵⁰ “Монгол Улс байгалийн нөөц баялаг ихтэй хэдий ч нөөц баялгийн зохисгүй, хариуцлагагүй хэрэглээ, ашиглалтаас үүдэлтэй нөөцийн хомсдол, доройтол бий болж байна” гэж дурдаад “байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн акт, холбогдох хууль, журам хоорондоо нийцээгүй, төрийн байгууллагуудын ажлын уялдаа, хяналт сул байгаагаас хуулийн хэрэгжилт хангалтгүй байна” гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Манай улсын сэргээгдэх байгалийн баялаг буюу ойн нөөц, ойн дагалт баялаг, усны нөөц, ургамал, ан амьтны нөөц, тэдгээрийн ашиглалтын нөхцөл байдлын талаар дараах мэдээлэл нээлттэй эх сурвалжуудад дурдагджээ.

Ойн сангийн талбай 2020 оны байдлаар 18608.0 мян.га буюу нийт нутаг дэвсгэрийн 11.9%-ийг эзэлж байна. Монгол Улсын ойн сангийн нийт талбайн 84.9%-ийг нутгийн хойд хэсэгт тархах шилмүүст, навчит ой, 15.1%-ийг нутгийн өмнөд хэсгийн говь, цөлийн бүсэд тархах заган ой эзэлнэ. Манай орны ойн талбайн хэмжээ нийт газар нутагтай харьцуулахад бага боловч 1 хүнд ногдох ойн талбай 3.7 га/хүн байгаа нь дэлхийн дундаж 0.54 га/хүн үзүүлэлтээс хавьгүй өндөр байдаг. Гэвч ой болон дагалт баялаг нь нөхөн сэргээгддэг баялаг боловч манай орон уур амьсгалын хүнд нөхцөлтэй учраас тэдгээрийн өсөлт, нөхөн сэргэлт удаан байдаг.⁵¹ Улсын Их Хурлын 2015 оны 49 дүгээр тогтоолоор “Төрөөс ойн талаар баримтлах бодлого”-ыг батлан гаргаж, ойг хамгаалахад чиглэсэн менежментээс ойг нөхөн сэргээх, ойжуулах замаар ойгоор бүрхэгдсэн талбайг

⁴⁵ Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар, Нийцлийн аудитын тайлан: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай. Сүхбаатар хот, 2023, 4 дэх тал.

<https://open.audit.mn/reports/open.audit.mn/pages/20240517032125/watermarked.pdf>

⁴⁶ Өмнөхтэй ижил, 8 дахь тал

⁴⁷ Өмнөхтэй ижил, 13 дахь тал

⁴⁸ Өмнөхтэй ижил.

⁴⁹ <https://www.panda.org/es/?207385/----->

⁵⁰ <https://mta.gov.mn/files/pdf/6mousij6c94//659ba082c6e2a83ab8eca99f.pdf>

⁵¹ Б.Оюунсанаа, <https://itoim.mn/article/78Sba/19278>

нэмэгдүүлэх, зүй зохистой, тогтвортой ашиглахад чиглэсэн ойн тогтвортой менежментэд шилжих зорилтыг дэвшүүлсэн.⁵² Гэвч сүүлийн үед ойн сан доройтож, нөөц нь багасаж, хууль бус мод бэлтгэх, ойн дагалт баялаг бэлтгэх ажиллагаа улам бүр газар авч байгаа, ойн сан бүхий газар нутгийн хэмжээ жил дараалан багасаж байгаа болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй хэмжээнд байгаа гэх ойлголт, шүүмжлэл нийгэмд оршин түгээмэл байсаар байна. Байгалийн гамшиг (хэт хуурайшилт, түймэр, хортон шавьж, г.м)-аас гадна замбараагүй, хууль бус мод бэлтгэл, ойн зохисгүй ашиглалт зэрэг нь ойн өөрчлөлтөд хамгийн их сөрөг нөлөөтэй хүчин зүйлс болж байна.⁵³ Тухайлбал, Монгол оронд ихэнх тохиолдолд эмх замраагүй байдлаар мод бэлтгэдэг нь удаан хугацааны ойн доройтолд хүргэдэг. Мод бэлтгэлийн компаниуд ойн тогтвортой менежментийн шилдэг туршлагыг дагаж мөрддөггүй ба мод бэлтгэлийн сөрөг үр дагаврыг бууруулах талаар ажилладаггүй байна.⁵⁴ Мөн түүнчлэн ойн дагалт баялгийн нэг болох хуш модны самрыг их хэмжээгээр ашигласнаас болж байгалийн тэнцвэрт байдалд ихээхэн сөрөг нөлөө үүсдэг байна. Тухайлбал, 2018 онд гаргасан ойн дагалт баялаг ашиглах тухай зөвлөмжид дурдсанаар хуш модны самрын зохисгүй ашиглалт нь ямар сөрөг үр дагавартай байж болохыг тэмдэглэжээ.⁵⁵

Мөн түүнчлэн 2018 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон UN-REDD Монгол Үндэсний хөтөлбөрөөс гүйцэтгэсэн Монголын ойн салбар дахь авлигын эрсдэлийн үнэлгээ ба үндэсний REDD+ хөтөлбөрийн стратегийн бодлого, арга хэмжээ тайланд “ойн санг эзэмших, ашиглах богино хугацааны гэрээ байгуулах орон нутгийн удирдлагын шийдвэрт танил тал, хамаатан садны нөлөө байгаа”, Ойн нөөц ашиглах эрхтэй гэрээт компаниудийг ихэвчлэн төрийн эрх мэдэлтнүүд эзэмшдэг нь ашиг сонирхлын зөрчил үүсгэн орон нутгийн түвшинд бэрхшээл учруулж байна”, “ойн салбарт байгуулсан гэрээ, хэлэлцээрүүдийн ил тод байдал хязгаарлагдмал байна” гэх дүгнэлтүүдийг хийсэн нь энэ салбарт авлигын эрсдэл өндөр байгааг харуулж байна.

Хууль бус мод бэлтгэл, худалдаа өргөн дэлгэрч, системийн авлигын шинжтэй болсныг өмнө нь хийгдэж байсан судалгаануудад дурьдсан байв.

Гэсэн хэдий ч одоогоор Монгол улсын хэмжээнд хууль бус мод бэлтгэл, худалдааны талаарх мэдээллүүд хоорондоо зөрүүтэй бөгөөд зарим эх сурвалж хууль бус мод бэлтгэлийн хэмжээ багасаж байгаа гэж үздэг.

⁵² Монгол орны ойн сан, Ч.Дулмаа, 2024 оны 5 сар. <http://mecc.mn/?p=17684>

⁵³ Ойгүүжилт, Ногоон хөтөч, <https://www.nogoonhutuch.mn/p/c/16/lastOne>

⁵⁴ Монгол орны ойн өөрчлөлтөд хүргэгч хүчин зүйлсийн урьдчилсан үнэлгээ, Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон UN-REDD programme, 31 дэх тал, <https://reddplus.mn/mon/wp-content/uploads/2017/12/Drivers-of-forest-change-in-mongolia-mon.pdf>

⁵⁵ Хуш модны самар, шилмүүс нь хур, сойр, самрын шаазгай, хөтүү зэрэг шувуу, жирх, хэрэм зэрэг мэрэгч, баавгай, гахай зэрэг том амьтдын гол хүнс тэжээл болдог. Жирх, хэрэм 6-10 кг самрыг өвлийн идшиндээ нөөцөлдөг бол баавгай өдөрт 20-30 кг боргоцой идэж 100-150 кг өөх хуримтлуулж байж ичээлэх боломжтой болдог. Баавгай самрын ургац муу жилд ичиж чадахгүй дан ангаар хооллох болдог бөгөөд сард 3-6 толгой гахай, буга, хандгай барьж идэх болдог нь ойн түүрайтан амьтны нөөцөд ихээхэн хохирол учруулахад хүргэдэг. Харин зэрлэг гахай өдөрт 2-2.5 кг самар идэж байж онд орох боломжтой болно. Самрын ургацгүй жил жирх, хэрэм их хорогдсоноос ойн булга, шилүүс зэрэг үслэг амьтдын хоол тэжээл хомсдож өсөж үржих нь багасдаг. Ер нь хуш мод бүрэлдэхүүнд нь орсон хөвч, тайгын ойд 50 зүйл хөхтөн амьтан, 160 орчим зүйл шувуу, зургаан зүйл хоёр нутагтан, дөрвөн зүйл мөлхөгч амьдардаг гэсэн судалгааг эрдэмтэд хийсэн байдаг.

Гэхдээ, ойн тухай хууль тогтоомжийг хэрэгжилтэд авлигын асуудал бэрхшээл учруулж байгаа гэдэг нэгдсэн ойлголт байна.

Зарим нутгийн удирдлагууд төвөөс баталсан квотыг үл хайхран тогтоосон тоо хэмжээнээс хэтрүүлж мод бэлтгэхийг зөвшөөрдөг байна.

Ойн салбарын үйл ажиллагааг хянах байгаль орчны байцаагч нарын нөөц бололцоо хангалтгүйгээс хээл хахууль, хууль бусаар гэрчилгээ олгох зэрэг асуудлууд мөн гарсаар байна.

Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын талаарх мэдээлэл зөрүүтэй, олон нийтийн дунд хязгаарлагдмал байдаг. Хууль тогтоомжид зааснаар орон нутгийн түвшинд хуримтлуулсан ойн нөөц ашигласны төлбөрийн 85% -ийг ойг хамгаалах, ойн менежмент хийхэд зарцуулах ёстой.

Гэхдээ орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлангуудаас харахад эрх бүхий байгууллагууд ихэнх тохиолдолд хуулийн энэ заалтыг дагаж мөрддөггүй нь харагдана.

Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг орон нутгийн удирдлагууд болон ИТХ-аас бусад нийгмийн үйлчилгээ, үйл ажиллагаанд зарцуулаад байна уу эсвэл тус орлогыг завшиж байна уу гэдэг нь тодорхойгүй байна.

Ойн нөхөрлөлүүдийн орлогын хэмжээ харьцангуй бага гэж тооцогддог боловч эдгээр орлогын талаарх мэдээлэл маш бага, тайлан, хяналт нь хязгаарлагдмал байдаг

Үндэсний Аудитийн Газрын тайланд дурдсанаар төвийн удирдлагууд экспортын зөвшөөрлийг квотоос хэмжээнээс хэтрүүлэн олгодог ба БОАЖЯ, гаалийн байгууллага экспортын компаниудаас авах төлбөрөө бүрэн тооцдоггүй байна. Тэдний дотор БОАЖЯ, гаалийн байгууллагад өртэй компаниуд ч байна.

Эх сурвалж: Монголын ойн салбар дахь авлигын эрсдлийн үнэлгээ ба үндэсний REDD+ хөтөлбөрийн стратегийн бодлого, арга хэмжээ, https://reddplus.mn/mon/wp-content/uploads/2018/09/MN_Forest_Report_UNREDD_formatted_06302018.pdf

Усны нөөцийн тухайд Монгол оронд жилд дунджаар 564.8 км³ усны нөөц хуримтлагдан бий болдог бөгөөд үүний 500.0 км³ нууранд, 34.6 км³ гол мөрөнд, 19.4 км³ мөстөл, мөсөн голуудад, 10.8 км³ нь газрын доор агуулагддаг байна. Нийт усны нөөцийн 98 хувь нь гадаргын ус, үлдсэн 2 хувь газрын доорх ус байна. Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн талхагдал, уул уурхайн зохисгүй үйл ажиллагааны улмаас булаг шанд, гол горхи, нуур, тойром хатаж ширгэх үйл явц нэмэгдэж байна. Цаг уурын өөрчлөлт дулаарлын хэмжээ дунджаар 2.2 хэмээр нэмэгдсэн, гангийн давтамж, хуурайшилтын явц хурдацтай явагдаж байгаагаас 2016 оны усны тооллогын дүнгээр улсын хэмжээнд нийт 2245 нуур тойром тоологдсоноос 16.7% нь буюу 376 нь ширгэсэн байна.⁵⁶ Усны тоо бүртгэлийн 2018 оны дүнгээр 316 гол горхи, 85 нуур, тойром, 413 булаг шанд ширгэсэн мэдээ гарсан байна.⁵⁷ Мөн 2020 оны усны тооллогын дүнгээр 116 гол горхи, 381 булаг шанд, 180 нуур тойром, 5 рашаан ширгэсэн дүн гарчээ.⁵⁸

⁵⁶ Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах нь, Байгаль орчны яам, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, УБ хот, 2019 он, 10 дахь тал,

https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/migration/mn/SDG-6_report.pdf

⁵⁷ Байгаль орчны салбарны танилцуулга, Монголын Үндэсний статистикийн хороо, УБ хот, 2019 он

https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=ENVIRONMENT_2018.pdf&ln=Mn

⁵⁸ <https://peoplenews.mn/>

Түүнчлэн сүүлийн 50 жилийн хугацаанд Монгол Улсын цэвэр усны нөөц 40 хувиар буурсан гэх ч мэдээлэл байна.⁵⁹ Эндээс харахад, манай орны усны бодлогод бүс нутгийн газарзүй экологийн онцлогийг харгалзан үзэж тохирсон арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Усны засаглалд, усны эрх зүйн зохицуулалт, стандарт хэм хэмжээ, ус ашиглалт, хаягдал ус зайлуулалтын зөвшөөрөл, оролцогч байгууллагуудын үүрэг хариуцлагын тогтолцоо хамаарахаас гадна тухайн сав газарт бүрэлдэх усны нөөц, түүний ашиглах боломжит хэмжээ, ус ашиглагчид болон бусад сонирхлын бүлгүүдийн хоорондын ашиг сонирхол, ус, газар, бусад байгалийн баялгийн захиран зарцуулалт, тэдгээрийн үйл ажиллагааны ил тод байдал, тайлагнал зэрэг нь нэн чухал үүрэгтэй.

Эх сурвалж: Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах нь, Байгаль орчны яам, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, УБ хот, 2019 он, 51 дэх тал

Байгалийн ургамлын хувьд Монгол Улсад бүртгэгдсэн нийт 2,800 гаруй зүйлийн ургамлаас эмчилгээ болон хүнсний зориулалтаар ашиглагддаг 382 зүйл ургамлын жагсаалтыг гаргаж тэдгээрийн 195 зүйлийг хамгаалах шаардлагатай байгаа ажээ. Судлаачид зах зээлд өртөж хомсдож болзошгүй 102 ургамлын жагсаалт гаргаж, хэрэглээний чиглэлийг тодотгож, тэдгээрээс чихэр өвс, зээргэнэ, цөлийн аргамжин цэцэг, эгэл бавран, газрын ус, дэрэвгэр жиргэрүү, жодоо, монгол хунчир, чацаргана, онго, цагаан мөөг зэрэг 10 гаруй зүйл ургамал гадаадын зах зээлд хулгайн бизнест орох магадлалтайг нотолж, Монгол орны ховор ургамлын жагсаалтад 8 зүйлийг нэмж оруулахаар санал боловсруулан батлуулж, 37 зүйлийн ургамлыг хил гаалийн үзлэгт хамруулж байна. Монгол Улсад хөнөөгдөж устах аюулд орсон эмийн ургамлын зүйл 75 байгаагаас 20 зүйл нь устаж байгаа, ийм хандлагатай хүнсний ургамал 11 зүйл байгаагаас 6 зүйл нь устаж байгаа, техникийн ургамал 16 байгаагаас 4 нь, гоёл чимэглэлийн 55 зүйл байгаагаас 5 зүйл тус бүр устаж байгааг судлаачид тодорхойлсон байна.⁶⁰

Ан амьтны хувьд эрс тэс уур амьсгалтай Монгол оронд 138 зүйлийн хөхтөн, 75 зүйлийн загас, 22 зүйлийн мөлхөгч, 6 зүйлийн хоёр нутагтан, 476 зүйлийн шувуу, бүртгэгджээ.⁶¹ Амьтны нөөц даацад тулгуурласан ашиглалтын зохистой, тогтвортой бодлогыг баримтлан агнах, барих жилийн хэмжээ хязгаарыг тогтоон төлбөртэйгөөр боломжит хэмжээгээр агналтыг зөвшөөрөх чиглэлээр төрөөс бодлого барьж хэрэгжүүлж байна. Манай орны ховор, нэн ховор амьтдын тоо толгой сүүлийн арав гаруйхан жилд огцом буурч байгааг мэргэжлийн байгууллагууд хэлж байна. Монгол улсад 1980-д онд 40 мянга орчим аргал хонь, 140 мянга орчим халиун буга тоологдож байсан. Гэтэл 2001, 2004 оны тооллогоор 13 мянга орчим аргал хонь, 10 мянга орчим халиун буга тоологдож тоо толгой нь хэдэн арав дахин буурсан тухай мэдээлсэн байна.⁶² Мөн зарим ан амьтныг гадаадад гаргах асуудлыг нууц горимоор хэлэлцэж, шийдвэрлэдэг, тэдгээр шийдвэрүүдийг

⁵⁹ <https://www.zindaa.mn/43v3>

⁶⁰ Ургамал, ойн нөөц, The Baikal Basin Information Center, <http://bic.iwlearn.org/mn/documents/natural-conditions/gadarghyn-bolon-ghazryn-doorkh-us/2-3-urghamal-oin-noots>

⁶¹ Зэрлэг амьтан, ургамал, тэдгээрийн эд эрхтэн, бүтээгдэхүүний хууль бүс худалдаа, агнууртай холбоотой гэрээ, хэлэлцээрийн өнөөгийн байдал, УБ хот, 2020 он, 8 дахь тал

<https://cccp.gov.mn/images/content/131caf8ad49fa35a94f9f21aaf1c90.pdf>

⁶² <https://mpress.mn/p/1513>

хэрэгжүүлэх явцад нутгийн иргэд болон төрийн байгууллага, зөвшөөрөл эзэмшигчдийн дунд зөрчлүүд гардаг нь сүүлийн жилүүдэд хэвийн үзэгдэл болсон төдийгүй энэ нь олон нийтийн зүгээс шүүмжлэл дагуулсан байна. Тухайлбал, хэвлэлийн мэдээнд дурдсанаар “БОАЖЯ-наас 2015-2019 онд амьдаар нь барьж гадаадад гаргах шонхорын тоог 2012, 2013, 2014 оныхоос хэд дахин нэмэгдүүлснээр барахгүй 2015 оноос өнөөг хүртэл жил бүр Засгийн газрын “Нууц тогтоол” гээчийг гаргуулж нууцлах болсон нь ихээхэн хардлага төрүүлж байна” гэжээ.⁶³

2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томьёолсон байдал

Судалгааны энэхүү шатанд дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх зорилгыг томьёолно.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 4.2 болон 4.3-т зааснаар асуудлыг шийдвэрлэх зорилгыг томьёолохдоо зорилгыг тухайн шийдвэрлэх гэж байгаа асуудлаас хамааруулан ерөнхий болон тодорхой гэсэн хоёр хэлбэрээр томьёолж болох бөгөөд зорилгыг томьёолохдоо түүнд хүрснээр асуудал шийдвэрлэгдэх эсэх, зорилгыг ерөнхий байдлаар томьёолох тохиолдолд түүнийг хэрэгжүүлэх зорилт байгаа эсэхийг харгалзан үзнэ.

Судалгааны эхэнд дурдсанчлан байгалийн баялаг ашиглалт, тэр дундаа эрдэс баялаг, уул уурхайн салбар ил тод байж уул уурхайн салбарын хариуцлагатай байдлыг хангах, авлигаас ангид байх, цаашлаад нийгэм, эдийн засагт эерэг нөлөө, өсөлт бий болгоно. Байгалийн баялаг ашиглалтын ил тод, нээлттэй байдлыг хангах гол хөшүүрэг нь байгалийн баялгийг ашиглах үйл ажиллагааны бүх үе шатны явц нь ил тод, иргэдэд нээлттэй байх хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн байх явдал юм.⁶⁴

Иймд асуудлыг шийдвэрлэх зорилгыг ерөнхий байдлаар **“байгалийн баялгийг ашиглах ажиллагааны ил тод байдлыг хангах”** гэж тодорхойллоо.

Тухайлбал эрдэс баялаг уул уурхайн салбарын ил тод байдлыг хангах эрх зүйн орчин бүрдсэнээр уул уурхайн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, улмаар уул уурхайн салбарын нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөллийг улам бүр нэмэгдүүлэх, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлд бодлого боловсруулах, уул уурхайн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгох, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, оролцогч талууд уул уурхайн үйл ажиллагааны ашиг, үр

⁶³ 2018-2019 онд нэг жилд гадаадад гаргасан шонхорын тоо түс бүр 395-д хүрч 2013 оныхоос даруй 26 дахин нэмэгджээ. <https://www.polit.mn/a/79242>

⁶⁴ ОУИТБС-д заасан ил тод байдлыг хангах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх нь ОУИТБС-ын гишүүн орнуудын эдийн засгийн өсөлтийн хувьд гишүүн бус орнуудтай харьцуулахад наад зах нь богино болон дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг идэвхжүүлдэг болохыг 2024 оны 12 дугаар сард хэвлэгдэгдсэн [“How does implementing the EITI affect economic growth? Evidence from developing countries”](#) судалгаанд дурджээ.

өгөөжийн талаар нэгдмэл нэг ойлголттой болоход түлхэц болно гэж төсөөлж байна.

Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг татаж буй голлох салбар болохын хувьд эрдэс баялаг уул уурхайн салбар ил тод, хариуцлагатай байж эдийн засагт эерэг нөлөө, өсөлт бий болгоно. Уул уурхайн салбарт гаднын хөрөнгө оруулалтыг татах гол хөшүүрэг нь уул уурхайн төслийн бүх үе шатны үйл явц нь нээлттэй, ил тод, хөрөнгө оруулагчдад ойлгомжтой байх явдал юм.⁶⁵ Энэ зорилгын хүрээнд уул уурхайн төслийн эхний төлөвлөлтөөс уурхайн хаалт хүртэлх бүх үе шатуудад ил тод байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр уул уурхайн салбарын тогтвортой байдлыг хангах, гадны хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлэн татах, үүнээс үүсэх эдийн засгийн эерэг үр нөлөөг хадгалан авч үлдэх боломжтой.

Иймд дээр дурдсан хүчин төгөлдөр үйлчилж буй бодлогын баримт бичгүүдэд тодорхойлон заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд уул уурхайн салбарын ил тод байдлыг хангах стандартыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үндсэн шаардлага тавигдаж байгаа бөгөөд үүний тулд уул уурхайн салбарын ил тод, нээлттэй байдал гэж юу болох, энэхүү ойлголтын хамрах хүрээг тодорхой болгох нь нэн тэргүүнд шаардлагатай болох нь тодорхой юм.

Эрдэс баялаг, уул уурхайн салбартай нэгэн адилаар нөхөн сэргээгдэх байгалийн баялаг ашиглалтын ил тод байдлыг хангах нь тогтвортой хөгжилд маш чухал нөлөөтэй бөгөөд тэдгээрийн ил тод байдлыг хангаснаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, байгалийн баялгийн хэт их ашиглалт, байгалийн доройтлоос урьдчилсан сэргийлэх (жишээлбэл, ой мод, дагалт баялаг, ус, ан амьтдыг хууль бусаар ашиглах г.м.), тэдгээрийн ашиглалтын үйл ажиллагаанд авлигаас урьдчилан сэргийлэх, байгалийн баялаг ашиглалтын тэнцвэртэй, тэгш, хүртээмжтэй байдлыг байдлыг хангах зэрэг ач холбогдолтой. Жишээлбэл, ил тод байдал нь эдгээр төрлийн байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, байгаль болон экосистемын тэнцвэртэй, тогтвортой байдлыг хангах, олон нийтийн хяналт, оролцоог хангахад чухал ач холбогдолтой.

Үндсэн хууль ба байгалийн баялаг

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуульд орсон гол өөрчлөлтүүдийн нэг нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг доорх байдлаар өөрчлөн найруулсан нь юм:

“Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн.

Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.

⁶⁵ Монголын уул уурхайн төслийн шийдвэр гаргах процессын авлигын эрсдэлийн зохицуулалтын үнэлгээ, С.Борбил, Б. Мөнхтогтох, Байгалийн нөөцийн засаглалын Институт, УБ хот, 2023
https://resourcegovernance.org/sites/default/files/documents/mongolia_regulatory_assessment_corruption_risks_mining_sector_mon.pdf

Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.”

Дээрх өөрчлөлтөөр урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулж, үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээх, дийлэнх үр өгөөж ард түмэнд ногдож байх гэж зааснаар байгалийн баялгийг хэрхэн ашиглаж, ямар зарчмаар ард түмэнд хүртээх асуудлыг тодорхой болгосон.

Байгалийн баялгийг ашиглах, үр өгөөжийг ард түмэнд тэгш, шударга хүртээх агуулга бүхий зохицуулалтуудыг оруулснаар төр, түүний байгууллага, албан тушаалтан төрийн нийтийн өмч болох байгалийн баялгийг ашиглах шийдвэр гаргахдаа уг баялаг ард түмний мэдэлд байх зарчмыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлж буй зохицуулалт болсон байна.

Аливаа улсын байгалийн баялаг нь нөхөн сэргээгдэхгүй өмч байх боломжтой тул түүнийг хэн, хэрхэн, ямар аргаар ашиглах хийгээд бодлого хэрэгжүүлэхдээ ард түмний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг нь хөндөхгүй байх нь чухал. Тийм ч учраас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр иргэд өөрийн нутаг дэвсгэрт явагдаж буй ашигт малтмалын үйл ажиллагаанаас бий болох нөлөөллийн тухай мэдэх эрхтэй байхаар тусгасан байна.⁶⁶ Иймд байгалийн баялаг ашиглалтын ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх нь Үндсэн хуулийн дээрх зохицуулалтыг бүрэн хэмжээнд хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

“Хариуцлагатай уул уурхай” болон “ил тод уул уурхай”, “нээлттэй байдал”, “ил тод байдал”

Хариуцлагатай уул уурхай гэх нэр томъёог бодвол уул уурхай дахь ил тод байдал гэсэн нь харьцангуй ойлгомжтой байж болох юм. Гэсэн хэдий ч ил тод байдал нь ихэнхдээ мэдээллээр хангах, нээлттэй байх зэрэг ойролцоо ойлголтуудтай хутгалдаж байдаг.⁶⁷

⁶⁶ Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийн дүн шинжилгээ, О. Алтантуяа, Д. Бадамдаш нар, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, Азийн Сан, МУИС, УБ хот, 2022.

https://cli.num.edu.mn/content/pdf/1_%20NUM_%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB%20%D0%A3%D0%BB%D1%81%D1%8B%D0%BD%20%D2%AE%D0%BD%D0%B4%D1%81%D1%8D%D0%BD%20%D1%85%D1%83%D1%83%D0%BB%D1%8C%D0%B4%202019%20%D0%BE%D0%BD%D0%B4%20%D0%BE%D1%80%D1%83%D1%83%D0%BB%D1%81%D0%B0%D0%BD%20%D0%BD%D1%8D%D0%BC%D1%8D%D0%BB%D1%82%2C%20%D3%A9%D3%A9%D1%80%D1%87%D0%BB%D3%A9%D0%BB%D1%82%D2%AF%D2%AF%D0%B4%D0%B8%D0%B8%CC%86%D0%BD%20%D0%B4%D2%AF%D0%BD%20%D1%88%D0%B8%D0%BD%D0%B6%D0%B8%D0%BB%D0%B3%D1%8D%D1%8D.pdf

⁶⁷ Хариуцлагатай уул уурхай. Сургалтын гарын авлага. ИБУИВУ-ын ЭСЯ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, http://portal.merit.mn/dataset/3a7d148a-1623-4512-86cc-1c926d15a11d/resource/faf79f8e-f5e1-452c-a757-e90ceedfa7ca/download/-_.pdf

Энэхүү судалгааны өмнөх хэсэгт дурдсан уул уурхайн салбарын бодлогын баримт бичгүүдэд “хариуцлагатай уул уурхай” болон “ил тод уул уурхай”, “нээлттэй байдал”, “ил тод байдал” гэх нэр томъёог ихэвчлэн зэрэгцүүлэн, хамтад нь хэрэглэсэн байх ба тэдгээрийг хэрэглэсэн дараалал нь нэг мөр бус байгаагаас зэргээс харахад дээрх нэр томъёонууд нь түгээмэл хэрэглэгддэг боловч тэдгээрийн хамрах цар хүрээг одоог хүртэл тодорхойлсон бодлогын болон эрх зүйн акт, стандарт заавал Монгол Улсад байхгүй байна.

Иймд дээр дурдсан, асуудлыг шийдвэрлэх зорилгыг илүү тодорхой болгохын тулд “ил тод уул уурхай (олборлох салбар)” гэж юу болох, түүний хамрах хүрээг тодорхойлох зүй ёсны шаардлага урган гарч байна. Үүний тулд тухайлбал “хариуцлагатай уул уурхай”, “ил тод уул уурхай”, “ил тод байдал” болон “нээлттэй байдал” гэх ойлголтуудын ялгаа, тэдгээрийн хүрээг тодорхойлох зүй ёсны шаардлага урган гарч байна.

Ил тод байдал болон нээлттэй байдал гэсэн ойлголтууд нь хэдийгээр ижил утгатай ойлголт мэт боловч утгын хувьд ялангуяа уул уурхайн салбарт хэрэглэгдэх утга нь харилцан хамааралтай боловч агуулгын хувьд харилцан адилгүй юм.

Тухайлбал, “нээлттэй байдал” (openness) гэдэг нь төрийн байгууллага, компаниуд болон бусад этгээдийн зүгээс тэдэнд байгаа мэдээллээ бусадтай хуваалцах, сонирхогч талуудтай харилцан хамтран ажиллах, бусдын санал хүсэлтийг хүлээн авахад бэлэн байх хүсэл зоригийг илэрхийлнэ. Энэхүү хүсэл зориг нь заавал хуулиар үүрэг хүлээлгэхгүйгээр, дээр дурдсан этгээдүүдээс тодорхой мэдээллийг сайн дураар бусдад түгээх, бусдад хүртээмжтэй болгох замаар бусдыг шийдвэр гаргах үйл ажиллагаандаа оролцох боломжийг хангахад чиглэсэн байх бөгөөд ихэнх тохиолдолд хуульд заасан мэдээлэл түгээх үүргээс ч өргөн хүрээнд хэрэгжих байдлаар илэрхийлэгддэг. Жишээлбэл, засгийн газар буюу төрийн байгууллага уул уурхайн салбарт хөрөнгө оруулагчтай байгуулсан гэрээг сайн дураар олон нийтэд түгээх, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд нутгийн ард иргэдтэй уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчин болон нийгэмд үзүүлэх үр нөлөөний талаар зөвшилцөх, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, эсхүл тогтвортой байдлыг хангах талаар хэрэгжүүлж буй арга хэмжээнийхээ талаар олон нийтэд сайн дураараа тайлагнах зэргээр илэрхийлэгдэж болно. Иймд “нээлттэй байдал” гэдэг нь сайн дурын үндсэн дээр мэдээллийг түгээх, бусдын оролцоог хангах боломжийг бий болгох ажиллагааг хамрах боловч энэ нь хариуцлагыг бэхжүүлэх цогц механизмыг өөртөө багтаадаггүй байна.

Харин “ил тод байдал” (transparency) гэдэг нь үнэн зөв, найдвартай, ач холбогдол (тухайн асуудалд хамааралтай) бүхий мэдээллийг системтэй, хүртээмжтэй байдлаар бусдад буюу олон нийтэд түгээх үүргийг илэрхийлэх бөгөөд энэ нь ихэвчлэн хууль эрх зүйн арга хэрэгсэлд үндэслэсэн, хариуцлага тооцох, үүргийн хэрэгжилтийг хангах тогтолцоог мөн багтаасан байдаг. Тухайлбал, ил тод байдал гэдэг нь мэдээллийг, ялангуяа авлигын эрсдэлийг бууруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх, итгэлцлийг бий болгоход чиглэсэн, мэдээллийг хүртээмжтэйгээр олон нийтэд түгээх ажиллагааг хамрах бөгөөд мөн чанарын хувьд заавал биелэгдэх шинжтэй, тодорхой мэдээллийг хамарсан, хуульд заасан албадлагаар дамжин хэрэгждэг. Жишээлбэл, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй

компаниудыг засгийн газарт төлсөн бүхий л татвар хураамж төлбөрөө ил тод болгохыг үүрэг болгосон хууль батлан гаргах, эсхүл эдгээр аж ахуйн нэгжийг эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллээ олон нийтэд ил тод тогтмол зарлах үүрэг бүхий эрх зүйн акт гаргах, эсхүл засгийн газар нь уул уурхайн салбараас олж буй бүхий л орлогыг тогтмол мэдээлэх, олон нийтэд хүртээмжтэй болгох цахим мэдээллийн санг байгуулах зэрэг нь ил тод байдлыг хангах арга хэмжээнүүдийг хамаарч болно. Энэ мэтчилэн ил тод байдал гэдэг нь илүү албан ёсны шинжтэй бөгөөд хариуцлагыг бэхжүүлэх байх тал дээр голлон төвлөрсөн, ихэвчлэн хууль эрх зүйн актаар бий болдог, түүнийг хэрэгжүүлэх, мэдээллийн найдвартай байдлыг хангах бүтэц тогтолцоо бүхий цогц арга хэмжээг ойлгож болох юм.

Дээрхээс харахад, нээлттэй байдал нь оролцоо, итгэлцлийг дэмждэг бөгөөд энэ нь орон нутгийн иргэд, иргэний нийгэм болон бусад сонирхогч талуудтай сайн харилцаа тогтооход онцгой ач холбогдолтой бол ил тод байдал нь сонирхогч талууд баталгаажсан, ач холбогдол бүхий мэдээллийг олж авах боломжийг бүрдүүлэх замаар, авлига, санхүүгийн хууль бус урсгал, байгалийн баялгийн буруу менежменттэй тэмцэхэд тусалдаг. Нээлттэй байдал болон ил тод байдлыг хослуулан хэрэгжүүлэх боломжтой бөгөөд нээлттэй байдал нь сонирхогч талуудын дунд итгэлцэл, хамтран ажиллах боломжийг бий болгоход чухал ач холбогдолтой хэдий ч ил тод байдал нь урт хугацааны тогтвортой сайн засаглал, системийн өөрчлөлтийг хийхэд илүү чухал ач холбогдолтой бөгөөд эрдэс баялаг уул уурхайн салбарын сайн засаглалын зайлшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг юм.

Мөн түүнчлэн “хариуцлагатай уул уурхай” болон “ил тод уул уурхай” гэсэн хоёр ойлголт нь харилцан хамааралтай боловч хамрах хүрээний хувьд тусдаа ойлголтууд юм. Тухайлбал, хариуцлагатай уул уурхай гэх ойлголт нь нийгэм, хүрээлэн буй орчин болон эдийн засгийн хүчин зүйлсийг нэгтгэн хамардаг бөгөөд жишээлбэл, уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн гарч болзошгүй байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөлөл болон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг багасгах, орон нутгийн иргэд болон уул уурхайн ажилчдын эрхийг хамгаалах, уул уурхайн олборлолтын ашгийн зүй зохистой хуваарилалтыг хангах, уул уурхайн үйл ажиллагаа нь улс, орон нутгийн тогтвортой хөгжилд бодитой хувь нэмэр оруулах, уг салбарын нээлттэй хариуцлагатай засаглалыг дэмжих зэрэг үйл ажиллагааг хамаардаг.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран гаргасан “Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага ба үнэлгээний аргачлал”⁶⁸ судалгаанд дурдсанаар “хариуцлагатай уул уурхай” гэдэг нь уул уурхайг зөв ашиглах гэсэн утгыг илэрхийлэх бөгөөд энэ нь “товчхондоо тухайн уурхайг ашигласнаар улс орны хөгжилд нь нэмэртэй, ард түмний амьдралд тустай, байгаль орчин, хүний эрүүл мэндэд хохиролгүй байхыг хэлэх ба уул уурхайг төлөвлөж эхлэхээс авхуулаад дуусах хүртэл хийгдэх олон талын цогц арга хэмжээ” гэж тодорхойлсон байна. Эдгээр нийт арга хэмжээг олон улсын хэмжээнд “Responsible Mining” буюу “Хариуцлагатай уул уурхай” гэж нэрлэж байна.⁶⁹ Түүнчлэн Хариуцлагатай уул уурхайн сан (Responsible Mining

⁶⁸ Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага ба үнэлгээний аргачлал. Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, УБ хот, 2018, 25 дахь тал
<https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/migration/mn/3a9d885828fa51337a66f7d13ab5754377e3cc764827c0a2988b182bb2c07cc8.pdf>

⁶⁹ Өмнөхтэй ижил, 26 дахь тал

Foundation)-гийн тодорхойлсноор хариуцлагатай уул уурхай гэдэг нь “Уул уурхайн үйл ажиллагаа тухайн үйлдвэрлэгч орны ард түмэн, орон нутгийн иргэдийн эрх ашиг болон хүрээлэн буй орчныг илтэд хүндэтгэн хамгаалсан байхаас гадна эдийн засгийн хөгжилд нь өргөн хүрээнд, шударгаар болон мэдэгдэхүйц хувь нэмэр оруулахыг хэлнэ” гэсэн байна.⁷⁰

Харин ил тод уул уурхай гэдэг нь уул уурхай, олборлох үйл ажиллагааны бүхий л үе шатууд (уул уурхайн төслийн эхний төлөвлөлтөөс уурхайн хаалт хүртэлх) дахь мэдээллийн нээлттэй байдал, уг нээлттэй байдлыг хэрэгжүүлэх тогтолцоо болон олон нийтийн оролцоог хангах зэрэг жишээлбэл, уул уурхайн олборлолтын болон санхүүгийн үйл ажиллагаа, тэр дундаа, ашигт малтмал олборлох гэрээ хэлцэл, төр болон хувийн хэвшлийн хоорон дахь төлбөрүүд, ашиг, орлого, татвар хураамж зэргийн талаарх мэдээллийн нээлттэй байдлыг багтаадаг.

Дээрхээс харахад хариуцлагатай уул уурхай гэдэг нь ил тод уул уурхай гэх ойлголтоос илүү өргөн хүрээтэй ойлголт бөгөөд харин ил тод байдал нь хариуцлагатай уул уурхайг цогцлоох гол нөхцөлүүдийн нэг болох нь харагдаж байна. Жишээлбэл, уул уурхайн үйл ажиллагааны ашиг орлого, түүнээс төлөх татвар хураамжийн ил тод байдлыг хангаснаар хариуцлагатай уул уурхайн гол зорилгуудын нэг болох авлигаас урьдчилан сэргийлэх, уул уурхайн олборлолтын ашгийн зүй зохистой хуваарилалтыг дэмжих, улс, орон нутгийн тогтвортой хөгжилд бодитой хувь нэмэр оруулах зэрэг зорилтуудыг хангах бүрэн боломжтой болох юм. Нөгөөтээгүүр зөвхөн ил тод байдал нь уул уурхайг дангаараа “хариуцлагатай” болгох боломжгүй юм. Жишээлбэл, уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч тодорхой хэмжээнд ил тод байдлыг хангаж байгаа ч байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулах, хүний эрхийг зөрчих гэх мэт хариуцлагатай уул уурхайн суурь зарчим зорилтуудад нийцээгүй үйл ажиллагаа явуулах, түүнийгээ үргэлжлүүлэх боломжтой байна. Дээрхээс дүгнэхэд ил тод уул уурхай нь хариуцлагатай уул уурхайг дэмжих, түүнийг цогцлоон бий болгоход зайлшгүй шаардлагатай нөхцөлүүдийн нэг болох нь харагдаж байна.

Ил тод уул уурхайн тодорхойлолтын тухайд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (Extractive Industries Transparency Initiative) нь “ил тод байдал”-ын нэгдсэн тодорхойлолтыг гаргаагүй ч олборлох үйлдвэрлэлийн хариуцлага, сайн засаглалыг хангахын тулд чухал мэдээлэл, үйл явцыг ил тод болгоход онцгойлон анхаарч олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын үндсэн элементүүдийг тоймлон Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын стандартад (EITI Standards) тусгасан байдаг. Эдгээр ил тод байдлын үндсэн элементүүдэд нь тухайлбал:

- Орлого ба төлбөр (Засгийн газар болон компаниуд олборлох салбарын орлого (жишээ нь: татвар, нөөц ашигласны төлбөр, урамшуулал) болон засгийн газарт төлсөн бусад төлбөрийн талаарх мэдээллийн ил тод байдал)
- Гэрээ болон тусгай зөвшөөрөл (газрын тос, байгалийн хий, уул уурхайн төслүүдийг зохицуулж буй гэрээ, лиценз буюу тусгай зөвшөөрлийн ил тод байдал)

⁷⁰ Responsible Mining Index Draft Methodology. Responsible Mining Foundation, 2016

- Үйлдвэрлэл, тээвэрлэлт ба экспорт (байгалийн баялгийн үйлдвэрлэлийн хэмжээ, үнэ цэнэ, тээвэрлэлт, экспортын талаарх мэдээллийн ил тод байдал)
- Эцсийн өмчлөгч (олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудыг эзэмшдэг эсвэл хянадаг хүмүүс буюу эцсийн өмчлөгчийн ил тод байдал)
- Орлогын хуваарилалт (байгалийн баялгаас олж буй орлогыг хэрхэн хуваарилж, ашиглаж байгаа, ялангуяа эдийн засаг болон олон нийтэд ашигтай төслүүдэд оруулж буй хувь нэмэртэй холбоотой ил тод байдал)
- Хууль эрх зүйн болон зохион байгуулалтын тогтолцоо (олборлох үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүй, зохицуулалт, зохион байгуулалтын механизмын ил тод байдал) зэрэг болно.

Иймд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгаас гаргасан стандарт, зарчмуудаас дүгнэхэд уул уурхайн ил тод байдал нь олборлох үйлдвэрлэлийн нийт өртгийн сүлжээний талаарх⁷¹ буюу хэрхэн гэрээ болон тусгай зөвшөөрлийг хуваарилах болон бүртгэхээс эхлээд орлогын бүрдүүлэлт, хуваарилалт хүртэлх, ард түмэнд очих бодит үр өгөөжийн талаарх мэдээллийг засгийн газар, аж ахуйн нэгжүүдээс олон нийтэд ил болгох цогц үйл ажиллагааг ойлгохоор байна. Энэхүү ил тод байдал нь авлигыг бууруулах, хариуцлагыг бэхжүүлэх, олборлох үйлдвэрлэлд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг бүрдүүлэх зорилготой юм.

3. Зохицуулах хувилбаруудыг тогтоосон байдал

Хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалд заасны дагуу судалгааны энэ үе шатанд дээр дурдсан зорилгод хүрэх, түүнийг биелүүлэхэд чиглэсэн асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулна.

Зохицуулалтын хувилбаруудын зорилгод хүрэх байдал болон тэдгээрийн эерэг, сөрөг тал, тухайн асуудлыг шийдвэрлэсэн бусад орны сайн туршлага зэргийг харьцуулан судалсны үндсэн дээр зохицуулалтын хувилбарыг сонгоно.

Хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 5.1-д зааснаар зохицуулалтын дараах хувилбарууд байна:

- “тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах;
- хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;
- зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;
- төрөөс санхүүгийн интервенц хийх;
- төрийн бус байгууллага, хувийн хэвслээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх

⁷¹ аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээг бүтээх, үйлдвэрлэх, хэрэглэгчдэд хүргэхэд шаардагдах бүх үйл ажиллагаа, оролцогчдын хүрээ гэж тодорхойлж болно

- захиргааны шийдвэр гаргах
- хууль тогтоомжийн төсөл боловсруулах.

Хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 5.6-д заасны дагуу зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талыг “зорилгод хүрэх байдал” болон “зардал үр өгөөжийн харьцаа” гэсэн хоёр шалгуур үзүүлэлтийн хүрээнд харьцуулан судална.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр анх тавьсан (энэхүү аргачлалын Дөрөв дэх хэсэгт заасны дагуу томьёолсон) зорилгод хүрч чадах эсэхийг тогтооно. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалтын хувилбаруудыг ерөнхий байдлаар тандан судлах явцад зарим хувилбар үр дүнгүй болох нь тодорхой болж болох бөгөөд тийнхүү үр дүнгүй болох нь тогтоогдсон хувилбаруудаас татгалзаж, үр дүнтэй буюу цаашид үр нөлөөг нь тооцох шаардлагатай хувилбаруудыг сонгож нарийвчлан томьёолно.

“Зардал, үр өгөөжийн харьцаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбогдон улсын төсвөөс зардал гарах эсэх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд захиргааны ачаалал, нэмэлт зардал үүсэх эсэхийг ерөнхий байдлаар тандан судалж, зардал их/бага гарна, эсхүл зардал гарахгүй гэж дүгнэнэ.

Эцэст нь Хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 5.11-д зааснаар “зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд зохицуулалтын хувилбаруудыг хооронд нь харьцуулсны үндсэн дээр анх тавьсан зорилгод хүрэх боломжтой гэж дүгнэгдсэн зохицуулалтын хувилбарууд дундаас бага зардлаар өндөр үр дүнд хүрэх зохицуулалтын хувилбарыг сонгож цаашид үр нөлөөг нь тандан судална.

Иймд дээрх аргачлалын дагуу зохицуулалтын хувилбаруудыг эрдэс баялаг уул уурхайн салбарын жишээн дээр доорх байдлаар харьцуулан судалж дүгнэлээ. Доорх дүгнэлт нь байгалийн нөхөн сэргээгдэх баялагт мөн нэгэн адил хамаарна.

А. “Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах хувилбар

Зорилгод хүрэх байдал: Асуудлыг зохицуулах “тэг” хувилбарыг сонгох буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах хувилбарыг сонгосноор судалгааны өмнөх хэсэгт тодорхойлсон зорилгод хүрэх боломжгүй нь тодорхой юм. Учир нь одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журмуудын хүрээнд “ил тод, нээлттэй уул уурхай” гэх ойлголт, түүний хамрах хүрээ, хэрэгжүүлэх арга зам, хэрэгслийг тодорхойлоогүй бөгөөд шинээр зохицуулалт хийхгүйгээр энэ байдал нь цаг хугацааны явцад өөрчлөгдөх боломжгүй юм.

Тухайлбал, Монголын уул уурхайн төслийн шийдвэр гаргах процессын авлигын эрсдэлийн зохицуулалтын үнэлгээ судалгаанд⁷² дурдсанаар ашигт малтмалын тухай хууль тогтоомжуудад дүн шинжилгээ хийх явцад ажиглагдсан нэг нийтлэг хандлага нь “улс төрийн дэмжлэг авдаггүй, бизнесийн бүлэглэлийн сонирхлыг төрүүлдэггүй үйл ажиллагаа, харилцааны эрх зүйн зохицуулалт нь өөрчлөгддөггүй байх явдал” гэжээ. Энэхүү судалгааны зохиогчдын үзсэнээр дээрх байдал нь салбарын хөгжил өөрчлөлтийг тусгадаггүй, шинээр үүсэж байгаа харилцаа, ойлголтыг журмаар зохицуулахгүй үлдээх, цаашид зохицуулалтын завсар, цоорхой бий болох эрсдэл дагуулж байна.⁷³

Иймд асуудлыг шийдвэрлэх зорилгодоо хүрэхийн тулд төрөөс ямар нэгэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай бөгөөд хэрэв тэгээгүй тохиолдолд уул уурхайн ил тод байдлыг хангахад чиглэгдсэн ямар нэгэн өөрчлөлт гарахгүйгээр зогсохгүй энэхүү судалгааны ажлын эхэнд дурдсан олон олон сөрөг үр дагавар үүсэх эрсдэл хэвээр хадгалагдах төдийгүй өсөх магадлалтай.

Зардал, үр өгөөжийн харьцаа: Мэдээж хэрэг зохицуулах “тэг” хувилбарыг сонгох буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзсанаар ямар нэгэн зардал гарахгүй нь ойлгомжтой боловч энэ нь мөн ямар ч үр өгөөж бий болгохгүй нь тодорхой юм.

Дүгнэлт: Зорилгод хүрэх байдал болон зардал, үр өгөөжийн харьцаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд авч үзэхэд энэхүү зохицуулалтын хувилбарыг сонгосноор эрдэс баялаг уул уурхай, олборлолтын ил тод байдлыг хангах зорилгод хүрч чадахааргүй байна.

Б. Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх хувилбар

Зорилгод хүрэх байдал: Уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг зөвхөн хэвлэл мэдээллийн оролцоо, олон нийтийг соён гэгээрүүлэх, тэдгээрийн мэдлэгийг дээшлүүлэх замаар хангах боломжгүй бөгөөд учир нь энэхүү арга зам нь ил тод байдлын экосистемийн зөвхөн нэг элемент болох мэдээлэл түгээх асуудлыг хамардаг. Ил тод байдлыг хангахын тулд хууль эрх зүй, бодлого, зохицуулалтын цогц тогтолцоо, тэр дундаа уг тогтолцоог хэрэгжүүлэх, хариуцлага тооцох арга хэмжээг зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Тухайлбал, хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийн соён гэгээрүүлэх нь иргэд олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх,

⁷² Монголын уул уурхайн төслийн шийдвэр гаргах процессын авлигын эрсдэлийн зохицуулалтын үнэлгээ, С.Борбил, Б. Мөнхтогтох, Байгалийн нөөцийн засаглалын Институт, УБ хот, 2023, 46 дахь тал https://resourcegovernance.org/sites/default/files/documents/mongolia_regulatory_assessment_corruption_risks_mining_sector_mon.pdf

⁷³ Жишээлбэл, уул уурхайн салбар болон түүний байгаль орчны нөлөөллийг зохицуулах зорилго бүхий “Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль” анх 2012 онд батлагдаад нийт таван удаа нэмэлт өөрчлөлт орсон. Харин “Ашигт малтмалын тухай хууль” 2006 онд батлагдсанаас хойш 40 удаа, 2012 оноос хойш 31 удаа нэмэлт өөрчлөлт орсон байх жишээтэй. Мөн “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”-ыг 2013, 2014 онд анхлан баталснаас хойш нэг ч өөрчлөлт, шинэчлэлт ороогүй байхад “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ыг 2014 оноос хойш нийт долоо удаа өөрчлөгдсөн тухай дээрх судалгаанд дурджээ.

тулгамдаад буй асуудлуудын талаарх тэдгээрийн ойлголтыг нэмэгдүүлэх, бэхжүүлэх эерэг үр дүнтэй хэдий ч уул уурхай, олборлох үйл ажиллагааны үнэн зөв мэдээллийг тогтмол ил тод, нээлттэй байлгах албан ёсны тогтолцоог орлож чадахгүй юм. Учир нь уул уурхай олборлох салбарын ил тод байдал нь хуулиар бий болгосон санхүүгийн, үйл ажиллагааны болон гэрээний мэдээллийг ил тод болгох механизмаас хамаардаг бөгөөд хууль эрх зүйн болон шаардлагатай бүтэц, тогтолцоог бүрдүүлэхгүйгээр ил тод байдлыг хэрэгжүүлэх оролдлого нь ил тод болж буй мэдээлэл тогтмол бус байх, тэдгээр нь хамрах хүрээ болон чанарын хувьд жигд бус, аль нэг этгээдийн дур зоргоос хэт хамааралтай болох талтай. Жишээлбэл, хуулиар тодорхой үүрэг бий болгоогүй тохиолдолд уул уурхайн салбарын компаниуд эсхүл төрийн байгууллага холбогдох гэрээ хэлцэл, тэдгээрийн дагуу хийгдэж буй төлбөрүүдийг олон нийтэд нээлттэй мэдээлэхээс татгалзах боломжтой бөгөөд энэ үйлдэлд нь ямар нэгэн хариуцлага хүлээлгэх боломжгүй юм.

Түүнчлэн хэвлэл мэдээллийн болон олон нийтийг соён гэгээрүүл үйл ажиллагаа нь сэтгүүлчид болон олон нийтэд ил болсон мэдээллээс ихэнхдээ хамаардаг бөгөөд мэдээллийн ил тод байдлыг хангах зохих тогтолцоо байхгүй тохиолдолд тухайн ил болсон мэдээлэл нь бүрэн бус, алдаатай эсхүл өрөөсгөл байж болзошгүй бөгөөд энэ нь олон нийтэд буруу ойлголтыг төрүүлэх, тэдгээрийн дунд хагарал үүсгэх эрсдэлийг үргэлж дагуулж байдаг. Жишээлбэл, мэдээллийн ил тод байдлыг хангах хуулийн тодорхой зохицуулалтгүй бол компаниуд болон төрийн байгууллагууд уул уурхай олборлох үйл ажиллагаатай холбоотой чухал мэдээллүүдийг олж авах боломжийг хязгаарлах боломжийг бий болгохоос гадна хэвлэл мэдээллийн хэрэгслүүд зөвхөн шуугиан тарьсан олны анхаарлыг татсан цөөн тооны асуудалд хэт төвлөрч уул уурхайн орлогын буруу хуваарилалт, байгаль орчны зөрчил зэрэг илүү системийн асуудлууд олон нийтийн анхаарлаас гадуур үлдэж орхигдох боломжийг бий болгодог.

Олон нийтийг соён гэгээрүүлэх ажил нь олон нийтийн зүгээс ил тод байдлыг хангахад чиглэсэн тодорхой хүлээлтийг бий болгох замаар уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн оролцогч нараас ил тод нээлттэй байдлыг хангах тодорхой үйлдэл хийхэд хүргэж болох ч ил тод байдлыг хэрэгжүүлэх засаглалын хүчтэй тогтолцоо болон хараат бус ил тод байдлыг хангах, хяналт тавих тогтолцоогүйгээр дангаараа ил тод байдлыг бий болгоход хангалтгүй юм. Учир нь ил тод байдал нь түүнийг хангахад чиглэсэн мэдээлэл цуглуулах, мэдээллийн чанар үнэн зөв байдлыг хараат бусаар шалгаж баталгаажуулах болон мэдээллийг олон нийтэд хүргэх тогтолцооноос бүрдэх бөгөөд энэхүү арга хэмжээнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь ач холбогдолтой боловч эдгээр арга хэмжээнүүдийг дангаараа гүйцэтгэх боломжгүй байдаг.

Мөн уул уурхай, олборлох үйлдвэрлэлд холбогдох мэдээлэл нь үйлдвэрлэлийн тоо хэмжээ, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, татвар хураамж, гэрээ гэх мэт нарийвчилсан болон санхүү, хууль эрх зүй, үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан болон техникийн өгөгдлүүдээс бүрддэг бөгөөд хэвлэл мэдээлэл, олон нийтэд ийм нарийн төвөгтэй өгөгдөлд дүн шинжилгээ хийх, тэдгээрийг хүртээмжтэй байдлаар түгээх чадавх, туршлага ихэвчлэн дутмаг байдаг.

Зарим тохиолдолд хэвлэл мэдээлэл нь засгийн газрын хяналт, эсхүл тодорхой компани, бизнесийн бүлэглэлүүдийн нөлөөнд автах эрсдэлтэй байдаг бөгөөд энэ

нь уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн талаар чухал мэдээллүүдийг олон нийтэд түгээх боломжийг нь хязгаарлаад зогсохгүй зарим тохиолдолд энэхүү оролдох нь сэтгүүлчдийн амь нас эрүүл мэндэд ч бодит аюул заналхийллийг бий болгодог төдийгүй уул уурхайн салбарын орлогын тэгш бус хуваарилалт, авлига, буруу менежментийн талаар мэдээлэл түгээснийхээ төлөө дарамт шахалтад өртөх, хуулийн хариуцлага хүлээх нь ч цөөнгүй байдаг.

Зардал, үр өгөөжийн харьцаа: Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх нь уул уурхайн ил тод байдалд тулгамдаж буй асуудлыг ил болгох тэдгээрийг шийдвэрлэх талаар олон нийтийн санаа бодлыг төлөвшүүлэхэд чухал нөлөө үзүүлэх боловч хууль эрх зүйн хүрээний тодорхой арга хэмжээгүйгээр дангаараа төдийлөн өндөр үр өгөөжтэй байх боломжгүй байна.

Зардлын хувьд энэхүү зохицуулалтын хувилбар нь төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, олон нийтийг мэдээллээр хангах, уул уурхайг олборлох үйлдвэрлэлийн талаарх нарийвчилсан техник өгөгдлүүдийг ойлгох, тайлбарлах чадавхыг бэхжүүлэх тогтмол арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх зэрэг зардал шаардлагатай. Гэвч үр өгөөжийн хувьд энэхүү арга хэмжээ нь олон нийт уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн мэдээллийг хэрхэн хүлээн авах болон ашиглах, хэвлэл мэдээллийн мэргэшсэн байдал, бие даасан, хараат бус байдал зэргээс хэт хараат байхаар байна.

Дүгнэлт: Дээр дурдсанчлан уул уурхайн ил тод байдлыг хангахад хэвлэл мэдээллийн оролцоо, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа нь чухал үүрэгтэй боловч дангаараа эдгээр арга хэмжээ нь эрдэс баялаг уул уурхай, олборлолтын ил тод байдлыг хангах зорилгод хүрч чадахгүй гэдэг нь харагдаж байна. Энэ нөхцөлд энэхүү зохицуулалтыг хэрэгжүүлснээр зардал нэмэгдэх хэдий ч үр өгөөж нь бага буюу тодорхойгүй байх тул уг хувилбарыг үр ашиг муутай гэсэн дүгнэлт хийлээ.

В. Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх хувилбар

Зорилгод хүрэх байдал: Уул уурхай олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг зах зээлийн механизм дангаараа хангаж чадахгүй бөгөөд учир нь аль ч аж ахуйн үйл ажиллагааны нэгэн адил ашиг олох гэсэн зорилго нь ил тод, хариуцлагатай байх зорилготой зөрчилддөг. Тухайлбал, уул уурхай олборлох үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд нь дийлэнх тохиолдолд ашгийн төлөө, ашиг олох зорилгоор үйл ажиллагаа явуулж байдаг бөгөөд ил тод байдал нь (тэр дундаа гэрээ хэлцэл, ашиг орлогын мэдээлэл, татвар хураамж зэрэг чухал мэдээллийг ил болгох нь) тэдгээрийн эдийн засгийн ашиг сонирхолд нийцэхгүй байх боломжтой бөгөөд энэ нь тэдгээрийн үйл ажиллагаанд олон нийтийн зүгээс ирэх дарамтыг ихэсгэх, зах зээлийн бусад оролцогчдын зүгээс өрсөлдөөнийг ширүүсгэх зэрэг эрсдэлийг дагуулдаг. Иймд хууль тогтоомжийн хүрээнд батлагдсан тодорхой мэдээллийг нээлттэй байлгах, ил тод байдлыг хангахад чиглэсэн зохицуулалтгүйгээр компаниуд мэдээллийг ил болгохдоо өөрсдийн дур зоргоор аашлах, өөрсдийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж болзошгүй мэдээллийг нуун далдлах зэрэг сөрөг үр дагавар гарч болзошгүй.

Түүнчлэн уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд уул уурхайн салбарын ил тод байдал нь зөвхөн олон нийтийн эрх ашигт нийцэж олон нийтэд үр өгөөжөө хүртээдэг бөгөөд харин ил тод байдлыг хангах зардлыг компаниуд хариуцаж төлдөг гэсэн итгэл үнэмшил байдаг бөгөөд энэ тохиолдолд компаниудын зүгээс ил тод байдлыг дэмжих санаачилга гаргах нь хязгаарлагдмал байх нь тодорхой юм. Бизнес эрхлэгчид нь өөрсдийн үйл ажиллагаанд хугацаа хожих, нэмэлт зардал гаргахгүй, давхар үүрэг хүлээхгүй, ашгаа бууруулах ямар нэгэн алхам хийхгүй байх үүднээс ил тод байдлыг дэмжих зохицуулалтыг сайн дураараа нэвтрүүлэхгүй байх, нэвтрүүлэх зах зээлийн механизмуудыг дэмжихгүй байх хандлагатай байдаг.

Мөн ширүүн өрсөлдөөн бүхий зах зээлд компаниуд бизнесийн нууцаа хамгаалах, өрсөлдөх чадвараа хадгалах, хууль бус үйлдэл, үйл ажиллагаагаа нуун дарагдуулахын тулд ил тод байдлаас зайлсхийдэг. Зарлага орлого болон гэрээний талаарх ил тод байдал нь өрсөлдөгч нарт нь бизнесийн нууцыг нь задруулах эсхүл гэрээлэгч орнуудтай өөрсөддөө ашигтай таатай нөхцөл бүхий гэрээ хэлэлцээр хийх чадварыг бууруулдаг гэж үздэг. Иймд зах зээлийн механизм нь дангаараа уул уурхайн ил тод байдлыг хангах боломж хязгаарлагдмал байх нь тодорхой юм.

Зардал, үр өгөөжийн харьцаа: Дээр дурдсанчлан уул уурхайн салбарын зах зээлийн механизм нь ил тод байдлыг бэхжүүлэхэд ямар нэгэн хөшүүрэг бий болгох боломжгүй учир энэхүү зохицуулалтын хувилбарын үр өгөөж нь бага буюу тодорхойгүй байхаар төсөөлөл гарч байна. Ил тод байдлыг хангахын тулд засгийн газар, компаниуд, иргэний нийгэм, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа шаардлагатай бөгөөд энэ нь зөвхөн зах зээлд суурилсан тогтолцооны хүрээнээс давсан асуудал юм.

Дүгнэлт: Зорилгод хүрэх байдал болон зардал, үр өгөөжийн харьцаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд авч үзэхэд энэхүү зохицуулалтын хувилбарыг сонгосноор эрдэс баялаг уул уурхай, олборлолтын ил тод байдлыг хангах зорилгод хүрч чадахааргүй байна. Зах зээлийн механизм нь тодорхой хэмжээний ил тод байдлыг (жишээлбэл, хэрэглэгчийн шахалт, хөрөнгө оруулагчдын шаардлагаар) бий болгоход түлхэц болж болох ч ил тод байдлыг бүрэн хэмжээгээр хангахын тулд хууль эрх зүйн зохицуулалт, бие даасан хяналт, засгийн газар, иргэний нийгэм, орон нутгийн иргэд зэрэг бүх оролцогч талуудын идэвхтэй оролцоо шаардлагатай. Тиймээс жинхэнэ ил тод байдлыг хангахад шаардлагатай системийн шинэчлэлийг хийхэд зах зээлийн механизм дангаараа дангаараа хангалтгүй буюу үр өгөөж багатай байна гэж дүгнэж байна.

Г. Төрөөс санхүүгийн интервенц хийх хувилбар

Зорилгод хүрэх байдал: Төрийн санхүүгийн интервенц буюу оролцооны төрлүүд болох татаас, татвар, ашигт малтмал ашигласны төлбөр болон хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүд нь уул уурхай, олборлох салбарыг удирдах чухал хэрэгслүүд боловч ил тод байдлыг бүрэн хангахад хангалтгүй юм. Учир нь эдгээр санхүүгийн интервенцийн төрлүүд нь үндсэндээ орлого бүрдүүлэлт, хуваарилалт, түүний урсгал, эдийн засгийн үр нөлөөг удирдахад чиглэдэг бол ил тод байдал нь илүү өргөн хүрээний засаглал, хариуцлага, хяналтын механизмыг шаарддаг.

Зардал, үр өгөөжийн харьцаа: Энэхүү зохицуулалтын хувилбарыг ашигласнаар зорилгодоо бүрэх боломжгүй байгаа нь тодорхой байх тул зардал, үр өгөөжийн харилцааг тооцоолох шаардлагагүй гэж үзлээ.

Дүгнэлт: Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд авч үзэхэд энэхүү зохицуулалтын хувилбарыг сонгосноор эрдэс баялаг уул уурхай, олборлолтын ил тод байдлыг хангах зорилгод боломжгүй байна.

Д. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх хувилбар

Зорилгод хүрэх байдал: Ил тод байдлыг хангахтай холбоотой шаардлагатай чиг үүргийг төрийн бус байгууллагуудад (ТББ) шилжүүлэх нь олборлох салбарын ил тод байдлыг хангахад хангалтгүй, учир нь ТББ-ууд уг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой хэдий ч ил тод байдлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх мэдэл, чадавх, нөлөөллийн хувьд хязгаарлагдмал байдаг. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал нь хууль эрх зүйн бүрэн эрх, зохицуулалтын хяналт, төрийн үүрэг хариуцлага, компанийн хариуцлага, олон нийтийн оролцоо зэргийг багтаасан цогц, олон талт асуудал юм. Ил тод байдлын чиг үүргийг зөвхөн ТББ-уудад найдах нь томоохон хийдлийг бий болгоно. Тухайлбал, ТББ-ууд ил тод байдлыг хангах, гэрээ, үйлдвэрлэлийн мэдээлэл, орлого гэх мэт чухал мэдээллийг ил тод болгохыг компани, засгийн газруудаас шаардах, албадан гаргуулах эрх хэмжээгүй байдаг бөгөөд ил тод байдал нь зөвхөн засгийн газар эсвэл хуулийн дагуу эрх мэдэл бүхий байгууллагууд хэрэгжүүлж чадахуй, ил тод байдлыг хангахад чиглэсэн хуулиар олгогдсон чиг үүр үүргийг шаарддаг. Иймд ТББ-ууд нь засгийн газар болон хувийн компаниудын эзэмшиж буй нууц гэрээ, татварын мэдүүлэг, эцсийн өмчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл гэх мэт гол өгөгдөл, мэдээлэлд нэвтрэх боломжгүй байдаг.

Түүнчлэн ТББ-ууд санхүүгийн эх үүсвэр, боловсон хүчин, техникийн мэдлэг чадвар хязгаарлагдмал байдаг нь олборлох салбарын ил тод байдлыг хангахад шаардагдах цогц, тогтвортой хүчин чармайлтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулдаг. Орлогын аудит хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлан нийтлэх зэрэг ил тод байдлын томоохон санаачилга нь ихээхэн хэмжээний санхүүжилт, техникийн чадавхыг шаарддаг.

Ил тод байдлыг хангах чиг үүргийг ТББ-ууд шилжүүлснээр ил тод байдлыг хангах үйл ажиллагаа нэгдсэн удирдлага, арга барилгүй болох төдийгүй өөр ТББ-ууд өөр өөр асуудал дээр анхаарлаа төвлөрүүлэх зэргээс үүдэн ил тод байдлыг хангах үйл ажиллагаа хүчин чармайлтыг хуваагдах, тэдгээрээс шалтгаалж ил тод байдал харилцан адилгүй байдлаар хэрэгжихэд хүргэдэг. Ил тод байдлыг иж бүрэн байдлаар хангахын тулд засгийн газар, компаниуд, иргэний нийгэм, олон улсын байгууллагууд зэрэг оролцогч талуудын нягт уялдаа холбоотой ажиллахыг шаарддаг бөгөөд энэхүү чиг үүргийг төрийн бус байгууллагууд дангаараа үр дүнтэй гүйцэтгэхэд учир дутагдалтай юм. Мөн ТББ-ууд нь засгийн газар, корпорацуудтай нэгэн адил хариуцлагын стандартад тэр бүр захирагддаггүй бөгөөд тэдний ил тод байдал, санхүүжилтийн эх үүсвэр эсвэл улс төрийн үзэл санаа нь тэдний үйл ажиллагааны талаарх итгэл үнэмшил, үр нөлөөг бууруулж болзошгүй юм.

Олборлох салбарын ил тод байдлыг хангахын тулд лиценз, хайгуул, олборлолт, орлогын хуваарилалт, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, нийгэмд үзүүлэх үр өгөөж зэрэг өртгийн сүлжээг бүхэлд нь хянах шаардлагатай. ТББ-ууд тодорхой чиглэлүүдэд анхаарлаа хандуулж болох ч бүрэн хамрах хүрээг нь хянах чадамж, эрх мэдэл дутмаг байдаг. Засгийн газар, зохицуулах байгууллагууд бүх үе шатанд иж бүрэн хяналт тавих шаардлагатай байна.

Зардал, үр өгөөжийн харьцаа: ТББ-ууд нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг боловч дангаараа ил тод байдлыг иж бүрэн, тогтвортой байлгахад хангалтгүй юм. Иймд энэхүү зохицуулалтын хувилбарыг ашигласнаар зорилгодоо бүрэх боломжгүй байгаа нь тодорхой байх тул зардал, үр өгөөжийн харилцааг тооцоолох шаардлагагүй гэж үзлээ.

Дүгнэлт: Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд авч үзэхэд энэхүү зохицуулалтын хувилбарыг сонгосноор эрдэс баялаг уул уурхай, олборлолтын ил тод байдлыг хангах зорилгод хүрэх боломжгүй байна.

Е. Захиргааны шийдвэр гаргах хувилбар

Зорилгод хүрэх байдал: Захиргааны шийдвэрүүд чухал боловч олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангахад дангаараа хангалтгүй юм. Учир нь ил тод байдал нь хууль эрх зүйн зохицуулалт, хариуцлагын механизм, олон нийтийн оролцоо, уг салбарт үйл ажиллагаа явуулж буй компанийн заавал дагаж мөрдөх шинжтэй журмуудыг багтаасан цогц, олон талт арга хэмжээг шаарддаг. Захиргааны шийдвэр нь хамрах хүрээ хязгаарлагдмал, улс төрийн нөлөөнд автдаг, хэрэгжилт нь сул байдаг зэрэг дутагдалтай байдаг.

Тухайлбал, захиргааны шийдвэрүүд нь ихэвчлэн түр зуурын үйлчлэлтэй, тухайн шийдвэрийг гаргасан албан тушаалтны үзэмжээс шалтгаалан хялбархан өөрчлөгддөг, хууль тогтоомжтой харьцуулбал хэрэгжилт нь хангалтгүй хэмжээнд байдаг. Жишээлбэл, захиргааны байгууллага, эрх мэдэлтнүүд нь захиргааны шийдвэрээр дамжуулан тодорхой бус, ойлгомжгүй, бүдэг зохицуулалтыг бий болгож, тэдгээрийг өөрийн ойлголт, үзэмжээр тайлбарлаж, эрх мэдлээ урвуулан ашиглах, ашиг хонжоо олох ч арга хэрэгсэл болгон ашиглах эрсдэлтэй юм.

Шаардлагатай хууль эрх зүйн орчин байхгүй бол ил тод байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг дараагийн удирдлагууд амархан өөрчлөх эсвэл үл тоомсорлож болно. Ил тод байдал нь бүх сонирхогч талуудад ил тод, хууль эрх зүйн хувьд заавал дагаж мөрдөх тогтолцоог шаарддаг. Мөн захиргааны шийдвэрүүд нь ихэвчлэн тодорхой асуудал эсвэл салбарыг хамардаг боловч лиценз, үйлдвэрлэл, орлогын удирдлага, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл зэрэг олборлох үйлдвэрлэлийн өртгийн сүлжээг бүхэлд нь хамарч чаддаггүй. Ил тод байдал нь нөөцийн олборлолт, хуваарилалтын бүх үе шатыг хамарсан цогц системийг шаарддаг.

Түүнчлэн захиргааны байгууллагууд шийдвэрээ үр дүнтэй хэрэгжүүлэх нөөц, чадавх, эрх мэдэл дутмаг байх ч нөхцөл байдаг. Ил тод байдлыг хангахын тулд хууль зөрчсөн тохиолдолд хяналт тавих, мөрдөн шалгах, хариуцлага тооцох чадвартай, нөөц бололцоо сайтай байгууллагууд шаардлагатай. Захиргааны шийдвэр дангаараа ил тод байдлыг хангахад чухал ач холбогдолтой олон

нийтийн мэдлэг, оролцоог хангаж чадахгүй. Олон нийтийн хяналт, оролцоо нь боловсролын кампанит ажил, хүртээмжтэй мэдээлэл, олон нийтийн оролцоо зэрэг идэвхтэй арга хэмжээг шаарддаг. Ил тод байдал нь засгийн газар болон компаниудад хариуцлага тооцох эрхийг иргэдэд олгохоос хамаардаг бөгөөд үүнийг зөвхөн захиргааны шийдвэрээр хэрэгжүүлэх боломжгүй юм.

Мөн түүнчлэн 2023 онд хийгдсэн Монголын уул уурхайн төслийн шийдвэр гаргах процессын авлигын эрсдэлийн зохицуулалтын үнэлгээ судалгаанд⁷⁴ “салбарын хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай харилцааны эрх зүйн зохицуулалтыг хуульд хэт ерөнхий байдлаар тусгасан эсхүл огт зохицуулалтгүй орхидгоос үүдэн тухайн харилцааг Засгийн газар болон салбарын яамны сайдын тушаалаар баталсан журмын дагуу зохицуулдаг практик нь салбарын хөгжилд эрх зүйн талаасаа эрсдэл дагуулж байна” гэж дүгнэсэн байна. Түүнчлэн энэхүү судалгаанд дурдсанаар энэ “практик нь байгаль орчны хамгаалалт, нөхөн сэргээлт, орон нутгийн оролцоо зэрэг чиглэлүүдээс гадна ил тод байдал, олон нийтийн хяналт, оролцоо зэрэг тулгуур ойлголтууд дээр ч түгээмэл” байгаа тухай дурдаад тухайлсан хуулийн зохицуулалт хийхгүйгээр “яамны сайдын тушаалаар журам баталж мөрдүүлэх нь тодорхой эрх ашиг, сонирхолд зохицсон өөрчлөлт оруулах, эсхүл шаардлагатай өөрчлөлтийг хийхгүй байх, эрх мэдэл нэг буюу цөөн хүний гарт төвлөрөх, цаашилбал зохицуулалт хомс орчинд авлига үүсэх, авлига өгөхөөс аргагүй нөхцөл бий болгох зэрэг олон тооны асуудал дагуулна гэж үзэж байна” гэсэн нь үндэслэлтэй төдийгүй уул уурхайн ил тод байдлыг хангах асуудлыг зөвхөн захиргааны шийдвэрийн хүрээнд зохицуулах нь асуудлыг шийдвэрлэх зорилгодоо хүрэх боломжгүй гэдгийг мөн нотолж байна.⁷⁵

Зардал, үр өгөөжийн харьцаа: Захиргааны шийдвэрүүд нь олборлох салбарын ил тод байдлыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг ч дангаараа хангалтгүй байдаг. Ил тод байдал нь цогц, зохион байгуулалттай арга хэмжээг шаарддаг. Захиргааны шийдвэрүүд нь эхлэлийн цэг болж болох ч ил тод байдлыг институцжуулах, засаглалын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, олборлох салбарын урт хугацааны хариуцлагыг хангах өргөн хүрээний стратегийн нэг хэсэг байх ёстой. Эдгээр нэмэлт арга хэмжээ авахгүй бол ил тод байдлын хүчин чармайлт богино хугацаатай, тогтвортой бус эсвэл үр дүнгүй болох эрсдэлтэй. Иймд энэхүү зохицуулалтын хувилбарыг ашигласнаар зорилгодоо бүрэх боломжгүй байгаа нь тодорхой байх тул зардал, үр өгөөжийн харилцааг тооцоолох шаардлагагүй гэж үзлээ.

Дүгнэлт: Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд авч үзэхэд энэхүү зохицуулалтын хувилбарыг сонгосноор эрдэс баялаг уул уурхай, олборлолтын ил тод байдлыг хангах зорилгод хүрч чадахааргүй байна.

⁷⁴ Монголын уул уурхайн төслийн шийдвэр гаргах процессын авлигын эрсдэлийн зохицуулалтын үнэлгээ, С.Борбил, Б. Мөнхтогтох, Байгалийн нөөцийн засаглалын Институт, УБ хот, 2023, 46 дахь тал https://resourcegovernance.org/sites/default/files/documents/mongolia_regulatory_assessment_corruption_risks_mining_sector_mon.pdf

⁷⁵ Жишээлбэл, дээрх судалгаанд дурдсанаар захиргааны байгууллага өөрийн урьд өмнө баталсан журамд заасан “тодорхойгүй шалтгаан”-аар өөрчилсөн олон тохиолдлын нэг нь ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын журамд 2022 онд оруулсан өөрчлөлтөөр урьд өмнө анх батлагдсан журамд байсан сонгон шалгаруулалтыг нийтэд зарлах хугацааг хассан жишээг дурджээ. Ингэснээр шинэ өөрчлөлтөөр сонгон шалгаруулалт хэзээ болох нь хугацааны хувьд тодорхойгүй болж энэ мэдээлэл олон нийтэд бус харин цөөн тооны шийдвэр гаргагчдын мэдэлд байх боломжтой болсон байна.

Ё. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар

Зорилгод хүрэх байдал: Уул уурхайн ил тод байдлыг хангах асуудлыг хууль батлах замаар шийдвэрлэх хувилбар нь урт хугацааны туршид үйлчлэх боломжтой заавал дагаж мөрдөх шинжтэй, хэрэгжилтийг нь хууль эрх зүйн албадлагын аргаар бүрэн хэмжээнд хангаж хэрэгжүүлэх боломжтой, ил тод байдлыг хангахад чиглэсэн институцлагдсан тогтолцоог бүрдүүлэх цорын ганц дүнтэй арга юм. Дээр дурдсан зохицуулалтын хувилбарууд болон сайн дураар дагаж мөрдөх стандарт, аргачлал боловсруулах, төрийн бус байгууллагаас гүйцэтгүүлэх болон захиргааны шийдвэр гаргах зэрэг хувилбараас ялгаатай нь аливаа хуулиар заавал дагаж мөрдөх шинжтэй, тухайн хуульд заасан зорилгод хүрэхэд чиглэгдсэн тодорхой хэм хэмжээ тогтоож, тухайн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж, туухайн хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг нь хангах цогц тогтолцоог бий болгодог.

Хуулиар уг асуудлыг зохицуулснаар уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн ил тод, нээлттэй байдлыг хангахад чиглэсэн заавал хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээнүүдийг тогтоогоод зогсохгүй, уг арга хэмжээнүүдийг тухайн салбарын бүх оролцогч талууд (засгийн газар, компаниуд болон бусад) тухайн дүрэм журмыг заавал дагаж мөрдөхийг баталгаажуулдаг. Энэхүү хувилбарын сайн дурын шинжтэй стандарт, санаачилга, захиргааны шийдвэрээс ялгаатай нь хууль тогтоомж нь дагаж мөрдөөгүй тохиолдолд торгууль, шийтгэл зэрэг эрх зүйн үр дагаварт хүргэдэг.

Хууль тогтоомж нь салбарын хэмжээнд нийтээр заавал дагаж мөрдөх шинж бүхий стандарт болон үүргийг бий болгож, ил тод байдлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зөрчил, хийдлийг багасгадаг. Түүнчлэн хууль тогтоомжид заасан ил тод байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ нь дотоодын болон гадаадын бүх компаниудад ижил тэгш өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлж, ил тод байдлын хэрэгжилтийг хянахад хялбар болгодог.

Дээрхээс гадна аливаа хууль тогтоомжийн арга хэрэгсэл нь захиргааны шийдвэр, сайн дурын шинжтэй аливаа стандарт, санаачилгатай харьцуулахад тэдгээрийг хүчингүй болгох, дур зоргоор өөрчлөх эсвэл санаатайгаар хэрэгжүүлэхгүй байх зэргийг илүү төвөгтэй болгодог нь уул уурхайн ил тод байдлыг хангах асуудлыг илүү урт хугацааны туршид шийдвэрлэх боломжийг олгодог. Хууль тогтоомж нь улс төрийн болон төрийн эрх мэдлийн хуваарилалтын өөрчлөлтөөс үл хамааран тогтвортой хэрэгжиж байдаг нь эрх баригчид хэн байхаас үл хамааран ил тод байдлын хүчин чармайлтын тасралтгүй байдлыг баталгаажуулдаг.

Хууль тогтоомжид засгийн газар, компаниуд, зохицуулагчид, иргэний нийгэм зэрэг янз бүрийн оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг нэг мөр тодорхойлж, тухайн харилцаанд оролцогч бүрийг эрх үүрэг тодорхой байх, оролцогчдод үүргээ ухамсарлах, нэг мөр биелүүлэх боломжийг олгодог. Энэ нь ил тод байдлыг арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх этгээд, тэдгээрийн эрх, үүргийг тодорхой байдлыг хангаж ил тод байдлыг хангах арга хэмжээнүүдийг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл байдлыг бий болгох ач тустай.

Хууль тогтоомж батлагдан гарснаар хууль тогтоомжоор ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангуулах чиг үүрэг бүхий байгууллага болон тогтолцоог бий болгох боломж илүү байдаг. Жишээлбэл, хуулиар ил тод байдлыг хангах үүргээ хэрэгжүүлээгүй зөрчлийг хэрхэн хянан шийдвэрлэх, уг үүргийн хэрэгжилтийг хэрхэн хангуулах, ямар албадлагын арга хэмжээ авах, хууль зөрчсөн үйлдэлд нь хариуцлага хүлээлгэх тогтолцоог бий болгох боломжтой.

Ил тод байдлын тухай асуудлыг хуулиар зохицуулснаар уул уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шат болох лиценз олгох, хайгуул хийхээс эхлээд олборлолт, орлогын хуваарилалт, байгаль орчны менежмент зэрэг олборлох үйлдвэрлэлийн өртгийн сүлжээний бүх үе шатыг хамарсан ил тод байдлыг хангахад чиглэсэн зохицуулалтыг тусгай боломжтой юм. Энэхүү цогц байдлаар асуудлыг шийдвэрлэх боломж уул уурхайн ил тод байдлыг илүү иж бүрэн байдлаар шийдвэрлэх боломжийг бий болгоно.

Хууль тогтоомж нь түүнчлэн уул уурхай, олборлох үйлдвэрлэлд холбогдох мэдээллийн нээлттэй байдлын үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх, тэр дундаа аливаа мэдээллийг хүртээмжтэй, ойлгомжтой, цаашид дахин ашиглахад хялбар байдлаар олон нийтэд нээлттэй болгох боломжийг нэмэгдүүлж байдаг. Энэ нь иргэд, иргэний нийгмийн байгууллагууд нээлттэй болсон байдлыг илүү дүнтэйгээр ашиглах замаар засгийн газар, компаниудад хариуцлага тооцох боломжийг олгодог.

Иймд олборлох салбарын ил тод байдлыг хангах асуудлыг хууль тогтоомжийн түвшинд шийдвэрлэх нь улс төр, аж ахуйн нэгжийн хөндлөнгийн оролцоонд тэсвэртэй, заавал дагаж мөрдөх, хэрэгжүүлэх боломжтой, институцлагдсан тогтолцоог бүрдүүлэх, олон улсын жишигт нийцүүлэн ил тод байдлын бат бөх суурийг бүрдүүлэх, хариуцлага, тогтвортой байдлыг урт хугацаанд хангах хамгийн үр дүнтэй арга гэж үзэхээр байна.

Зардал, үр өгөөжийн харьцаа: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зорилго бүхий хууль батлах нь зардал, үр өгөөжийн асуудлын аль алиныг хамарна. Хууль батлах үр өгөөж нь урт хугацаанд, ялангуяа засаглал, эдийн засгийн тогтвортой байдалд үүсч болзошгүй зардлаас илүү байна гэсэн төсөөлөл байна.

Төрд учрах зардлын хувьд хуулийг хэрэгжүүлэх зардал болон хуулийг сахиулахад гарах гэсэн үндсэн хоёр төрлийн зардал үүсэх боломжтой. Тухайлбал, ил тод байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх, тэдгээрийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай дэд бүтэц, тогтолцоог бүрдүүлэх, шаардлагатай боловсон хүчнийг сургах, мэдээллийн технологийн системийг бий болгох (жишээ нь, мэдээлэл цуглуулах, түгээх цахим платформууд г.м) зэрэгт тодорхой зардлууд шаардлагатай нь тодорхой юм. Жишээлбэл, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн эцсийн өмчлөлийн талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах олон нийтэд нээлттэй бүртгэлийг бий болгоход анхны хөрөнгө оруулалтаас гадна тухайн бүртгэлийн системийг хөтлөх, системийн засвар үйлчилгээнд шаардлагатай зардал зэрэг болно. Мөн түүнчлэн уул уурхайн ил тод байдлыг хангахад чиглэсэн хуулийг хэрэгжилтэд хяналт тавих, хууль сахиулахад чиглэсэн

арга хэмжээнүүд болон тодорхой хяналт шалгалтын арга хэмжээг хэрэгжүүлэх, хууль зөрчсөн зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, шийтгэх оногдуулах зэрэг нь санхүүгийн болон хүний нөөцийг онцгойлон шаардах нь мөн гарцаагүй юм.

Мөн түүнчлэн ил тод байдлыг хангах хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай институцыг бэхжүүлэх, хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавхыг бий болгох бэхжүүлэхэд ч мөн тодорхой зардал шаардлагатай. Дээрхээс гадна төрийн албан хаагчид, иргэний нийгэм, салбарын оролцогчдод хууль эрх зүйн шинэ шаардлагуудын талаар сургалт сурталчилгаа хийх шаардлага нь мөн тодорхой зардал, цаг хугацаа шаардана.

Хууль батлан гаргах үйл ажиллагааны эрсдэлийн хувьд уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд нь уг хуулиас болж тэдгээрийн үйл ажиллагааны зардал нэмэгдэх, бизнесийн нууц задрах зэрэг асуудлаас ил тод байдлын хуулийг эсэргүүцэж болох бөгөөд энэ нь хууль батлах үйл ажиллагаанд саад бэрхшээл учруулж болзошгүй юм. Мөн түүнчлэн уул уурхайн салбарын ил тод бус байдал, авлига, ил тод бус үйлдлээс ашиг хүртэж буй улстөрчид, нийгмийн тодорхой бүлэг уг хуулийг эсэргүүцэж, улс төрийн зөрчилдөөн, тогтворгүй байдалд хүргэж болзошгүй юм.

Үр өгөөжийн хувьд засаглал, хариуцлагын тогтолцоог сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулах бөгөөд ил тод байдал нь авлигыг бууруулах, хуулийн засаглалыг бэхжүүлэх, төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх ач тустай. Эдийн засгийн үр өгөөжийн хувьд уул уурхайн ил тод байдал нь авлигын эрсдэлийг бууруулж шударга өрсөлдөөнийг дэмжих замаар хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, уг салбарт хөрөнгө оруулалтыг татах, байгалийн нөөц ашигласны орлогын бүрдүүлэлтэд хяналт тавих боломжийг нэмэгдүүлснээр татвараас зайлсхийх боломжийг хумих санхүүгийн хууль бус эргэлтийг таслан зогсоох зэргээр засгийн газрын орлого нэмэгдүүлэх болон байгалийн нөөцийн үр ашигтай, тэнцвэртэй хуваарилалт, зарцуулалтыг дэмжихэд эерэг үр нөлөө үзүүлдэг төдийгүй олсон ашгийг үр дүнтэй зарцуулах нөхцөлийг бүрдүүлдэг.

Нийгэмд үзүүлэх үр өгөөжийн хувьд байгалийн нөөц ашиглах гэрээ, түүнээс бүрдүүлсэн орлого, уул уурхайн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй болгосноор иргэд шаардлагатай мэдээллээр хангагдаж засгийн газар болон компаниудыг хариуцлагажуулах тогтолцоо бүрдэх бөгөөд энэ нь уул уурхайн засаглалын чанарт эерэг нөлөө үзүүлнэ. Түүнчлэн ил тод байдал нь аливаа зөрчилдөөн, нөөцийн буруу менежменттэй холбоотой гомдлыг бууруулж, нөөцтэй холбоотой зөрчил, хурцадмал байдлаас урьдчилан сэргийлэхэд тусалдаг.

Үүнээс гадна ил тод байдлын тухай хууль батлагдсанаар уул уурхайн салбар нь олон улсын стандартууд, жишээлбэл Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОҮИТБС) зэрэг олон улсын стандартын дагуу үйл ажиллагаа явуулах боломж бүрдэж, олон улсын түншүүд болон хандивлагчдын зүгээс шаардлагатай санхүүгийн болон техникийн туслалцааг авах боломж нэмэгдэнэ.

Уул уурхайн ил тод байдал нь нийгэм, эдийн засгийн урт хугацаанд тогтвортой байдалд эерэг үр нөлөө авчрах бөгөөд бодлого боловсруулагчид болон шийдвэр

гаргагчдад найдвартай, үнэн зөв мэдээлэлд тулгуурлан зохистой шийдвэр гаргах боломжийг олгож, байгалийн нөөцийн засаглалыг сайжруулна.

Дээрхээс харахад уул уурхай, олборлох салбарт ил тод байдлыг хангах тухай хууль баталснаар үр өгөөж нь ерөнхийдөө гарч болзошгүй зардлаас, ялангуяа урт хугацаандаа, их байх төсөөлөл гарч байна. Хуулийн төслийг боловсруулах, хэрэгжүүлэх, хуулийг сахиулахад шаардлагатай зардал нь өндөр байж болох ч ил тод байдлыг хангасны үр дүнд засаглал, эдийн засгийн тогтвортой байдал, олон нийтийн итгэлцэл сайжирснаар өргөн цар хүрээтэй, тогтвортой үр өгөөжийг бий болгох боломжтой юм.

Дүгнэлт: Сайтар боловсруулсан, хэрэгжих боломжтой хууль нь ил тод байдлын тогтвортой тогтолцоог бүрдүүлж, олборлох салбарын урт хугацааны засаглал, эдийн засгийн тогтвортой байдлыг хангана. Үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг багасгахын тулд хуулийг хэрэгжүүлэх хүчтэй механизм, чадавхыг бэхжүүлэх хүчин чармайлт, олон талын оролцоотой байх ёстой. Зорилгод хүрэх байдал болон зардал, үр өгөөжийн харьцаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд авч үзэхэд энэхүү зохицуулалтын хувилбарыг сонгосноор эрдэс баялаг уул уурхай, олборлолтын ил тод байдлыг хангах зорилгод бүрэн хүрч чадахаар байна.

Ж. Хууль тогтоомжийн төслийн бүтэц, агуулга

Дараагийн шатанд Хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 5.5 дахь хэсэгт зааснаар асуудалд дүн шинжилгээ хийж, зохицуулалтын хувилбаруудыг сонгож тандан судлах явцад тухайн асуудлыг зөвхөн хууль гаргах замаар шийдвэрлэнэ гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд хууль тогтоомжийн төслийн бүтэц, агуулга, нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах шаардлагатай хууль тогтоомжийг ерөнхий байдлаар томъёолж бичих шаардлагатай.

Хуулийн төслийг бие даасан хууль хэлбэрээр эсхүл байгалийн баялаг ашиглахтай холбоотой харилцааг зохицуулаж буй холбогдох хууль тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэрээр боловсруулж болох боловч бие даасан анхдагч хууль хэлбэрээр боловсруулж, байгалийн бүхий л төрлийн баялгийг ашиглах үйл ажиллагааг хамруулснаар асуудлыг илүү цогц хэлбэрээр шийдвэрлэх, хуулийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих цогц тогтолцоог бүрдүүлэхэд ач холбогдолтой бөгөөд улмаар хуулийн хэрэгжилт нь илүү үр нөлөөтэй байх боломжтой.

Хуулийн төслийн бүтцийн хувьд ОУИТБС-ын бүхий л шаардлага, тэр дундаа ОУИТБС-ын үндэсний зөвлөл, ажлын алба болон олон талд оролцогчдын (ОТОБ) бүлэг зэргийг бүхэлд нь хамарч, тэдгээр бүтэц, тогтолцооны ил тод байдлыг хянах, зохицуулах байгуулах талаарх чиг үүрэг, эрх зүйн байдлыг олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах дээр дурдсан үндсэн шаардлагуудын хамт (үндсэндээ ОУИТБС-ын Шаардлагуудыг бүхэлд нь хуульчлах хувилбар) хамарсан байж болох боловч хуулийн өөр нэг хувилбар нь зөвхөн ил тод байдлыг хангахад шууд чиглэсэн үндсэн шаардлагуудыг хамарсан байдлаар боловсруулах боломжтой бөгөөд энэ нь мөн хуулийн хамрах хүрээтэй (зөвхөн

олборлох үйлдвэрлэлээс зогсохгүй байгалийн бүхий л төрлийн баялгийн ашиглалтын ил тод байдлыг хамрах) ч илүү нийцтэй байх боломжтой юм.⁷⁶

Төсөл нь доор дурдсан бүтэц, агуулгатай байх боломжтой:

1. Хуулийн зорилт: байгалийн баялаг ашиглалтын ил тод, хариуцлагатай байдал, засаглалыг сайжруулах, улмаар авлигын эрсдэлийг бууруулах, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих, байгалийн нөөц баялгийн орлогын тэгш хүртээмжтэй хуваарилалтыг бий болгох зэргийг багтаасан хуулийн зорилтыг тодорхойлно.

Мөн зорилтод байгалийн баялаг ашиглалтын ил тод байдлыг хангахад олон улсын шилдэг туршлага тэр дундаа ОУИТБС-ын стандарт, зарчмуудыг уг санаачилгад нэгдэн орсон орны хувьд үр нөлөөтэй хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагын талаар дурдаж болно.

2. Хуулийн хамрах хүрээ: хуулийн үйлчлэлд хамаарах салбаруудыг тодорхойлно. Тухайлбал, газрын тос, ашигт малтмал болон бусад эрдэс баялаг, ой, усны нөөц, ургамал, ан амьтан зэрэг байгалийн баялгийг ашиглах үйл ажиллагааг хамруулна.

Түүнчлэн энэхүү хуулийн үйлчлэлд хамаарах субъектүүдийн хувьд засгийн газар, байгалийн баялгийн ашиглалтыг зохицуулах, уг асуудлыг эрхэлсэн төрийн байгууллагууд, нутгийн өөрөө удирдах байгууллага, байгалийн баялаг ашиглах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн, хувийн, холимог өмчийн аж ахуйн нэгжүүд, төрийн чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн бус байгууллагуудыг хамруулах шаардлагатай.

Эрдэс баялаг уул уурхайн салбарын хувьд ОУИТБС-ын Стандартын дийлэнх хэсэг нь олборлох салбарын бүхий л компаниудад хамаатай бөгөөд хувийн болон төрийн өмчит компанийг хооронд нь ялган заагладаггүй. Гэвч олон улсад болоод Монголд олон ТӨК-иуд ажилладаг бөгөөд хуулийн этгээдийн хэлбэр, зохион байгуулалт болон үйл ажиллагааны чиглэлийн хувьд маш олон төрөлд хуваагддаг. Дотоодын хууль тогтоомжийн хувьд бүх аж ахуйн нэгжийг тодорхой мэдээллээ нээлттэй болгохыг үүрэг болгодог хэдий ч ТӨК-иудад ил тод байдлын нэмэлт шаардлага тавигддаг.⁷⁷ Иймд ТӨК-иудад тавигдах ил тод, нээлттэй байдлыг хангах шаардлага нь тэдгээрийн үйл ажиллагааны чиглэл, гүйцэтгэх үүрэг, тэдгээрийн засаглалын онцлогт тохирсон байх шаардлагатай нь тодорхой юм. Тухайлбал, хувийн аж ахуйн нэгжүүдийн хувьд зөвхөн төрд төлсөн татвар хураамж ногдол ашиг, роялти зэрэг бусад төлбөрүүдийг ил тод болгох шаардлагатай бол ТӨК-иудын хувьд эдгээрээс гадна төсөвт оруулсан, төсвийн зардлыг санхүүжүүлэх зорилго

⁷⁶ ОУИТБС нь хэдийгээр олон улсад нэр хүнд бүхий чухал санаачлагуудын нэг боловч энэхүү санаачлагад нэгдэх, зохих шаардлагуудын биелүүлэх эсэх нь сайн дурын шинжтэй бөгөөд Монгол Улсын нэгдсэн орсон олон улсын гэрээ биш юм. Иймд энэхүү сайн дурын механизмд дурдсан тогтолцоог албан ёсоор хуульчлан тогтоох хэрэгцээ шаардлагатай бий эсэх, үүнээс үүдэн гарах болзошгүй үр дагавруудыг мөн тооцоолж, уг асуудлыг шийдвэрлэх оновчтой хувилбарыг сонгох нь зүйтэй.

⁷⁷ Монгол Улсын олборлох салбарын төрийн өмчит компаниудын ил тайлагналын нөхцөл байдлын судалгаа, Н.Дорждарь, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, УБ хот, 2024 оны 7 дугаар сар. 4 дэх тал. https://resourcegovernance.org/sites/default/files/2024-10/scoping_study_extractive_sector_soe_disclosures_mongolia-mn_0.pdf

бүхий улсын төсөвт шилжүүлсэн төлбөр, аливаа хөрөнгө оруулалт, төрийн чиг үүрэгтэй холбоотой зардлууд, авсан зээл, тэдгээрийг санхүүжүүлэх бүтэц, төрөөс авсан зээлийн баталгаа, төсвөөс хүлээн авсан бүхий л санхүүжилтийг ил тод болгох шаардлага тавигддаг. Мөн түүнчлэн ТӨК-иудын хувьд аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, засаглалын бүтэц, эрх бүхий байгууллага зэргийн талаарх мэдээллийг тогтмол ил тод болгох шаардлагатай бол хувийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн хувьд зөвхөн тэдгээрээс төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж зэргийг ил тод болгохыг шаарддаг бөгөөд засаглалын бүтцийг тэр болгон ил болгохыг шаарддаггүй.

Түүнчлэн зарим ТӨК-д ил тод байдлын шаардлага нь заримд нь хамаарахгүй харин хуулийн этгээдийн төрөл, үйл ажиллагааны онцлогоос шалтгаалж, тодорхой хэсэгт нь үйлчилж болно. Жишээлбэл Шилэн дансны тухай хууль нь төрийн өмчит болон төр дийлэнх хувийг эзэмшиж буй компаниудыг санхүүгийн тайлангаа шилэнд дансаар тайлагнахыг шаарддаг бөгөөд харин төр цөөн хувьцаа эзэмшдэг бол тайлагнах шаардлага тавьдаггүй.⁷⁸ Иймд ТӨК-иудын хувьд дээрх онцлогуудыг харгалзан хуулийн үйлчлэх хүрээг оновчтой тогтоох, ил тод байдлыг ханга арга хэмжээг хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжуудад заасан зохих зохицуулалтуудтай уялдуулах хэрэгцээ шаардлага гарна.

3. Хуульд хэрэглэгдэх нэр томьёоны тодорхойлолтууд: тухайлбал, уул уурхайн салбар, олборлох үйлдвэрлэл, байгалийн баялаг, ил тод байдал, нээлттэй байдал, эцсийн өмчлөгч, гэрээ, тусгай зөвшөөрөл, ашиг, орлого, төлбөр, хураамж гэх мэт хуульд нийтлэг ашиглагдах, хуулийг нэг мөр хэлбэрэлтгүй хэрэгжүүлэхэд шаардлагатай нэр томьёоны тодорхойлолтуудыг багтаана.
4. Мэдээлэл ил тод болгох үүрэг: Засгийн газар, компаниуд болон байгалийн баялгийг ашиглахтай холбоотой үйл ажиллагаа эрхлэгч, бусад оролцогч талуудын заавал ил тод болгох мэдээлэл, мэдээллийг ил тод болгох үүргийг нэг бүрчлэн тусгана. Тухайлбал:

4.1. Орлого болон төлбөрийн ил тод байдал

Аж ахуйн нэгжүүдийн хувьд: татвар, хураамж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, урамшуулал зэрэг төрд төлсөн бүх төрлийн төлбөрийг ил тод болгох, олон нийтэд нээлттэй мэдээлэх

Засгийн газар болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хувьд: олборлох салбарын аж ахуйн нэгжүүдээс төлсөн, цуглуулсан бүх шатны төсөвт төвлөрүүлсэн бүх орлого, тэдгээрийн хуваарилалтыг ил тод болгох, энэ тухай тайланг жил бүр аудитаар баталгаажуулж, олон нийтэд мэдээлэх

Түүнчлэн олборлох үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний төрд ногдох биет хэлбэрээр төвлөрүүлсэн хэсэг, тэдгээрийг худалдан борлуулж олсон орлогын ил тод байдлыг хангах

4.2. Гэрээ болон тусгай зөвшөөрлийн ил тод байдал

⁷⁸ Өмнөхтэй ижил

Байгалийн нөөц ашиглалттай холбоотой бүхий л гэрээ, тэдгээрийн нэмэлт, өөрчлөлтүүд болон тусгай зөвшөөрлийн мэдээллийг нийтэд ил болгох. Тухайлбал,

- байгалийн нөөц ашиглах гэрээ болон тусгай зөвшөөрлийн нөхцөл болон хугацаа,
- гэрээ болон тусгай зөвшөөрлийг олгох болон хэлэлцэх үйл ажиллагаа
- гэрээнд заасан байгаль болон нийгэмд үзүүлэх нөлөөллийг зохицуулах заалтууд
- тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талаар нэр, хамрах талбай, олгосон огноо зэрэг болно.

Монгол Улсын гэрээний ил тод байдлын нөхцөл байдлын судалгаанд⁷⁹ дурдсанаар Монгол Улсад дараах төрлийн гэрээг нийтлэг ашиглаж байна. Үүнд: хөрөнгө оруулалтын гэрээ, хувьцаа эзэмшигчдийн гэрээ, орд ашиглах гэрээ, нөхөн төлбөрийн гэрээ, операторын үйлчилгээний гэрээ, хамтран ажиллах гэрээ, газар ашиглах гэрээ, ус ашиглах гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээ, тогтворжуулах гэрээ, санхүүжилтийн зохицуулалтууд, оффтейк гэрээ, төрийн өмчит компанийн худалдан авалтын гэрээ, экспортын борлуулалтын гэрээ, бартер солилцооны гэрээ, байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбоотой гэрээ зэрэг хамаарч байна.⁸⁰

Түүнчлэн Гэрээний мэдээллийн сан болон ОУИТБС-ын жилийн тайланд нийтэлсэн гэрээний дийлэнх нь орон нутгийн харилцаатай холбоотой⁸¹ нь тодорхой харагдаж байгаа бөгөөд Эдгээр гэрээ орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ, нийгмийн хариуцлагын гэрээ зэрэг өөр өөр нэртэй байна.

Мөн дээрхтэй зэрэгцүүлэн олборлох салбарт үйлчилж байгаа олон төрлийн гэрээ бүрийг бүрэн хэмжээнд баримтжуулах, гэрээний бүрэн жагсаалтыг бүрдүүлэх, гэрээг сайн дураар нийтлэхийг дэмжих тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлагатай.

4.3. Эцсийн өмчлөгчийн ил тод байдал

Байгалийн баялаг ашиглах гэрээ, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдүүдийн эцсийн өмчлөгчийг ил тод болгох болон эцсийн өмчлөгчийн цогц тодорхойлолтыг тодорхойлж, эцсийн өмчлөгчийн олон нийтэд нээлттэй бүртгэлийг бий болгох.

⁷⁹ Монгол Улсын гэрээний ил тод байдлын нөхцөл байдлын судалгаа. Н.Дорждарь, Н.Золжаргал.

Байгалийн нөөцийн засаглалын институт, УБ хот, 2024

https://resourcegovernance.org/sites/default/files/2024-10/scoping_study_contract_transparency_mongolia-mn.pdf

⁸⁰ Эдгээр гэрээний жагсаалт болон агуулга, тодорхойлолтыг дээрх судалгаанаас харна уу.

⁸¹ Уул уурхайн компаниуд, иргэд, тэдний төлөөлөгчдийн хооронд хийгддэг, ихэвчлэн “Олон Нийтийн Хөгжлийн Гэрээ”, “Нөлөөлөл, Үр Ашгийн Гэрээ” хэмээн нэрлэгддэг гэрээг хэрэглэх явдал уул уурхайн салбарт нэмэгдэж байна. Австрали, Канад зэрэг цөөхөн хэдэн орны уул уурхайн салбарын нутгийн иргэдтэй (Орон Нутгийн Уугуул Иргэд) гэрээ хийх явдал нь стандарт үйл явц болсон байхад, энэ нь байгалийн баялаг ихтэй хөгжиж буй олон орны хувьд харьцангуй шинэ зүйл юм.

Эцсийн өмчлөгчийг тодорхойлоход шаардлагатай шалгуур үзүүлэлтүүд тур дундаа холбогдох хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, удирдан чиглүүлэх, ашиг хүртэх зэрэг бүхий л шалгуурыг цогцоор нь багтааж хуулийн этгээдийн хувь, хувьцаа эзэмшлийн босгыг эцсийн өмчлөгчийн төрлөөс хамааран ялгавартайгаар тогтоох эсэхэд анхаарах. Тухайлбал, эцсийн өмчлөгчийг тогтоохдоо ОУИТБС-ын шаардлагын дагуу хуулийн этгээдийн хувь хувьцааны өмчлөлийн босгыг 10 хувь түүнээс доош байхаар тогтоох (одоогийн байдлаар 33 хувийн босгыг ашиглаж байгаа). Мөн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч нь улс төрд нөлөө бүхий этгээд, эсхүл түүний гэр бүлийн гишүүн, эсхүл хамаарал бүхий этгээд болох тохиолдолд эцсийн өмчлөгчийг тогтоох илүү хатуу буюу нарийвчилсан шалгуур тогтоох, эцсийн өмчлөгчийн мэдээллийг илүү нухацтай шалгаж нягтлах, нийтэд ил болгох тогтолцоог бүрдүүлэх зохицуулалтуудыг тусгах.

4.4. Үйлдвэрлэл, борлуулалт болон экспортын ил тод байдал

Эрдэс баялгийн үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, үнэ ханш, экспорт болон тээвэрлэлтийн орлого, зарлага, маршрут, тээвэрлэлтэд оролцогч аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл, экспортын хэмжээ, үнэ ханш болон хааш нь экспортолсон тухай мэдээллийг ил тод болгох

4.5. Эрдэс баялаг олборлох (ашиглах) үйлдвэрлэлийн төслийн ил тод байдал

Газрын тос, байгалийн хий, уул уурхайн төслийн зардлыг хянах, орлогын алдагдлын эрсдэлийг удирдах бодлого, туршлага, тэдгээрт холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, бодлого, түүнчлэн төслийн зардлыг хянах чиглэлээр авсан арга хэмжээний мэдээлэл, төслийн эцсийн зардал, татварын болон аудитын тайлан зэргийг ил тод болгох

4.6. Орлогын хуваарилалт болон зарлагын ил тод байдал

Байгалийн баялгаас олсон улсын төсөв болон орон нутгийн төсөв, бүх төрлийн сангуудад төвлөрүүлсэн орлогын хуваарилалт, зарцуулалтын болон энэхүү орлогоор хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, тэдгээрийн явцын мэдээлэл болон эрдэс баялгийн салбарын эдийн засагт үзүүлж байгаа үр нөлөөний талаарх мэдээллийг ил болгох.

4.7. Байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөний ил тод байдал

Байгалийн баялаг ашиглах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээс өөрсдийн үйл ажиллагааны байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах тайлан, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн мэдээлэл зэрэг байгаль орчин нийгэмд үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой мэдээллийн ил тод болгох, байгаль орчныг нөхөн сэргээх, байгаль хамгаалах сангуудад төлсөн төлбөр болон

нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн санаачилгууд болон хандив тусламжид зарцуулсан төлбөрүүдийг ил тод болгох⁸².

4.8. Хууль эрх зүй, татварын орчин, шийдвэр гаргах процессын ил тод байдал

Эрдэс баялгийн салбарыг зохицуулж буй хууль эрх зүйн орчин, холбогдох татвар хураамжийн дэглэм, олборлох салбарын авлигаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой хууль тогтоомж, газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын хайгуул, ашиглалтыг зохицуулах төрөл бүрийн гэрээ, тусгай зөвшөөрлийн тодорхойлолт; төрийн холбогдох байгууллагуудын үүрэг, хариуцлагын талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах.

Мөн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах болон тусгай зөвшөөрөл олгох процессыг илүү нээлттэй, ил тод болгох, уг ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, шийдвэр гаргах журам, үндэслэл, хугацаа болон шалгуурыг нарийвчлан зохицуулж тодорхой болгосноор шийдвэр гаргах процесс илүү нээлттэй, ил тод болох боломжтой.

Түүнчлэн эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд болон олон нийт, иргэний нийгмийн төлөөллийг эрдэс баялгийн салбарын засаглал, түүний ил тод байдлыг хангахтай холбоотой шийдвэр гаргах явцад идэвхтэй оролцуулах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн зохицуулалтуудыг тусгах

5. Хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг (ой, ойн дагалт баялаг, усны нөөц, ургамал, ан амьтан г.м) ашиглах үйл ажиллагаа нь эрдэс баялаг уул уурхайн салбараас ялгаатай тул ил тод байдлыг хангах тодорхой шаардлага, арга хэмжээний хувьд тусад нь томъёолох шаардлагатай хэдий ч өмнөх хэсэгт заасан арга хэмжээний дийлэнх нь байгалийн бүх төрлийн баялгийг ашиглахад ач холбогдолтой.

Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийн ашиглалтын ил тод байдлын хувьд дээрхээс гадна байгалийн баялгийг ашиглуулах шийдвэр гаргах үйл ажиллагаа, тэдгээртэй холбоотой төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр (эрх, зөвшөөрөл олгоход шаардлагатай шат шатны байгууллага, албан тушаалтнаас гаргадаг санал, дүгнэлт г.м), тэдгээрийн үндэслэл, ашиглах болон ашигласан байгалийн баялгийн төрөл, хэмжээ зэргийг ил тод болгоход түлхүү анхаарах шаардлагатай.

6. Ил тод байдлыг хэрэгжүүлэх, хяналт тавих тогтолцоо: ил тод байдлыг хэрэгжүүлэх, зохион байгуулах, хяналт тавих бүтэц, тогтолцоог тодорхой болгох, шаардлагатай бол бие даасан бүтцийг бий болгож, эрх хэмжээг тодорхой болгох шаардлагатай.

Тухайлбал, төр болон хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоотой тогтолцоог бүрдүүлж, түүнд ил тод байдлыг хэрэгжүүлэх, хяналт тавихад шаардлагатай эрх хэмжээг болгож, компаниуд болон засгийн газраас

⁸² Одоогийн байдлаар байгаль орчныг хамгаалах эдгээр баримт бичгийг нийтлэх хугацааг тодорхой заагаагүй, мөн нийтлэхгүй тохиолдолд авах арга хэмжээ тодорхой бүс байна. Одоогоор зөвхөн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг www.eic.mn вэбсайтаас авч болно. Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах тайлан нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэдэлд байдаг бөгөөд одоогоор нийтэд зориулж хэвлээгүй байна.

тайлагнасан төлбөр, орлогыг нэгтгэх, хянах, баталгаажуулах бие даасан хараат бус тогтолцоог бий болгож мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангах зорилгоор тогтмол хараат бус аудит хийх, ил тод байдлын төрөлжсөн болон нэгдсэн тайланг тогтмол гаргах зэрэг чиг үүргийг тодорхой болгох нь зүйтэй.

Түүнчлэн компаниуд болон төрийн байгууллагаас мэдээлэл ил тод болгох хугацаа, давтамж, хэлбэрийг мөн тодорхой болгож, хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох нь хуулийн хэрэгжилтэд эергээр нөлөөлнө. Хариуцлагын хувьд торгууль оногдуулах, хуульд заасан үүргээ биелүүлээгүй компаниудыг нийтэд ил тод зарлах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах гэх мэт төрөл байх боломжтой.

7. Мэдээллийн хүртээмжтэй байдал: ил тод болгосон мэдээллийг аль болох нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр түгээх, тухайлбал, ил тод байдалд хамаарах бүхий л мэдээллийг багтаасан мэдээллийн төвлөрсөн цахим санг бий болгож ажиллуулах, түүнээс олон нийт мэдээллийг чөлөөтэй авах, судлах, дахин ашиглах (жишээлбэл, нээлттэй өгөгдөл хэлбэрээр түгээх), харьцуулах боломжийг хангах, мэдээллийг тогтмол цаг алдалгүй шинэчлэх, төрийн байгууллагуудын мэдээллийн сантай харилцан уялдааг хангах, тэдгээртэй автоматаар мэдээлэл солилцох зэрэг боломж нөхцөлийг цогцлоох шаардлагатай.

Ил тод байдлын мэдээллийн ач холбогдол, хэрэгцээ, ил болгосон мэдээллийг үр дүнтэй ашиглах болон олон нийт байгалийн баялаг ашиглалтад хэрхэн хяналт тавьж болох, шийдвэр гаргах процесст оролцох, олон нийтийн хяналтын үр нөлөөний талаар олон нийтэд сурталчлах, таниулах арга хэмжээ, чиг үүргийг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох нь хуулийн зорилгод нийцнэ.

Мөн түүнчлэн мэдээллийг хэрхэн ил болгох, түгээх талаар төрийн байгууллагууд болон компаниудын чадавхыг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалтыг тусгаснаар мэдээллийн чанар дээшлэх, ил болгож байгаа ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх боломж бий болно.

8. Мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангах: ил тод болгож буй мэдээллийн чанар болон үнэн зөв байдлыг хангах, мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавих, мэдээллийг баталгаажуулах (ил тод болгож буй мэдээлэлд аудит хийх, мэдээллийг боловсруулах холбогдох олон улсын стандартуудыг дагаж мөрдөх шаардлага г.м) цогц тогтолцоог бий болгох.
9. Ил тод байдлыг хангах чиглэлээр эрдэс баялгийн салбарын үүрэг: эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн, хувийн болон холимог өмчийн аж ахуйн нэгжүүд эрдэс баялгийн ашиглалтын ил тод байдлыг хангах үйл явцад бүрэн, идэвхтэй, үр дүнтэй оролцох, үйл ажиллагаандаа авлигаас урьдчилан сэргийлэх талаар төлөвлөгөө, хөтөлбөр хэрэгжүүлэх, тэдгээрийг олон нийтэд ил тод болгох, мэдээлэх

4. Хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдал

Энэхүү үе шатанд Хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 6-д заасны дагуу өмнө үе шатанд сонгож авсан зохицуулалтын хувилбарын үр нөлөөг тандан судална.

Судалгааны өмнөх шатанд дурдсанаар хуулийн төсөл боловсруулах нь асуудлыг шийдвэрлэх зорилгодоо хүрэх цор ганц боломжит зохицуулалтын хувилбар байна гэж дүгнэсэн тул энэхүү зохицуулалтын үр нөлөөг Хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу доорх хүснэгтүүдэд зааснаар тандан судаллаа.

А. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө
	1.2.Оролцоог хангах		
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага		
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		Хамааралгүй
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх		Хамааралгүй
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Хамааралгүй

3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		Хамааралгүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх		Хамааралгүй
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)		Хамааралгүй
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх		Хамааралгүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх		Хамааралгүй

Б. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Эерэгээр нөлөөлнө
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Үгүй	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Үгүй	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Үгүй	
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Үгүй	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө

	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Үгүй	
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Үгүй	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Үгүй	
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Үгүй	
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Үгүй	
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Үгүй	
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Үгүй	
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Үгүй	
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Үгүй	
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө

	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Үгүй	
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	

В. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Үгүй	
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Үгүй	
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Үгүй	
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Үгүй	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Үгүй	
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Үгүй	
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Үгүй	
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	

	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Үгүй	
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Үгүй	
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Үгүй	
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Үгүй	
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Эерэгээр нөлөөлнө

Г. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Үгүй	
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Үгүй	

3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Үгүй	
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Үгүй	
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Үгүй	
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Үгүй	

5.Хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийсэн байдал

Энэхүү шатанд Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 7.1-д зааснаар зохицуулалтын хувилбарын үр нөлөөг урьдчилан тандаж судалсны үр дүнд илрүүлсэн зохицуулалтын хувилбар тус бүрийн эерэг болон сөрөг үр нөлөөг хооронд нь харьцуулж дүгнэлт хийнэ.

Судалгааны өмнөх хэсэгт тэмдэглэснээр хуулийн төсөл боловсруулах хувилбар нь асуудлыг шийдвэрлэх зорилгодоо хүрэх боломжтой, үр өгөөжийн хувьд гарч болзошгүй зардлаас илүү байх цор ганц хувилбар байна гэж дүгнэсэн.

Доорх хүснэгтэд хуулийн төсөл боловсруулах хувилбарын зардал болон үр өгөөжийг харьцуулсан.

	Зардал	Үр өгөөж
Санхүүгийн нөлөөлөл	Хуулийн төсөл боловсруулах, хуулийг хэрэгжүүлэх болон хэрэгжилтэд хяналт тавихад шаардагдах анхны зардал өндөр байна	Орлого бүрдүүлэлт нэмэгдэж, авлигыг бууруулснаар урт хугацааны эдийн засгийн ашиг олно.
Засаглал	Хуулийн хэрэгжилт хангалтгүй байх болон хувийн ашиг сонирхлоос үүдэлтэй	Хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх, хариуцлагыг сайжруулах, дэлхийн

	эсэргүүцэл гарах эрсдэл байна.	жишигт нийцсэн ил тод байдлын тогтолцоо бий болно.
Нийгэмд үзүүлэх нөлөөлөл	Богино хугацааны улс төрийн эсэргүүцэл ба салбарын зүгээс эсэргүүцэл гарч болзошгүй.	Иргэд олон нийтийн байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаа, түүнээс олох орлого, түүний зарцуулалтад тавих боломж, чадавхыг бэхжүүлэх, иргэдийн байгалийн баялаг ашиглалтын талаарх ойлголт нэмэгдэх, улмаар иргэдээс гарах гомдол санал багасах, иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.
Чадавхтай тогтолцоо	Тогтолцооны чадавхыг бэхжүүлэх, техникийн хөрөнгө оруулалтад зардал шаардана.	Байгалийн баялгийг илүү үр дүнтэй удирдах чадвартай хүчирхэг тогтолцоо бий болно.
Тогтвортой байдал	Хуулийн хэрэгжилтийн хангалтгүй байдал нь хуулийн үр нөлөөнд сөргөөр нөлөөлж болзошгүй.	Институтчилэгдсэн ил тод байдал нь засаглал, эдийн засгийн урт хугацааны тогтвортой байдлыг хангана.

6. Олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 8.1-д хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар сонгогдсон тохиолдолд тухайн зохицуулалтын талаарх олон улсын эрх зүйн холбогдох зохицуулалт, бусад улсын адил төстэй хууль тогтоомжийн харьцуулсан судалгааг хийнэ гэж заасан.

ОУИТБС-ын гишүүн 55 орон олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангахад чиглэсэн тодорхой хууль эрх зүйн болон зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, Канад болон Украин улсууд олборлох салбарын ил тод байдлыг хангахад чиглэсэн бие даасан хуулиудтай байна.

Канад Улс

Канад Улсын хувьд Олборлох салбарын ил тод байдлыг хангах арга хэмжээний тухай (*Extractive Sector Transparency Measures Act (ESTMA)*⁸³) хууль нь газрын тос, байгалийн хий, ашигт малтмалыг “арилжааны зориулалтаар олборлох” салбарын оролцогч бизнес эрхлэгчид Канад болон гадаад дахь засгийн газарт төлсөн төлбөрөө тайлагнаж байхыг шаарддаг. ESTMA нь дэлхийн газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбарын ил тод байдлыг нэмэгдүүлэх, авлигыг бууруулах чиглэлээр 2013 онд болсон Их наймын удирдагчдын дээд хэмжээний уулзалтын үеэр бусад улстай хамтран Канадын өгсөн амлалтын хүрээнд батлагдан гарчээ.

⁸³ <https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/e-22.7/page-1.html>

ESTMA-д хамрагдах бизнесүүд дор хаяж таван жилийн хугацааг хамрах тайлангаа онлайнаар нийтлэх ёстой. Олон нийтийн төлөөлөл, эрдэмтэн судлаачид, төрийн бус байгууллага (ТББ), дэлхийн улс орнуудын засгийн газрууд болон уул уурхай эрдэс баялгийн салбарын мэргэжилтнүүд ESTMA-ийн өгөгдлийг ашиглан байгалийн баялгаас олсон орлогын талаарх тодорхой, найдвартай мэдээлэл авах боломжтой байдаг. ESTMA-ийн зохицуулалтын тойм, тайлагнах үүргийн талаарх мэдээллийг доор хураангуйлав.

Хамрах хүрээний хувьд “газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын арилжааны зориулалтаар ашиглах” гэдэгт хайгуул, ашиглалт буюу олборлолт, түүнчлэн эдгээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, түрээс, лиценз эсвэл бусад зөвшөөрөл авах, эзэмших зэрэг орно. Үүнд түүхий тос, битум, занарын тосны үйлдвэрлэл; байгалийн хий ба түүний дайвар бүтээгдэхүүн; мөн байгалийн бүх металл, металл бус ашигт малтмал хамаардаг байна. Харин хуулийн үйлчлэх хүрээнд барилга байгууламж, тоног төхөөрөмж үйлдвэрлэх, боловсруулах, хайлуулах, маркетинг, түгээх, экспортлох зэрэг олборлолтын дараах үйл ажиллагаа зэрэг туслах үйлчилгээ ордоггүй байна.

Дараах аж ахуйн нэгжүүд ESTMA-ын үйлчлэх хүрээнд:

а. Канадын хөрөнгийн биржид бүртгэлтэй, эсхүл

б. Канадын хөрөнгийн биржид бүртгэлгүй боловч Канадад бизнес эрхэлдэг, Канадад бизнес эрхэлдэг эсвэл Канадад хөрөнгөтэй бөгөөд хамгийн сүүлд байгуулсан санхүүгийн хоёр жилийн аль нэгэнд нь дараах босгын хоёрыг хангасан:

- Доод тал нь 20 сая канад долларын хөрөнгөтэй байсан
- Хамгийн багадаа 40 сая канад долларын орлого олсон
- Дунджаар хамгийн багадаа 250 гаруй ажилтантай

газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын арилжааны чиглэлээр шууд болон өөрийн хяналтад байдаг байгууллагаар дамжуулан үйл ажиллагаа явуулдаг аливаа корпораци, итгэлцэл, нөхөрлөл эсвэл бусад хуулийн этгээд хамаарна.

Түүнчлэн зарим аж ахуйн нэгжүүд өөрсдөө газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын арилжааны чиглэлээр шууд үйл ажиллагаа явуулдаггүй, харин хяналтандаа байдаг өөр аж ахуйн нэгжээр дамжуулан дээрх үйл ажиллагааг явуулдаг бол ESTMA-ын үйлчлэлд мөн хамрагдана. Энэхүү хуульд заасан “хяналт” нь шууд хяналтаар хязгаарлагдахгүй бөгөөд “шууд бусаар хянах, хяналтандаа байлгах” бүх хэлбэрийг хамаарна.

Дээрх шалгуурыг хангаж байгаа эсэхийг тодорхойлохын тулд аж ахуйн нэгжүүдийн хамгийн сүүлийн хоёр жилийн санхүүгийн тайланд үндэслэн тогтооно. Жишээлбэл, аж ахуйн нэгжийн санхүүгийн жил 1-р сарын 1-ээс 12-р сарын 31-ний хоорон дахь хугацааг хамаарч байгаа бол 2024 оны 12-р сарын 31-ний өдрөөс хойш 2024 оны тайлангаа ирүүлэх эсэхийг тодорхойлохын тулд тухайн ахуйн нэгж нь 2024 оны 12-р сарын 31-ээр эсвэл 2023 оны 12-р сарын 31-нд дуусаж байгаа санхүүгийн жилийн аль нэгний хугацаанд дээрх шалгуурыг хангасан эсэхийг тодорхойлох ёстой. Хэрэв аж ахуйн нэгж тухайн хоёр жилийн

аль нэгэнд шалгуурыг хангасан бол 2024 оны санхүүгийн жил дуусгаснаас хойш 150 хоногийн дотор хуульд заасан тайлан мэдээг гаргаж өгөх шаардлагатай болно.

Хэрэв бизнес дээрх шалгуурыг хангасан бол Канадын Байгалийн нөөцийн газар (Natural Resources Canada)⁸⁴ бүртгүүлж, дараах гурван шалгуурыг хангасан төлбөрөө тайлагнах ёстой. Үүнд:

- “Төлбөр хүлээн авагч”-д төлсөн (төлбөр хүлээн авагч хэсгийг үзнэ үү)
- Газрын тос, хий эсвэл ашигт малтмалыг арилжааны зорилгоор ашиглах буюу олборлох үйл ажиллагаанд хамаарна
- Дор хаяж доор дурдсан аль нэг ангилалд хамаарах бөгөөд хэмжээний хувьд 100,000 канад доллараас их:
 - Татвар (хэрэглээний болон хувь хүний орлогын албан татвараас бусад)
 - Роялти
 - Төлбөр (түрээсийн төлбөр, хураамж, зохицуулалтын хураамж, түүнчлэн тусгай зөвшөөрөл, концессын хураамж эсвэл бусад төлбөр орно)
 - Үйлдвэрлэлийн эрх
 - Урамшуулал (гарын үсэг зурах, нээлт, үйлдвэрлэлийн урамшуулал орно)
 - Ногдол ашиг (энгийн хувьцаа эзэмшигчийн хувьд Төлбөр төлөгчдөд олгосон ногдол ашгаас бусад)
 - Дэд бүтцийг сайжруулах төлбөр

Төлбөр хүлээн авагчийг дараах байдлаар тодорхойлсон байна:

- Канад болон гадаадад аль ч засгийн газар
- Хоёр ба түүнээс дээш Засгийн газрын хамтран байгуулсан байгууллага
- Канад болон гадаадын засгийн газрын чиг үүрэг, эрх мэдэл, үүргийг төлөөлөн гүйцэтгэдэг аливаа холбоо, зөвлөл, комисс, корпораци, байгууллага эсвэл бусад хэлбэрийн хуулийн этгээд

"Засгийн газар" гэж ерөнхийд нь Канад болон гадаадад байгаа аливаа засгийн газрыг ойлгоно гэж тодорхойлдог. Үүнд холбооны, муж, бүс нутгийн засгийн газар түүнтэй адилтгах байгууллага, хотын болон уугуул иргэдийн өөрөө удирдах байгууллага гэх мэт орно. Канад болон Европын холбоо ижил төстэй өргөн хүрээтэй тодорхойлолтыг ашигладаг байна.

Мэдээлэх үүрэг бүхий бизнесүүд нь тэдгээрийн хэрэгжүүлж байгаа төсөлд дэмжлэг үзүүлэх, төслийг үргэлжлүүлэх, эсхүл төслийг эсэргүүцэхгүй байх зэрэг нөхцөлтэйгөөр төлбөр хүлээн авагчид төлбөр төлж болох ба хэрэв эдгээр төлбөрийг хийгээгүй тохиолдолд төсөл цаашид үргэлжлэх боломжгүй байсан эсхүл төлбөрийн хэмжээ, хугацаа болон давтамжийг төлбөр хүлээн авагч тогтоодог бол эдгээр төлбөрийг тайлагнах үүрэгтэй.

⁸⁴ <https://natural-resources.canada.ca/home>

Эдгээр “нийгмийн төлбөр” (social payments) нь газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын олборлолт, эсхүл түүний нөхцөлтэй шууд холбоотой бол хуулийн дагуу тайлагнах шаардлагатай. Төлбөрийг төлбөр бүрийн баримт, нөхцөл байдалд үндэслэн ангиана.

Бэлнээс бусад хэлбэрээр хийгдсэн төлбөрийг биет хэлбэрээр хийсэн төлбөр (in-kind payments) гэж үзэх бөгөөд ESTMA-ийн дагуу тайлагнах ёстой. Биет хэлбэрээр хийсэн төлбөрийн мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх өртгийг тодорхойлон тайлагнах ёстой ба хэрэв өртгийг тодорхойлох боломжгүй зах зээлийн бодит үнийг баримтлан мөнгөн дүнг тодорхойлж тайлагнана.

Тайлангийн хувьд гурван төрлийн ESTMA тайлан байна:

- Бие даасан тайлан (individual report):: Эдгээрийг нэг бизнес жил бүр гаргадаг бөгөөд сүүлийн санхүүгийн жилийн хугацаанд төлбөр хүлээн авагчид төлсөн дээр дурдсан шалгуурыг хангасан төлбөрийг багтаана.
- Нэгдсэн тайлан (consolidated report): Зарим толгой компаниуд сүүлийн санхүүгийн жилд хийсэн тайлагнаж болох төлбөрүүд болон охин компаниудын хийсэн тайлангуудыг багтаана.
- Орлон тайлан (substituted report): Эдгээрт өөр улс орнуудын ижил шаардлагад нийцүүлэн бэлтгэсэн тайлангуудыг ойлгоно. Жишээлбэл, зарим тохиолдолд бизнесүүд эдгээрийг ашиглан ESTMA-ийн дагуу тайлагнах шаардлагаа биелүүлж, тайлагнах ачааллаа бууруулах боломжтой.

Канадын Байгалийн нөөцийн газраас Канадын Статистикийн газартай хамтран гаргасан ESTMA мэдээллийн портал⁸⁵ нь сүүлийн таван жилийн ESTMA мэдээллийг нэг онлайн байршилд нэгтгэдэг. Портал нь хэрэглэгчдэд ESTMA төлбөрийн мэдээллийг аж ахуйн нэгж, төлбөр авагч болон төслөөр хайх боломжийг олгодог бөгөөд хэрэглэгчдэд ESTMA мэдээллийн багцыг бүрэн ашиглахад туслах аналитик функцээр өгөгдлийг баяжуулдаг. Цаашид дүн шинжилгээ хийхийн тулд өгөгдлийг CSV форматаар татаж авах боломжтой.

Олборлох салбарын ил тод байдлын арга хэмжээний тухай хууль (ESTMA)-ийн Комплаенс хөтөлбөр нь мэдээллийн бүрэн бүтэн байдал, хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Бүртгүүлээгүй эсвэл тайлангаа ирүүлээгүй ESTMA-ийн хүрээнд хамаарах бүх аж ахуйн нэгжид нийцлийн баталгаажуулалт хийх, хууль хэрэгжүүлэх шаардлага хүргүүлэх, хууль хэрэгжүүлэх арга хэмжээ авах боломжтой.

ESTMA Комплаенс хөтөлбөр⁸⁶ нь өгөгдөлд дүн шинжилгээ хийх, аж ахуйн нэгжийн мэдээллийг ирүүлсэн хянах, газар дээр нь хянаж баталгаажуулах, олон нийттэй хамтран ажиллах зэрэг арга ажиллагааг ашиглан ESTMA-ийн мэдээлсэн мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг сайжруулах зорилготой бөгөөд дараах элементүүдээс бүрдэнэ:

⁸⁵ <https://www150.statcan.gc.ca/n1/pub/71-607-x/71-607-x2022008-eng.htm>

⁸⁶ <https://natural-resources.canada.ca/minerals-mining/services-for-the-mining-industry/extractive-sector-transparency-measures-act/compliance-and-verification/25149>

- Өгөгдлийн баталгаажуулалт - ESTMA өгөгдөл дахь болзошгүй алдааг хянах, мэдээллийн үнэн зөв байдлыг сайжруулахын тулд тасралтгүй өгөгдлийн аналитик процессуудыг ашигладаг.
- Комплаенс шалгалт – аж ахуйн нэгж, тэдгээрийн үйл ажиллагаанд тулгуурласан тодорхой аж ахуйн нэгжийн ирүүлсэн тайлан мэдээнд нийцлийн шалгалт хийх, ирүүлсэн мэдээллийн үнэн зөв байдлыг хангах зорилгоор ярилцлага хийх, газар дээрх шалгалт гэх мэт нэмэлт ажиллагааг багтааж болно. Комплаенс шалгалт нь гомдол мэдээлэл болон эрсдэлд суурилсан хяналт-шинжилгээний хослуулсан аргыг хэрэгжүүлдэг байна.
- Комплаенсыг дэмжих – тайлагнах үүрэг болон тайлагнах үед гардаг нийтлэг алдааны талаар аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл өгөх, Хуулийн хэрэгжилтийн чиг хандлага, тайлангийн нийтлэг алдааны талаарх статистик мэдээллийг тогтмол нийтэлдэг.

Украин Улс

Тус улс 2018 онд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах тухай бие даасан хууль (Law “On Ensuring Transparency in the Extractive Industries⁸⁷)-ийг баталсан бөгөөд энэ нь ОУИТБС-ын Шаардлагууд болон энэ талаарх бусад улсуудын сайн туршлагуудыг тус улсад хэрэгжүүлэх зорилготой байна. Энэ хууль нь Украины олборлох үйлдвэрлэлийн талаарх мэдээллийг цуглуулах, задруулах, түгээх эрх зүйн зарчмуудыг тодорхойлсон. Энэ нь төслийн түвшинд төлбөр тооцоог ил тод болгох, компаниудын эцсийн ашиг хүртэгч буюу өмчлөгчдийг ил тод болгох, нийгмийн үүрэг хариуцлага, дэд бүтэц барих, бартерын зохицуулалт зэрэг олборлох үйлдвэрлэлтэй холбоотой гэрээний “материаллаг” элементүүдийг ил тод болгох зохицуулалтыг агуулсан байна.

Тухайлбал, хуульд дараах шаардлагыг тусгажээ:

- Гэрээний ил тод байдал: 11 дүгээр зүйлд тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, олгогдсон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, газрын хэвлийг ашиглах гэрээний үндсэн нөхцөл, хугацааны талаарх мэдээллийг нийтлэх;
- Төслийн түвшний ил тод байдал: 6-р зүйлд төслийн үйл ажиллагаа тус бүртэй холбоотой төлбөрийн нийт хэмжээ, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (түрээсийн төлбөр), газрын төлбөр, байгаль орчны албан татвар зэрэг төлбөрийн төрөл бүрийн мэдээлэл, төсөл бүрийн үйлдвэрлэл буюу олборлолтын мэдээлэл, төрөөс авсан тусламжийн мэдээллийг нийтлэх;
- Эцсийн өмчлөгчийн ил тод байдал зэрэг болно.

87

https://eiti.org/sites/default/files/attachments/ukraine_law_6229_on_ensuring_transparency_in_extractive_industries.pdf

Түүнчлэн олборлох салбарын үйл ажиллагааны талаар энэ хуульд заасны дагуу мэдээллээ ил тод болгоогүй, мэдээлэл ил тод болгох нөхцөлийг зөрчсөн, түүнчлэн дутуу мэдээлэл өгсөн бол хариуцлага хүлээлгэхээр хуульд заасан.

7.Зөвлөмж

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 9.1-д заасны дагуу өмнөх хэсгүүдэд сонгосон зохицуулалтын хувилбаруудыг харьцуулан судалсны үндсэн дээр зөвлөмж гаргах ба уг зөвлөмжид хамгийн үр дүнтэй хувилбарыг санал болгож, тухайн хувилбарыг хэрэгжүүлэх шат дараалал, бусад хувилбартай хамт, эсхүл хавсран хэрэгжүүлэхэд илүү үр нөлөөтэй байж болох эсэх талаар тусгана.

Энэхүү тайлангийн 3-д зааснаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах зохицуулалтын хувилбар нь асуудлыг шийдвэрлэх хамгийн тохиромжтой буюу оновчтой хувилбар гэж дүгнэсэн бөгөөд энэхүү хувилбарыг “Хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1.2-д заасан “хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх”, 5.1.5-д заасан “төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх” болон 5.1.6-д заасан “захиргааны шийдвэр гаргах” хувилбаруудтай хамт, хослуулсан хэрэглэх нь асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй зохицуулалтыг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэнэ.

Тухайлбал “хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх” хувилбар нь иргэд олон нийтийн уул уурхайн үйл ажиллагаа, түүний үр нөлөөний талаарх мэдлэг, тулгамдаад буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга замуудын талаарх тэдгээрийн ойлголтыг нэмэгдүүлэх, бэхжүүлэх, иргэдийн шийдвэр гаргах ажиллагаанд оролцох боломжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд үүний үр дүнд иргэд уул уурхай, олборлох үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэрхэн үр дүнтэй ашиглах боломж илүү нэмэгдэнэ. Мөн “төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх” хувилбарыг ил тод, нээлттэй байдлыг хангах аль нэг үе шат, тодорхой ажиллагааны үед хэрэглэх нь ил тод, нээлттэй байдлыг бүрдүүлэхэд олон нийтийн оролцоог хангах, олон нийтийн хяналтыг бэхжүүлэх, шаардлагатай мэдлэг, чадавх бүхий төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөллийг оролцоог хангах замаар төрд учрах зардлыг хэмнэх зэрэг ач холбогдолтой байж болох юм. Жишээлбэл, ил тод, нээлттэй байдлыг хангах ажиллагаанд бие даасан хараат бус олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, мэдээллийн үнэн зөв, баталгаатай байдлыг хангахад чиглэсэн зарим чиг үүргийг (мэдээллийн баталгаажуулалт, аудит г.м) төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоотой гүйцэтгүүлж болох юм. Түүнчлэн “захиргааны шийдвэр гаргах” хувилбар нь хуулиар олгосон тодорхой чиг үүргийн хүрээнд захиргааны байгууллагаас нарийвчилсан зохицуулалт бүхий шийдвэр гаргах үед ашиглагдаж болох бөгөөд энэ нь Засгийн газар, түүний аль нэг гишүүнд ил тод, нээлттэй байх зарим төрлийн мэдээллийн нарийвчилсан жагсаалтыг батлах гэх мэт байдлаар үндсэн зохицуулалтын хамт хослон хэрэгжиж болох юм. Мөн түүнчлэн “зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх” хувилбарыг төрөөс ил тод, нээлттэй байдлыг хангах үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байгаа аж ахуйн

нэгжийг ямар нэгэн байдлаар урамшуулах, олон нийтэд зарлах, хяналт шалгалтын аль болох бага арга хэмжээнд хамруулах, шаардлагатай бол аль нэг хэмжээгээр давуу байдал олгох гэх зэргээр хуулийг биелүүлэх хүсэл зориг, сэдлийг бий болгох зохицуулалтаар дамжуулан үндсэн хувилбартай хослуулан хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай.

Хууль тогтоомжийн төслийн бүтэц, ерөнхий агуулгыг энэхүү тайлангийн **3.Ж**-д тодорхойлсон.

Хуулийн төсөл боловсруулах хувилбарыг хэрэгжүүлэх шат дараалал, хуулийн төслийг боловсруулахад доорх асуудлуудыг анхаарч, тэдгээрийг шийдвэрлэх, хэрэгжүүлэх үр дүнтэй арга замыг тодорхойлох нь асуудлыг шийдвэрлэх зорилгодоо бүрэн хүрэх, үүнд чиглэсэн зохицуулалтын үндсэн хувилбарыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Үүнд:

- Хуулийн төслийг уул уурхай, байгаль орчны салбарт хийх эрх зүйн шинэ зохицуулалтын алхмуудтай (тухайлбал, Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 69-д заасан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга, 72-д заасан Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл г.м) нийцүүлэх, хүчин төгөлдөр үйлчилж байгаа энэхүү тайлангийн 2 дугаар хавсралтад заасан хууль тогтоомж, тэдгээрт байгаа мэдээлэл авах эрх, ил тод байдлын талаарх зохицуулалтуудтай уялдуулан боловсруулах
- Төсийн хамрах хүрээний хувьд уул уурхай эрдэс баялгийн салбар болон байгалийн нөхөн сэргээгдэх баялгийг ашиглах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн, түүнчлэн төрийн өмчийн, эсхүл төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийг тэдгээрийн үйл ажиллагааны цар хүрээ, өмчийн хэлбэр, тэдгээрийн засаглалын онцлог, тэдгээрийн үйл ажиллагаан дахь төрийн оролцоо зэргийг харгалзан аль болох өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжүүдийг хамруулах

Түүнчлэн хамрах хүрээг тодорхойлохдоо уг хууль нь эрдэс баялаг уул уурхайн салбарт олборлох үйл ажиллагаа эрхэлж байгаа Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль болон бусад хуульд заасан хэлбэр, хугацаа, хамрах хүрээний дагуу байгалийн бүхий л баялгийг ашиглахтай холбоотой үйл ажиллагаа явуулдаг бүхий л аж ахуйн нэгжүүдийг ашиг орлогын хэмжээнээс үл хамааран бүгдэд нэгэн адил үйлчлэх эсэх, түүнчлэн ашиг орлогын хэмжээнээс хамааран ил тод, нээлттэй байдлыг хангах үүрэг, тухайлбал, мэдээлэх үүргийн давтамж, хамрах хүрээг ялгавартай тогтоох нь тогтмол бус үйл ажиллагаатай жижиг аж ахуйн нэгжүүдэд ирэх ачааллыг зөв тогтоох, тэдгээрт хамаарах эрсдэлийн түвшинд тохирсон зохицуулалтыг бий болгох боломжтойг анхаарах

- Хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах байгалийн баялгийн төрлийн хувьд газрын тос болон ашигт малтмал (алт, зэс, нүүрс, уран г.м.) олборлох үйл ажиллагаа нь байгалийн бусад баялаг болох ой, усны нөөц, ургамал, ан амьтан зэргийг ашиглахаас ялгаатай бөгөөд ил тод байдлыг хангах шаардлагын хувьд мөн ялгаатай авч үзэх үндэслэлтэй байхыг үгүйсгэхгүй юм. Иймд хуулийн хамрах хүрээнд багтах байгалийн баялгийн

ашиглалтын онцлогт тохируулан ил тод байдлыг хангах арга хэмжээ, эрх үүргийг оновчтой тогтоох

- Уул уурхай эрдэс баялгийн салбар, байгалийн бусад баялгийн ашиглалтаас олж буй орлого, татвар, хураамж, уг салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн зүгээс төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудад төлж буй бүхий л хэлбэрийн төлбөр, хандив тусламж, тэдгээрийн зарцуулалтын мэдээллийг тогтмол, үнэн зөвөөр мэдээлэх тогтолцоог бүрдүүлэхэд онцгой анхаарах. Тухайлбал, төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд аж ахуйн нэгжүүдээс төвлөрүүлсэн бүхий л төлбөрийн төлбөр, хандив тусламж, тэдгээрийн зарцуулалтыг тогтмол мэдээлэх үүргийг бий болгох, эдгээр хандив тусламжийн орлогыг тайлагнах, хяналт тавих одоо ашиглагдаж буй зохицуулалтууд (жишээлбэл, Сангийн яамны г.м), мэдээллийн системүүдийг ашиглах, тэдгээрийг улам боловсронгуй болгох
- Мэдээллийн баталгаатай, хангалттай, үнэн зөв байдлыг найдвартай хангахад чиглэсэн зохицуулалтыг бий болгоход онцгой анхаарах. Тухайлбал, дээр дурдсанчлан төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын мэдээлэх, тайлагнах үүргээс гадна уул уурхай эрдэс баялгийн салбарын аж ахуйн нэгжүүдээс ирүүлэх ялангуяа санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, баталгаажуулах, мэдээллийг түргэн шуурхай, тогтмол шинэчлэх, үнэн зөв байдлыг шалгах, зөрүүтэй байдал болон зөрчил илэрсэн тохиолдолд хэрхэн хянан шийдвэрлэх, ямар арга хэмжээ авах, татвар болон гаалийн байгууллагын цуглуулж боловсруулсан мэдээлэлтэй хэрхэн уялдах зэрэг асуудлыг анхаарч, боломжтой бүхий л тохиолдолд аж ахуйн нэгжүүдийн мэдээлэх үүргийг хялбарчлах, мэдээллийн үнэн зөв байдлыг хангах зорилгоор төрд байгаа уул уурхайн салбар, тэдгээрийн оролцогчидтой холбоотой мэдээллийн системүүдийн уялдаа холбоог хангах, нэг системд цугларсан баталгаажсан мэдээллийг бусад системүүд харилцан хамтран ашиглах боломжийг бүрдүүлэх (мэдээллийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх)
- Цугларсан мэдээллийг ил тод болгохдоо мэдээллийн үр өгөөжтэй байдлыг хангахад мөн анхаарч, ил тод болгож буй цахим өгөгдлийг нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр түгээх, дахин ашиглах, боловсруулалт хийх, хооронд нь харьцуулах, тэдгээрт дүн шинжилгээ хийх, автомат мэдээллийн систем болон хиймэл оюун ухаан зэргийг ашиглан ил болгосон мэдээлэлд бүхэлд нь дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх (жишээлбэл зөвхөн сканердсан зураг, PDF файл хэлбэрээр бус машин таньж унших боловсруулалт хийх боломжтой, мэдээллийн төрөл, ангилал тус бүрээр ялгамжтай байдлаар байдлаар түгээх г.м), мэдээллийн төвлөрсөн цахим санг бий болгож ажиллуулах, мэдээллийг тогтмол цаг алдалгүй шинэчлэх, төрийн байгууллагуудын мэдээллийн сантай харилцан уялдааг хангах, тэдгээртэй автоматаар мэдээлэл солилцох зэрэг боломж нөхцөлийг цогцлоох.

-оОо-

Хавсралт 1. Ашигласан материал

- [Уул уурхайн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалтын монгол улсын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө судалгааны тайлан \(2024\)](#). Санхүү эдийн засгийн их сургууль
- [EITI Requirements](#)
- [EITI Guide to implementing the EITI Standard](#)
[Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага ба үнэлгээний аргачлал \(2018\)](#). Байгаль орчин, аялал жуулчлалын яам, UNDP
- [Эдийн засгийн аюулгүй байдал \(2020\)](#). Монгол Улсын Үндэсний статистикийн хороо
- [Дотоодын нийт бүтээгдэхүүн – 2024 оны эхний хагас жилийн танилцуулга \(урьдчилсан гүйцэтгэл\)](#). Монгол Улсын Үндэсний статистикийн хороо
- [Макро эдийн засгийн сарын мэдээ \(2024 оны 3 дугаар сар\)](#). Эдийн засаг, хөгжлийн яам
- [Монгол Улсын уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчин бусад орны татварын орчны харьцуулсан судалгаа](#)
- [Монголын уул уурхайн салбарын авилгын эрсдлийн үнэлгээ \(2016\)](#). Уул уурхайн яам, Авлигатай тэмцэх газар
- [Монголын уул уурхайн төслийн шийдвэр гаргах процессын авлигын эрсдэлийн зохицуулалтын үнэлгээ \(2023\)](#)
- [Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын баталгаажуулалт \(2010\)](#)
- [Монгол улсын гэрээний ил тод байдлын нөхцөл байдлын судалгаа \(2024\)](#)
- [Mongolia Seventeenth EITI Reconciliation Report 2022](#)
- [Mongolia EITI 2023 Annual Report](#)
- [Validation of Mongolia \(2022\): Final assessment of progress in implementing the EITI Standard](#)
- [Хариуцлагатай уул уурхай. Сургалтын гарын авлага](#)
- [Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлого](#)
- [Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга. Тайлан 2018](#)
- [Монгол улсын үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийн дүн шинжилгээ \(2022\)](#)
- [Газрын хэвлийн баялаг ашиглахтай холбоотой засгийн газар ба орон нутгийн чиг үүргийн хуваарилалт \(2024\)](#)
- [Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн хэрэгцээ, шаардлага урьдчилсан тандан судалгааны тайлан \(2020\)](#)
- [Supporting Good Governance of Extractive Industries in Politically Hostile Settings: Rethinking Approaches and Strategies](#)

- [Transparent Governance in Times of Uncertainty. Best Practices and Strategic Proposals for the Extractive Industries \(2019\)](#)
- [A Theory of Change for the Extractive Industries Transparency Initiative Designing resource governance pathways to improve developmental outcomes](#)
- [Getting the most out of extractive industries transparency: How a more explicit treatment of political considerations could strengthen the impact of transparency efforts](#)
- [Oil, Gas, and Mining : A Sourcebook for Understanding the Extractive Industries](#)
- [Legislating for effective beneficial ownership transparency reforms in the extractive sector](#)
- [How does implementing the Extractive Industries Transparency Initiative \(EITI\) affect economic growth? Evidence from developing countries](#)
- [Монгол Улсын олборлох салбарын төрийн өмчит компаниудын ил тайлагналын нөхцөл байдлын судалгаа](#)
-

Хавсралт 2. Байгалийн баялгийн ашиглалтын ил тод байдалтай хамаарал бүхий хууль тогтоомжуудийн холбогдох зохицуулалтууд

Монгол Улсад хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжууд дахь байгалийн баялгийг ашиглалтын ил тод байдлыг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг доорх хүснэгтэд харуулав.

Эрх зүйн актын нэр, дугаар батлагдсн огноо	Зохицуулалт
Ашигт малтмалын тухай хууль, 2006	9.1.Ашигт малтмалын асуудлаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 9.1.11.геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хайгуулын болон энэ хуулийн 24.1-т зааснаас бусад тохиолдолд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох талбайг солбицлоор тогтоож, нийтэд мэдээлэх; 10.1.Ашигт малтмалын асуудлаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.18.үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, геологи, уул уурхайн салбарын төрийн бус байгууллагатай хамтран ашигт малтмалын баялаг, ордын нөөц, хайгуулын ажлын үр дүнг нийтэд нээлттэй тайлагнах журмыг батлах. 11.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид энэ хуульд "төрийн захиргааны байгууллага" гэх) дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: 11.1.22.сонирхсон этгээдэд тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлтэй танилцах бололцоо олгох, эдгээр бүртгэлд орсон өөрчлөлтийн талаар зохих байгууллагад мэдэгдэж нийтэд мэдээлэх. 12.2.Ашигт малтмалын асуудлаар сумын Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 12.2.2.харьяалах нутаг дэвсгэрт эрдэс баялгийн салбарын талаар хэрэгжиж байгаа шийдвэрийн талаар жил бүр олон нийтэд мэдээлэх 16.4.Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны мэдээлэл төрийн мэдээллийн сангийн үндсэн бүрэлдэхүүн бөгөөд нийтэд нээлттэй байна. 17.4.Энэ хуулийн 10.1.20-д заасан хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайд сонгон шалгаруулалт явуулахаас

	30-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ. 20.1.[Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох] Сонгон шалгаруулалтын үнийн саналыг үнэлэхэд дараах зарчмыг баримтална: 20.1.1.сонгон шалгаруулалтын үнийн саналыг үнэлэхдээ бүртгэл хаагдсан өдрийн дараагийн ажлын өдрөөс эхлэн үнэлгээг нээлттэйгээр нийтэд мэдээлэх; 20.2.3.сонгон шалгаруулалтын комиссын гишүүдийн баталгаажуулсан техникийн саналын оноог үнэлгээ хийж дууссанаас хойш ажлын гурван өдрийн дотор оролцогчдод мэдэгдэж, нэгтгэсэн дүнг нээлттэй мэдээлэх. 20.8.Төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон даруйд энэ тухай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, татварын албанд мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ. 22.3.Төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгамагц энэ тухай татварын албанд мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ. 26.7.Төрийн захиргааны байгууллага ашиглалтын тусгай зөвшөөрөл болон үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгосноос хойш ажлын 7 өдөрт багтаан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг даргад энэ тухай тус тус мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ. 28.3.Төрийн захиргааны байгууллага ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан тухай шийдвэрийг түүнийг гарснаас хойш ажлын 7 өдөрт багтаан энэ хуулийн 26.7-д заасан байгууллагуудад мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ. 42.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана. 42.4.Нутгийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан энэ хуулийн 42.1-д заасан гэрээг олон нийтэд нээлттэй, ил тод байлгана. 47.14.Экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний үндэслэл болгох олон улсын жишиг үнэ тогтоодог биржийн,
--	--

	зах зээлийн үнийн эх сурвалжийн нэрийг тухайн бүтээгдэхүүний нэр төрлийг харгалзан Засгийн газар нийтэд зарлана. 48.10.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг дараа оны 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ. 48.14.Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 47³дугаар зүйлд заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланг энэ хуулийн 48.9-т заасны дагуу татварын албанд тушааж 48.10-т заасны дагуу холбогдох мэдээллийг нийтэд мэдээлнэ. 49.11.Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл шилжүүлснийг бүртгэсэн талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ. 50.2.Талбайн тодорхой хэсгийг энэ хуулийн 50.1-д заасны дагуу шилжүүлснийг мөн хуулийн 49.6.1-д заасны дагуу төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ. 50.5.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 50.2-т заасан бүртгэлийг дараахь журмаар гүйцэтгэнэ: 50.6.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 50.5-д заасны дагуу бүртгэл хийсэн тухайгаа мөн хуулийн 49.11-д заасан байгууллагуудад мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ. 54.5.Төрийн захиргааны байгууллага нь тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь буцаан авсан тухай зохих байгууллагад мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ. 55.6.Төрийн захиргааны байгууллага тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн тодорхой хэсгийг буцаан авсан тухай зохих байгууллагад мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ. 56.7.Төрийн захиргааны байгууллага хайгуулын, ашиглалтын болон үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрлийг цуцалсан бол татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж өдөр тутмын сонинд нийтэлнэ. 57.1.Сонирхсон этгээд тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлтэй ажлын цагаар зориулалтын байранд танилцах эрхтэй. 57.2.Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боловсруулсан хайгуулын тайлан, уурхайн ашиглалтын мэдээ, техник, эдийн засгийн үндэслэлийг
--	---

	түүний хүсэлтээр тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаанд нууцад хамааруулах бөгөөд мэдээ, тайланг хүлээлгэн өгөхдөө нууц хадгалах талаар гэрээ байгуулж болно. 57.3.Энэ хуулийн 57.2-т заасны дагуу нууцад хамааруулсан мэдээллийг Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан үндэслэл, журмаас гадуур задруулах, нийтлэх буюу нийтэд мэдээлэхийг хориглоно. 57.4.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан, байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлж болзошгүй химийн хорт болон бусад бодисын хэрэглээний талаархи мэдээллийг байгаль орчны болон геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нийтэд нээлттэй болгож, тухайн мэдээллийг цахим хэлбэрээр түгээнэ.
Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995	4 дүгээр зүйл.Байгаль орчныг хамгаалах талаархи иргэний эрх, үүрэг 1.Иргэн байгаль орчныг хамгаалах талаар дараахь эрхийг эдэлнэ: 4/холбогдох байгууллагаас байгаль орчны тухай үнэн, зөв мэдээлэл авах; 5 дугаар зүйл.Байгаль орчныг хамгаалах талаархи төрийн чиг үүрэг, зарчим 2.Төр нь байгаль орчныг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараахь зарчим баримтална: 4/байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах шийдвэр, үйл ажиллагаа ил тод байх. 10 дугаар зүйл.Байгаль орчны төлөв байдлын хяналт-шинжилгээ 1.Байгаль орчны төлөв байдлын хяналт-шинжилгээнд байгаль орчны төлөв байдал, түүний хувьсал өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа, шинжилгээ хийж дүгнэлт гаргах, илэрсэн сөрөг өөрчлөлтийг зогсоох, арилгах арга хэмжээ боловсруулах үйл ажиллагаа хамаарна. 3.Хяналт-шинжилгээний сүлжээгээр дараахь ажлыг хэрэгжүүлнэ: 2/байгаль орчин, түүний баялгийн талаар хүн ам, сонирхогч аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээллээр хангах; 33 дугаар зүйл.Мэдээллийн сангийн хэлбэр 4.Хуульд өөрөөр заагаагүй бол [байгаль орчны] мэдээллийн сан олон нийтэд нээлттэй байна. 35 дугаар зүйл.Мэдээллийн сангийн бүрдэл 1.Улсын мэдээллийн сан дараахь зүйлийн талаархи мэдээллээс бүрдэнэ: 1/газар, түүний хөрс;

	2/газрын хэвлий, ашигт малтмал; 3/ус, рашаан; 4/ой; 5/байгалийн ургамал; 6/амьтан; 7/агаар, түүний бохирдол; 8/уур амьсгал; 9/байгалийн гамшиг; 10/химийн хорт болон аюултай бодис; 11/хог хаягдал; 12/тусгай хамгаалалттай газар нутаг; 13/байгаль орчны эрх зүй; 14/байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ; 15/байгаль орчны бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт; 16/байгаль орчны статистик мэдээлэл, тайлан; 17/байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардал; 18/байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, хүний нөөц; 19/мета мэдээллийн сан; 20/байгаль орчны талаархи бусад мэдээлэл. 21/байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн мэдээлэл; 22/байгаль орчны холбогдолтой гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл. 23/генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн сан. 2.Аймаг, нийслэлийн мэдээллийн сан энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-7, 9-12, 14-18, 20-д заасан зүйлийн талаархи мэдээллээс бүрдэнэ. 3.Сум, дүүргийн мэдээллийн сан энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-6, 9-12, 14, 15, 17, 18, 20-д заасан зүйлийн талаархи мэдээллээс бүрдэнэ. 38 дугаар зүйл.Мэдээллийн сангийн үйл ажиллагааг хангах байгууллага 1.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээллийн сангийн үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулна. 2.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгаль орчны мэдээллийн төв байх бөгөөд уг төв нь улсын мэдээллийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн үйлчилгээний байгууллага байна. 41 дүгээр зүйл.Мэдээллийн санг хэрэглэгчийн эрх, үүрэг 1.Мэдээллийн сангийн хэрэглэгч дараахь эрх, үүрэгтэй: 1/мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээллийг ашиглан эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, лавлагааны мэдээлэл бэлтгэх болон бусад хэлбэрээр ашиглахдаа мэдээлэл эзэмшигчийн нэрийг ишлэл болгох; 2/мэдээллийн сангийн үйл ажиллагаа болон өгөгдөл, мэдээллийн талаар гомдол гаргах. 44 дүгээр зүйл.Мэдээллийн сангийн санхүүжилт, төлбөрийн нөхцөл
--	---

	1.Мэдээллийн сан төрийн өмч байх бөгөөд түүний үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ. 2.Мэдээллийн сангийн мэдээлэл нь төлбөртэй болон төлбөргүй байна. Төлбөргүй болон нийтэд зориулсан мэдээллийн жагсаалтыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 3.Иргэн, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр цуглуулж бүрдүүлсэн өгөгдөл, мэдээллийн тухай мета мэдээллийг улсын санд төлбөргүй өгөх үүрэгтэй. 4.Байгаль орчны мэдээллийн төв энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан иргэн, хуулийн этгээдээс шаардлагатай мэдээллийг худалдан авч болно. 5.Иргэн, байгууллага, хуулийн этгээд нь улсын төсөв, шинжлэх ухаан, технологийн сан, олон улсын болон гадаадын зээл, тусламжийн хүрээнд бүрдүүлсэн байгаль орчны өгөгдөл, мэдээллийг улсын мэдээллийн санд үнэ төлбөргүй төвлөрүүлэх үүрэгтэй. 6.Мэдээллийн сангийн сургалт, танин мэдэхүй, эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахтай холбоотой нийтэд зориулсан мэдээллийг иргэн, хуулийн этгээд төлбөргүй ашиглах эрхтэй. 7.Энэ зүйлд заасан төлбөртэй мэдээллийн орлогын 50 хүртэл хувийг мэдээллийн санг шинэчлэх, үйлчилгээний хүрээг нэмэгдүүлэх, түүний хүчин чадлыг сайжруулахад зарцуулна.
Хөрөнгө оруулалтын тухай	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах талаар тодорхой зохицуулалт байхгүй
Цөмийн энергийн тухай, 2009	11.1.Цөмийн энергийн комисс дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 11.1.6.ураны баяжмал, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийн онцлогийг харгалзан түүний хүчин чадал, тоо хэмжээ, шилжилт хөдөлгөөн, тээвэрлэлтийн холбогдолтой нууцлах мэдээллийн жагсаалтыг баталж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах; 11².2.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 15.2.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боловсруулсан хайгуулын тайлан, техник, эдийн засгийн үндэслэл, энэ хуулийн 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боловсруулсан уурхайн ашиглалтын мэдээ, техник, эдийн засгийн үндэслэлийг түүний хүсэлтээр тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаанд нууцад хамааруулна. 11².3.Энэ хуулийн 11².2-т заасны дагуу нууцад хамааруулсан мэдээллийг Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан үндэслэл, журмаас гадуур задруулах, нийтлэх буюу нийтэд мэдээлэхийг хориглоно. 16.1.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу

	байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, тус улсад татвар төлөгч компанид олгож болно. 16.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь ерөнхий шаардлагыг биелүүлнэ: 16.3.3.үйл ажиллагаа нь ил тод, тогтвортой байх; 22.6.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан шийдвэрийг ажлын 5 өдөрт багтаан энэ хуулийн 19.8-д заасан байгууллага болон олон нийтэд мэдээлнэ. 26.7.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэрийг ажлын 5 өдөрт багтаан энэ хуулийн 19.8-д заасан байгууллага болон олон нийтэд мэдээлнэ.
Газрын тосны тухай, 2014	8.1.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид "төрийн захиргааны төв байгууллага" гэх/ газрын тосны асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 8.1.4.хайгуулын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах; 10.1.Аймгийн Засаг дарга газрын тосны асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.5.харьяалах нутаг дэвсгэрт газрын тосны салбарын талаар хэрэгжиж байгаа шийдвэрийг жил бүр олон нийтэд мэдээлэх; 10.2.Сумын Засаг дарга газрын тосны асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.2.4.харьяалах нутаг дэвсгэрт газрын тосны салбарын талаар хэрэгжиж байгаа шийдвэрийг жил бүр олон нийтэд мэдээлэх; 11.2.Гэрээлэгч дараах үүрэг хүлээнэ: 11.2.6.хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгах; 11.2.16.үйл ажиллагааны тайлан, хөрөнгө оруулалт, өмчлөлтэй холбоотой аливаа мэдээллийг Засгийн газрын хүсэлтээр гарган өгөх; 19.2.Төрийн захиргааны байгууллага хайгуулын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж байгаа талаарх мэдээллийг өөрийн цахим хуудас болон өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гурваас доошгүй удаа зарлана. 20.3.Төрийн захиргааны байгууллага хайгуулын талбайн захиалга хүлээн авсан эсэх талаар ажлын таван өдрийн дотор захиалагчид бичгээр, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

	36.1.Гэрээлэгч нь тухайн жилд оруулсан хөрөнгө оруулалт, гаргасан зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан төлбөр, урамшуулал, үйлчилгээний хөлсний хэмжээг дараа оны нэгдүгээр улиралд багтаан холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ. 36.2.Гэрээлэгч нь тусгай зөвшөөрөлтэй талбайд хийгдэж байгаа газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, тайлагнана.
Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, 2012	4 дүгээр зүйл.Төлбөр төлөгч, түүнийг бүртгэх 4.1.Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгч нь Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд байна. 4.3.Сум, дүүргийн Засаг дарга, орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагчийн томилсон албан тушаалтан байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх мэдээллийг зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 10 хоногийн дотор зохих шатны татварын албанд гаргаж өгөх бөгөөд татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэнэ. 4.4.Энэ хуулийн 4.3-т заасан мэдээлэлд иргэний нэр, иргэний бүртгэлийн дугаар, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, байршил, ашиглах хугацаа, хэмжээ, тоног төхөөрөмжийн хүчин чадал зэрэг шаардлагатай үзүүлэлтийг тусгана.
Усны тухай хууль, 2012	7 дугаар зүйл.Усны мэдээллийн сан, тоо бүртгэл 7.1.Улсын усны мэдээллийн сан нь гадаргын болон газрын доорх ус, рашааны төлөв байдал, орон зайн үзүүлэлт, усны нөөцийн нийт болон ашиглах боломжит хэмжээ, чанар, өөрчлөлт, хяналт-шинжилгээний дүн мэдээ, ус ашиглалт, хаягдал ус зайлуулахтай холбогдсон мэдээ, экологи-эдийн засгийн үнэлгээ, ус хэрэглэгч, ашиглагчийн тухай мэдээлэл, хайгуул, судалгааны тайлан, усны барилга байгууламжийн байршил, хүчин чадал, техникийн үзүүлэлт зэрэг мэдээллээс бүрдэнэ. 17.1.Сав газрын захиргаа нь усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг тухайн сав газартаа хэрэгжүүлнэ: 17.1.5.сав газрын усны мэдээллийн дэд санг эрхэлж, олон нийтийг мэдээллээр хангах; 18.1.Аймаг, нийслэлийн байгаль орчны алба нь усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 18.1.4.ус ашиглагчид сав газрын захиргааны шийдвэр, энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулах, усны мэдээллийн санд бүртгэх;

Ойн тухай хууль, 2012	6 дугаар зүйл.Ойн мэдээллийн сангийн тогтолцоо, журам 6.1.Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ойн төлөв байдал, ойн сангийн эзлэх талбайн хэмжээ, нөөц, бүрэлдэхүүн, үнэлгээ, тэдгээрийн өөрчлөлт, ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний талаарх цогц мэдээллийг агуулсан улсын хэмжээний ойн мэдээллийн сантай байна. 6.2.Энэ хуулийн 6.1-д заасан мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 6.3.Энэ хуулийн 6.1-д заасан мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн долдугаар бүлэгт заасны дагуу зохицуулна. 20.1.Иргэн ойг хамгаалах талаар дараах эрх эдэлнэ: 20.1.3.холбогдох байгууллагаас ойн нөөц, түүний хамгаалалт, ашиглалтын талаар үнэн, зөв мэдээлэл авах; 38 дугаар зүйл.Ойн дагалт баялаг, түүнийг ашиглах горим 38.1.Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн дагалт баялгийн нөөц ашиглах эрхийн бичгийг тухайн ойн анги /байхгүй бол тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч/ олгоно.
Амьтны тухай, 2012	29¹ дүгээр зүйл.Дуудлага худалдаа зохион байгуулах 29¹.1.Энэ хуулийн 20.2-т заасан ховор амьд амьтны цуглуулга хийх тусгай зөвшөөрөл, 25.1-д заасан тусгай болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлд заасны дагуу дуудлага худалдааны журмаар олгоно. 29¹.2.Энэ хуулийн 29¹.1-д заасан зөвшөөрлийн дуудлага худалдааг мөн хуулийн 26.3-т заасны дагуу Засгийн газраас тусгай зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг баталсан шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор олон нийтэд нээлттэй мэдээлж, 30 хоногийн дотор цахим хэлбэрээр зохион байгуулна. 31 дүгээр зүйл.Амьтны мэдээллийн сан 31.1.Амьтны мэдээллийн сан дараах мэдээллээс бүрдэнэ: 31.1.1.амьтны тархац нутаг, нөөц, түүний үнэлгээ; 31.1.2.амьтны судалгааны тайлан, мэдээ баримт; 31.1.3.амьтны цуглуулга, лабораторид хадгалсан үр хөврөл; 31.1.4.амьтан хамгаалах, өсгөн үржүүлэх, ашиглах арга хэмжээний мэдээ; 31.1.5.агнуурын амьтны тархац, нягтаршлыг аймаг, нийслэлээр харуулсан зураг. 31.2.Амьтны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.
Байгалийн ургамлын тухай 1995	5 дугаар зүйл.Ургамлын нөөцийн мэдээллийн сан 1.Ургамлын нөөцийн мэдээллийн сан дараахь үзүүлэлтээс бүрдэнэ:

	1/ургамлын тархац, нөөцийн хэмжээ, түүний үнэлгээ; 2/ургамлын хатаамал, бэлдмэл, үрийн цуглуулга; 3/ургамлын судалгааны тайлан, мэдээ баримт; 4/ургамлын хяналт-шинжилгээний ажиглалт, хэмжилтийн мэдээ баримт; 5/ургамал хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний мэдээ. 2.Ургамлын мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна. 6 дугаар зүйл.Ургамал ашигласны төлбөр 1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага төрийн өмчийн газар дахь ургамлыг ашиглахдаа хууль тогтоомжид заасны дагуу төлбөр төлнө. 2.Ургамал ашигласны төлбөрийн дээд, доод хэмжээ, төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх журмыг хуулиар тогтооно.
Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, 2014	34.5.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах мэдээ, тайланг доор дурдсан хугацаанд аймаг, нийслэлийн Засаг даргад ирүүлнэ: 34.5.3.тухайн жилийн үйл ажиллагааны тайлан, маркшейдерийн хэмжилтээр тогтоогдож батлагдсан уулын ажлын үндсэн үзүүлэлт болон график зургийг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор батлагдсан маягтын дагуу. 34.7.Энэ хуулийн 34.5.3-т заасан тайланд доор дурдсан зүйлийг тусгана: 34.7.1.ажилласан өдөр, ажиллагчийн тоо, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмчлөлтэй холбоотой гэрээ, хэлцэл; 34.7.2.уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл, нөөцийн хөдөлгөөний тооцоо, уурхай ажилласан хугацаа, үйлдвэрлэлийн дамжлагын схем, өргөтгөл, шинэтгэлийн ажил; 34.7.3.олборлосон, үйлдвэрлэсэн, ачуулсан, борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, борлуулсан үнэ, түүнийг худалдан авагчийн тухай мэдээлэл, тухайн жилд оруулсан хөрөнгө оруулалт, ашиглалтын зардал, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлсөн болон ашиглаж байгаа тоног төхөөрөмж, бусад хөрөнгийн тухай мэдээ. 34.10.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг дараа оны 01 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ. 38.1.Сонирхсон этгээд тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлтэй ажлын цагаар зориулалтын байранд танилцах эрхтэй. 38.3.Энэ хуулийн 38.2-т заасны дагуу нууцад хамааруулсан мэдээллийг Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан үндэслэл, журмаас гадуур задруулах, нийтлэх буюу нийтэд мэдээлэхийг хориглоно.

Монгол Улсын засаг захиргааны нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	Уул уурхай олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах талаар тодорхой зохицуулалт байхгүй
Төсвийн тухай хууль	5.1.Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.4.ил тод байдлыг хангасан байх; 6.5.Энэ хуулийн 5.1.4-т заасан төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.5.1.төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх; 6.5.2.төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах; 6.5.3.төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах;
Авлигын эсрэг хууль	3.1.6."авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа" гэж авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, тэдгээрийг арилгах, авлигыг таслан зогсооход чиглэгдсэн арга хэмжээний цогцолборыг; 6.1.Төрийн байгууллага энэ хуулийн 3.1.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр дараахь нийтлэг үүрэг хүлээнэ: 6.1.2.тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох, сонирхогч нийгмийн бүлгүүдэд өөрийн бодлого, байр суурийг танилцуулах, хяналтын тодорхой аргыг дэвшүүлэн хэрэгжүүлэх бололцоо олгох зорилгоор харилцан зөвлөлдөж ажиллах боломжийг бүрдүүлэх; 6.1.5.тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод байлгаж, түүнтэй танилцах боломжоор хангах; 6.1.10.төрийн байгууллагаас гаргасан шийдвэр иргэд болон бусад сонирхогч талуудад ойлгомжтой, нээлттэй байх;
Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	8.1.Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана.

	8.5.Мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана: 8.5.2.зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа. 8.6.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана: 8.6.7.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьд нэгдсэн төсөв болон Үндэсний баялгийн санд оруулж байгаа татвар, хөрөнгийн хэмжээ; 8.6.9.хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагавар, тэдгээрийг арилгах арга хэмжээг тогтоосон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаарх мэдээлэл, газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн мэдээлэл; 8.6.10.мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл; 8.6.13.Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ; 13.1.Хүн, хуулийн этгээд мэдээллийг хүсэлт гаргаж, эсхүл цахим хэлбэрээр, нээлттэй, ил тод байршуулсан мэдээллийг хүсэлт гаргалгүйгээр тухайн цахим хуудсанд хандаж авч болно. 13.2.Нээлттэй мэдээлэл авах бол хүсэлтийг амаар, эсхүл бичгээр, эсхүл цахим хэлбэрээр, хязгаарлалттай мэдээлэл авах бол хүсэлтийг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргана.
Зөвшөөрлийн тухай, 2022	1.5 дугаар зүйл.Зөвшөөрөл олгох, сунгах, шинээр бий болгоход баримтлах зарчим, хэрэгжүүлэх хүрээ 1.Эрх бүхий этгээд зөвшөөрөл олгох, сунгах болон зөвшөөрөлтэй холбогдох бусад харилцаанд доор дурдсан зарчмыг баримтална: 1.3.ил тод, шударга байх; 3.2 дугаар зүйл.Эрх бүхий этгээдийн бүрэн эрх 2.Эрх бүхий этгээд дараах үүрэг хүлээнэ: ... 2.5.энэ зүйлийн 2.4-т заасан шийдвэрийг зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд тухайн шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор бүртгүүлэх;

	2.6.зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийг зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулах, тухайн шийдвэрийг хүртээмжтэй хэлбэрээр нийтэд мэдээлэх; ... 2.9.зөвшөөрөл хүссэн өргөдөл, түүнд хавсаргах баримт бичгийн жагсаалт болон өргөдөл хүлээн авах этгээд, түүний хаяг, байршлын талаарх мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр нийтэд мэдээлэх. 7.2 дугаар зүйл.Зөвшөөрлийн лавлагаа, мэдээлэл 1.Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой хүсэлт гаргасан этгээд, түүний бүрдүүлсэн баримт бичиг болон зөвшөөрөл олгох, бүртгэх, хяналт тавих эрх бүхий этгээдийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл нээлттэй, ил тод байна. 2.Зөвшөөрөл эзэмшигчтэй холбоотой мэдээлэл хуульд заасны дагуу тухайн этгээдийн нууцад хамаарахаар бол түүнтэй холбоотой лавлагааг зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлийн үндсэн дээр олгоно.
--	---